



USAID
FROM THE AMERICAN PEOPLE



BEST
Business Excellence for Sustainability and Transparency



**ХӨГЖЛИЙН
ШИЙДЭЛ**

МОНГОЛ УЛСЫН ЖИЖИГ, ДУНД БИЗНЕСИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГАА

Тайлан

Монгол Улс
2024 он

АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID)-аар дамжуулан Америкийн ард түмний өгөөмөр тусламжаар энэхүү судалгааг гүйцэтгэх боломжтой болсон. Судалгааны агуулга, тайлан дүгнэлт нь АНУ-ын Засгийн газар эсвэл USAID-ын байр суурийг илэрхийлэхгүй болно.

Зохиогчийн эрх ©Хөгжлийн Шийдэл ТББ

Анхны хэвлэл 2024

Судалгааны тайлан нь Монгол Улсын Зохиогчийн эрхийн тухай хуулийн дагуу зохиогчийн эрхээр хамгаалагдсан болно. Доор өгүүлсэн зааврын дагуу эх сурвалжийг нь дурдан иш татаж болно. Дахин хэвлэх, орчуулах зэрэг эрх авах тохиолдолд Хөгжлийн Шийдэл ТББ-ын contact@dsmongolia.org цахим хаягаар хүсэлт илгэж хандана уу.

Энэхүү судалгааны тайланг мөн www.dsmongolia.org вэбсайтаас авах боломжтой

ISBN: 978-9919-0-2241-9 (хэвлэмэл)

ISBN: 978-9919-0-2242-6 (веб PDF)

Монгол хэл дээрх эшлэл: Хөгжлийн Шийдэл (2024). Монгол Улсын Жижиг Дунд Бизнес (ЖДБ)-ийн Өрсөлдөх Чадварын Судалгаа

Энэхүү судалгаа нь Олон Улсын Худалдааны Төв (ОУХТ)-ийн ЖДБ-ийн өрсөлдөх чадварын матрицан аргачлалыг ашиглан Монгол Улс дахь ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг тодорхойлсон ба тус байгууллагаас зөвлөсний дагуу холбогдох тайлан мэдээнээс иш татан ашигласан болно. Мөн тус судалгаанд багтсан мэдээлэл, үр дүнгүүд нь АНУ-ын Засгийн газар, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг, Хөгжлийн Шийдэл ТББ-ын байр суурь, үзэл баримтлалыг илэрхийлэхгүй болно.

Хөгжлийн Шийдэл ТББ

“Бизнесийн Тогтвортой Хөгжлийг Сайжруулах, Ил Тод Байдлыг Нэмэгдүүлэх” BEST хөтөлбөр

Жамъяан гүний гудамж, Downtown оффис, 501 тоот

Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот

Утас: +976 77222210; 95195331

Цахим шуудан: contact@dsmongolia.org

Вэб хуудас: www.dsmongolia.org

Facebook: <https://www.facebook.com/BESTprogramMN/>

АГУУЛГА

Товчилсон үгсийн жагсаалт	1
Өмнөх үг	
Талархал	
Оршил	1
1. Судалгааны аргазүй	3
1.1. ОУХТ-ийн ЖДБ-ийн өрсөлдөх чадварын аргачлал	3
1.2. Мэдээлэл цуглуулалт	8
1.3. Шинжилгээний хүрээ	13
2. ЖДБ-ийн өрсөлдөх чадварын нэгдсэн үзүүлэлтүүд	15
3. Компанийн чадавх	18
3.1. Компанийн өрсөлдөх чадвар	18
3.1.1. Үйлдвэрлэлийн үр ашгийн өрсөлдөх чадвар	19
3.1.2. Нөөцийн менежментийн өрсөлдөх чадвар	23
3.1.3. Чанарын удирдлагын өрсөлдөх чадвар	25
3.2. Компанийн холбогдох чадвар	26
3.2.1. Хэрэглэгчтэй холбогдох чадвар	29
3.2.2. Ханган нийлүүлэгчтэй холбогдох чадвар	31
3.2.3. Институтүүдтэй холбогдох чадвар	31
3.3. Компанийн өөрчлөгдөх чадвар	32
3.3.1. Бизнес төлөвлөлт ба санхүүгийн боломжид хүрэх чадвар	33
3.3.2. Ур чадвартай хүний нөөц бүрдүүлэх чадвар	37
3.3.3. Инновац ашиглах, хөгжүүлэх чадвар	39
4. Бизнесийн экосистем	41
4.1. ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг дэмжих бизнесийн экосистемийн үнэлгээ	42
4.1.1. Үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх экосистем	43
4.1.2. Нөөцийн менежментийг хангах экосистем	45
4.1.3. Чанарын удирдлагыг нэвтрүүлэх экосистем	48
4.2. ЖДБ-ийн холбогдох чадварыг дэмжих бизнесийн орчны үнэлгээ	50
4.2.1. Хэрэглэгчтэйгээ холбогдох экосистем	51
4.2.2. Ханган нийлүүлэгчтэй холбогдох экосистем	52
4.2.3. Институтүүдтэй холбогдох экосистем	53
4.3. ЖДБ-ийн өөрчлөгдөх чадварыг дэмжих бизнесийн орчны үнэлгээ	53
4.3.1. Санхүүжилт авах боломж, экосистем	54
4.3.2. Ур чадвартай ажиллах хүч олох, ажиллуулах боломж, экосистем	55
4.3.3. Инновац нэвтрүүлэх боломж, экосистем	55
5. Макро орчин	57
5.1. Эдийн засгийн гол үзүүлэлтүүд	57
5.2. Эдийн засгийн хэтийн төлөв	58
5.3. Багана ба индикаторын үнэлгээ	59
6. Өрсөлдөх чадварын баганын бүрэлдэхүүний шинжилгээ	62
6.1. Өрсөлдөх чадвар	62
6.2. Холбогдох чадвар	65
6.3. Өөрчлөгдөх чадвар	67
7. Бодлогын оновчлолын шинжилгээ	70
8. Дүгнэлт	77
Ашигласан материал	83
Хавсралтууд	84

ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	ЖДБ-ийн өрсөлдөх чадварын матриц.....	6
Зураг 2.	ЖДБ-ийн өрсөлдөх чадварын дунджилсан индекс ба нэг хүнд ноогдох ДНБ-ий хамаарал....	7
Зураг 3.	Өрсөлдөх чадварын харьцуулах түвшин	8
Зураг 4.	Датаны чанарын хяналтын төрөл болон хянасан хувь	10
Зураг 5.	Шинжилгээний хүрээний тойм зураглал	14
Зураг 6.	Компанийн чадавхын үнэлгээний харьцуулалт, бизнесийн хэмжээгээр, үндсэн үзүүлэлтийн түвшинд.....	17
Зураг 7.	Компани, бизнесийн экосистем, макро орчны харьцуулалт, үндсэн үзүүлэлтийн түвшинд ...	17
Зураг 8.	Компанийн чадавхын нийт индикаторуудын нормчилсон оноо	18
Зураг 9.	ЖДБ-ийн хөдөлмөрийн бүтээмжийн тархалт, хэвийн тархалтын хамтаар	21
Зураг 10.	ЖДБ-ийн хөдөлмөрийн бүтээмж, бизнесийн хэмжээгээр.....	21
Зураг 11.	ЖДБ-ийн мэдээллийн сувгууд.....	28
Зураг 12.	ЖДБ-ийн хэрэглэгчийн мэдээлэл бүрдүүлэлтийн тогтолцоо	28
Зураг 13.	ЖДБ-ийн борлуулалт, маркетингийн сувгууд.....	28
Зураг 14.	Бизнес төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүд (n=369).....	34
Зураг 15.	Бизнес төлөвлөгөөний хугацаа (n=369)	34
Зураг 16.	Бизнесийн экосистемийн нийт индикаторуудын нормчилсон оноо.....	41
Зураг 17.	Дотоодын зах зээлд бараа нийлүүлэхээр тээвэрлэхэд гардаг эвдрэлийн зэрэг, ЖДБ-ийн үйл ажиллагааны чиглэлээр, хувиар.....	46
Зураг 18.	Дотоодын зах зээлд бараа нийлүүлэхээр тээвэрлэхэд гардаг эвдрэлийн зэрэг, ЖДБ-ийн байршлаар, хувиар	46
Зураг 19.	Экспортын гаалийн бүрдүүлэлтийн үр ашиг, бизнесийн хэмжээгээр, хувиар	47
Зураг 20.	Экспортын гаалийн бүрдүүлэлтийн үр ашиг, салбараар, давхардсан тоогоор, хувиар ..	47
Зураг 21.	Импортын гаалийн бүрдүүлэлтийн үр ашиг, бизнесийн хэмжээгээр, хувиар.....	48
Зураг 22.	Импортын гаалийн бүрдүүлэлтийн үр ашиг, салбараар, давхардсан тоогоор, хувиар ...	48
Зураг 23.	Дотоодын тохирлын гэрчилгээний талаар мэдээлэл авах боломж, ЖДБ-ийн үйл ажиллагаа явуулсан жилээр, хувиар.....	50
Зураг 24.	Олон улсын гэрчилгээжүүлэлтийн талаар мэдээлэл авах боломж, ЖДБ-ийн үйл ажиллагаа явуулсан жилээр, хувиар.....	50
Зураг 25.	Хамгийн өндөр үнэлгээтэй үзүүлэлт ба анхны оноо, 10%, 15%, 20%-ийн өсөлтийн дараах онооны зөрүү	72
Зураг 26.	Бичил бизнесийн 20%-ийн өсөлт ба жижиг бизнесийн анхны онооны харьцуулалт.....	73
Зураг 27.	Жижиг бизнесийн 15%-ийн өсөлт ба дунд бизнесийн анхны онооны харьцуулалт	73
Зураг 28.	Хамгийн өндөр үнэлгээтэй үзүүлэлт ба анхны оноо, 10%, 15%, 20%-ийн өсөлтийн дараах онооны зөрүү	75
Хүснэгт 1.	Түүвэр судалгааны шалгуур үзүүлэлт ба тэдгээрийн биелэлт.....	9
Хүснэгт 2.	Мэдээлэл цуглуулалтын явцад гарсан хүндрэлүүд ба шийдвэрлэсэн аргууд	10
Хүснэгт 3.	Түүврийн хуваарилалт	11
Хүснэгт 4.	Судалгаанд хамрагдсан ЖДБ-үүдийн гол үзүүлэлтүүд.....	12
Хүснэгт 5.	ЖДБ-ийн өрсөлдөх чадварын матрицын хураангуй	15
Хүснэгт 6.	ЖДБ-ийн өрсөлдөх чадварын матрицын хураангуй, үндсэн үзүүлэлтийн түвшинд.....	16
Хүснэгт 7.	Өрсөлдөх чадвар баганын индикаторуудын нормчилсон оноо, ЖДБ-ийн шинж байдлаар..	19
Хүснэгт 8.	ЖДБ-ийн үйл ажиллагааны үр ашиг, хувиар.....	20
Хүснэгт 9.	ЖДБ-ийн зардлын үр ашиг, хувиар	22

Хүснэгт 10. ЖДБ-ийн цаг хугацааны үр ашиг, хувиар.....	23
Хүснэгт 11. ЖДБ-ийн нөөцийн менежмент, хувиар.....	24
Хүснэгт 12. ЖДБ-ийн чанарын хяналт, стандарт хувиар.....	25
Хүснэгт 13. Холбогдох чадвар баганын индикаторуудын нормчилсон оноо, ЖДБ-ийн шинж байдлаар.....	26
Хүснэгт 14. Хэрэглэгчтэй холбогдох чадвар, хувиар.....	29
Хүснэгт 15. Ханган нийлүүлэгч талын индикаторууд, хувиар.....	30
Хүснэгт 16. Гишүүнчлэл, гишүүнчлэлийн үнэлгээний индикаторууд, хувиар.....	32
Хүснэгт 17. Өөрчлөгдөх чадвар баганын индикаторуудын нормчилсон оноо, ЖДБ-ийн шинж байдлаар.....	32
Хүснэгт 18. ЖДБ-ийн санхүүгийн боломжит эх үүсвэр, хувиар.....	36
Хүснэгт 19. ЖДБ-ийн санхүүгийн тайлагналт ба баталгаажуулалт, хувиар.....	37
Хүснэгт 20. ЖДБ-ийн үр чадвартай хүний нөөц, хувиар.....	38
Хүснэгт 21. ЖДБ-ийн үр чадвартай хүний нөөцийг бүрдүүлэх, хувиар.....	39
Хүснэгт 22. ЖДБ-ийн инновац ашиглалт, хувиар.....	40
Хүснэгт 23. ЖДБ-ийн инновац хөгжүүлэлт, хувиар.....	40
Хүснэгт 24. Өрсөлдөх чадварын экосистемийн индикаторуудын нормчилсон оноо, ЖДБ-ийн шинж байдлаар.....	42
Хүснэгт 25. Холбогдох чадварын экосистемийн индикаторуудын нормчилсон оноо, ЖДБ-ийн шинж байдлаар.....	51
Хүснэгт 26. Өрсөлдөх чадварын экосистемийн индикаторуудын нормчилсон оноо, ЖДБ-ийн шинж байдлаар.....	54
Хүснэгт 27. Монгол Улсын эдийн засгийн гол үзүүлэлтүүд.....	57
Хүснэгт 28. Монгол Улсын эдийн засгийн хэтийн төлөв.....	58
Хүснэгт 29. Макро орчин (Нормчилсон оноо).....	60
Хүснэгт 30. Өрсөлдөх чадварын багана: Компани, бизнесийн экосистем, макро орчны уялдаа..	62
Хүснэгт 31. Холбогдох чадварын багана: Компани, бизнесийн экосистем, макро орчны уялдаа..	66
Хүснэгт 32. Өөрчлөгдөх чадварын багана: Компани, бизнесийн экосистем, макро орчны уялдаа..	69
Хүснэгт 33. Компанийн чадавхыг 10%, 15%, 20%-иар өсгөхөд шаардагдах нэмэлт нөөцийн хуваарилалт.....	70
Хүснэгт 34. Бичил ба жижиг бизнесийн өрсөлдөх чадавхыг харгалзан 20% ба 15%-иар өсгөхөд шаардагдах нэмэлт нөөцийн хуваарилалт.....	72
Хүснэгт 35. Бизнесийн экосистемийг 10%, 15%, 20%-иар өсгөхөд шаардагдах нэмэлт нөөцийн хуваарилалт.....	74
Хүснэгт 36. Компани ба бизнесийн экосистемийн түвшинд сайжруулах шаардлагатай үндсэн үзүүлэлтүүд ба индикаторууд.....	76

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуйн нэгж байгууллага
АХБ	Азийн Хөгжлийн Банк
ДБ	Дэлхийн Банк
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖДБ	Жижиг, дунд бизнес
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэрлэл
МУ	Монгол Улс
МХТ	Мэдээлэл харилцааны технологи
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОУВС	Олон Улсын Валютын сан
ОУХТ	Олон Улсын Худалдааны Төв
УИХ	Улсын Их Хурал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо

ӨМНӨХ ҮГ

Хөгжлийн Шийдэл ТББ нь АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID)-ийн санхүүжилтээр “Жижиг Дунд Бизнесийн Тогтвортой Хөгжлийг Сайжруулах, Ил Тод Байдлыг Нэмэгдүүлэх” (BEST) хөтөлбөрийг 2019 оны 12-р сараас эхлэн 5 жилийн хугацаанд хэрэгжүүлж байгаа бөгөөд жижиг, дунд бизнес (ЖДБ)-ийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлж, эдийн засгийн сайн засаглал, хариуцлага, ил тод байдлыг сайжруулах замаар Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэн өсгөхөд чиглэж ажиллаж байна. BEST хөтөлбөр нь Улаанбаатар болон Баянхонгор, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Завхан, Орхон, Сэлэнгэ, Ховд, Өвөрхангай, Хөвсгөл, Өмнөговь, Хэнтий гэсэн 12 аймгуудад хэрэгжиж байна.

BEST хөтөлбөрийн хүрээнд жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ)-ийн салбарт тулгамдаж буй сорилтуудыг тодорхойлох, мэдээллийн тэгш бус байдлыг арилгаж салбарын өсөлт, хөгжлийг дэмжих бодлого, хөтөлбөр боловсруулахад мэдээлэл өгөх, ЖДБ-ийн чиг хандлага, боломжуудыг тодорхойлоход чиглэсэн судалгаа, шинжилгээ хийж гүйцэтгэдэг. Энэ хүрээнд өнгөрсөн 4 жилийн хугацаанд хөтөлбөр хэрэгжиж буй 13 салбар болон үндэсний хэмжээнд 8,000 гаруй бизнес эрхлэгчдийн төлөөллийг хамруулсан 13 төрлийн судалгаа хийж гүйцэтгээд байна.

Эдгээр судалгаа, шинжилгээгээр дамжуулан бодлого боловсруулагчид, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллүүд, бизнес эрхлэгчдэд тоон үр дүнд суурилсан шийдвэр гаргах боломж олгоод зогсохгүй ЖДҮ-д чиглэсэн бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулахад дэмжлэг үзүүлэхийг Хөгжлийн Шийдэл ТББ-ын зүгээс зорин ажиллаж байна.

Жижиг, дунд бизнес нь хөгжиж буй орнуудын эдийн засгийн хөгжилд онцгой үүргийг гүйцэтгэдэг. Дэлхий банкны мэдээлснээр дэлхий хэмжээнд ЖДБ нийт бизнесийн 90 орчим хувийг, ажил эрхлэлтийн 50 гаруй хувийг бүрдүүлж байна. Түүнчлэн албан ёсны бүртгэлтэй ЖДБ хөгжиж буй орнуудын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий 40 хүртэлх хувийг бүрдүүлж байна. Иймд ЖДБ-ийн салбарыг хөгжүүлэх нь ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулахад онцгой хувь нэмэр оруулдаг тул олон орон ЖДБ-ийн хөгжлийг тэргүүлэх чиглэлээ болгосон байдаг. Монгол Улсын хувьд 2021 оны байдлаар үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийн 66.1% нь жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид байна. Тэд ДНБ-ий 5.5%-ийг бүрдүүлж, нийт барааны экспортын 2.4%, импортын 9.7%-ийг гүйцэтгэжээ. ЖДБ-ийн гадаад худалдааны оролцоо жилээс жилд буурах хандлагатай байгааг ҮСХ тэмдэглэсэн байна.

Монгол Улсын хувьд ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг үнэлэх аргачлалын дагуу үнэлэх, компанийн түвшний өрсөлдөх чадавх болон бизнесийн экосистемийн орчны судалгааны үр дүнг тодорхойлох хэрэгцээ шаардлага үүсэж буй цаг үед Хөгжлийн Шийдэл ТББ-аас санаачлан IRIM судалгааны хүрээлэнтэй хамтран “Жижиг, дунд бизнесийн өрсөлдөх чадвар”-ын судалгааг 2023 оны 7-р сараас 10-р сарын хугацаанд амжилттай хийж дууслаа.

Олон Улсын Худалдааны Төв (ОУХТ)-ийн ЖДБ-ийн өрсөлдөх чадварын матрицан аргачлалыг ашиглан Монгол Улс дахь ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг компанийн чадавх, бизнесийн экосистем, макро орчин гэсэн гурван түвшинд тодорхойлсон. Энэ аргачлал нь компанийн чадавхыг өрсөлдөх чадвар, холбогдох чадвар, өөрчлөгдөх чадвар гэсэн гурван түлгүүр хүчин зүйлээр үнэлж, эдийн засгийн гурван түвшний (микро, месо, макро) хувьд авч үзэн ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг тодорхойлсон.

Энэхүү судалгаагаар ЖДБ-ийн өрсөлдөх чадвар, түүний орчны нөхцөл байдлыг цогцоор нь тодорхойлж, цаашдын хэрэгцээ шаардлагыг үнэн зөв оновчлох боломж бүрдэж байгаа бөгөөд бидний зүгээс энэхүү судалгааны үр дүнг хувийн сектор, бизнесийн орчныг дэмжих зорилго бүхий төрийн ба төрийн бус байгууллага, олон улсын байгууллагад танилцуулах, цаашид бодлогын шийдэлд ашиглах зорилготой байна.

Та бүхэн судалгааны үр дүн, зөвлөмжтэй танилцаж, цаашид засаж сайжруулах, хөгжүүлэх, дэлгэрүүлэн судлах санал зөвлөмжөө бидэнд илгээвэл бид дараа дараагийн судалгааны ажилдаа тусган ажиллах болно. Энэхүү судалгаа нь Монгол Улсын ЖДБ-ийн өрсөлдөх чадвар, түүний орчин нөхцөлийг цогцоор нь судалсан анхны ажил гэдгээрээ онцлог бөгөөд цаашид засаж сайжруулах, хөгжүүлэх олон зүйлс байгаа тул та бүхний санал, зөвлөмж үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

Хөгжлийн Шийдэл ТББ-ын зүгээс ЖДБ-ийн өрсөлдөх чадварын судалгааг тодорхой хугацааны давтамжтайгаар панел судалгаа болгон судлах, МУ-ын ЖДБ-ийн хөгжил, дэвшилд судалгаа, шинжилгээний үр дүнд суурилсан бодлого төлөвлөлт, шийдвэр гаргах соёлыг түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмэр оруулахаар зорин ажиллаж байна. Та бүхэн ЖДҮ салбарт чиглэн хийгдсэн бусад олон судалгааны тайланг манай байгууллагын www.dsmongolia.org вэбсайтаар нэвтрэн танилцана уу. Бид хамтдаа МУ-ын ЖДБ-ийн хөгжилд өөр өөрсдийн үйл ажиллагаагаараа дамжуулан хувь нэмрээ оруулж чадна гэдэгт итгэж байна.

Батцоожийн Гангис

Хөгжлийн Шийдэл ТББ-ын Гүйцэтгэх захирал

ТАЛАРХАЛ

АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID)-ийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Бизнесийн Тогтвортой Хөгжлийг Сайжруулах, Ил Тод Байдлыг Нэмэгдүүлэх” (BEST) хөтөлбөрийн хүрээнд Хөгжлийн Шийдэл ТББ, IRIM судалгааны хүрээлэн хамтран “Монгол Улсын жижиг дунд бизнесийн өрсөлдөх чадварын судалгаа” амжилттай хийгдэж дуулаа.

Энэхүү судалгааг АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагаар дамжуулан Америкийн ард түмний өгөөмөр тусламжаар гүйцэтгэх боломжтой болсонд гүнээ талархал илэрхийлье.

Судалгааны ажлын хүрээг тодорхойлох болон судалгаа хийх үйл явцыг зохион байгуулах бүхий л үе шатанд чиглүүлэг өгч, санал солилцон, нягт хамтран ажилласан Хөгжлийн Шийдэл ТББ-ын мониторинг үнэлгээний ахлах ажилтан Ж.Пүрэвдуламд, мөн судалгааны тайланг хянан сайжруулахад хувь нэмэр оруулан ажилласан Хөгжлийн Шийдэл ТББ-ын мониторинг үнэлгээний ажилтан Г.Итгэмжит, О.Баасанжав нарт талархал илэрхийлж байна.

Судалгааны мэдээлэл цуглуулалтад дэмжлэг үзүүлж, шаардлагатай мэдээ мэдээллээр хангаж, туслалцаа үзүүлсэн 21 аймаг, 9 дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийн газрын мэргэжилтнүүдэд, BEST хөтөлбөр хэрэгжиж буй 12 аймгийн салбарын зөвлөхүүдэд хамтран ажилласанд баярлалаа.

Судалгааны баг

Судалгааны багийн ахлагч:

Доржнямбуугийн Бямбасүрэн IRIM судалгааны хүрээлэнгийн зөвлөх

Судалгаа гүйцэтгэсэн баг:

Дэлгэрсамбуугийн Мөнхцэцэг IRIM судалгааны хүрээлэнгийн зөвлөх

Даашинхүүгийн Гансүлд IRIM судалгааны хүрээлэнгийн зөвлөх

Нямсүрэнгийн Янжинпагма IRIM судалгааны хүрээлэнгийн ахлах судлаач

Пүрэвдоржийн Цэдэн-Иш IRIM судалгааны хүрээлэнгийн зохицуулагч

Болдын Болор IRIM судалгааны хүрээлэнгийн дата менежер

Баяраагийн Хонгор IRIM судалгааны хүрээлэнгийн дата судлаач

Баянбатын Шинэцэцэг IRIM судалгааны хүрээлэнгийн менежер

Төмөрхүүгийн Бямбацэрэн IRIM судалгааны хүрээлэнгийн чанарын хяналтын менежер

ОРШИЛ

Жижиг, дунд бизнес (ЖДБ) нь хөгжиж буй орнуудын эдийн засгийн хөгжилд онцгой үүргийг гүйцэтгэдэг. Дэлхий банкны мэдээлснээр¹ дэлхий хэмжээнд ЖДБ нийт бизнесийн 90 орчим хувийг, ажил эрхлэлтийн 50 гаруй хувийг бүрдүүлж байна. Түүнчлэн албан ёсны бүртгэлтэй ЖДБ хөгжиж буй орнуудын дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) 40 хүртэлх хувийг бүрдүүлж байна. Иймд ЖДБ-ийн салбарыг хөгжүүлэх нь ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулахад онцгой хувь нэмэр оруулдаг тул олон орон ЖДБ-ийн хөгжлийг тэргүүлэх чиглэлээ болгосон байдаг. Монгол Улсын хувьд 2021 оны байдлаар үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийн 66.1%² нь жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид байна. Тэд ДНБ-ий 5.5%-ийг бүрдүүлж, нийт барааны экспортын 2.4%, импортын 9.7%-ийг гүйцэтгэжээ. ЖДБ-ийн гадаад худалдааны оролцоо жилээс жилд буурах хандлагатай байгааг ҮСХ тэмдэглэсэн байна (ҮСХ, 2021).

ЖДБ эрхлэхэд макро эдийн засгийн байдал, нийгэм, хууль эрх зүйн хэрэгжилт, дэд бүтэц болон санхүүжилттэй холбоотой асуудлууд хүндрэл учруулсаар байгааг өмнө хийгдсэн зарим судалгаануудад дурдсан байна. Тухайлбал, Монгол банк (2018) нийгэм, улс төрийн тогтворгүй байдал, төрийн байгууллагын үйлчилгээний хүнд суртал, татварын орчин, хээл хахууль, санхүүжилтийн орчин, хүний нөөцийн хомсдол зэрэг нь ЖДБ-ийн хөгжилд гол хүндрэлийг үзүүлж байна гэжээ. Иймд ЖДБ-ийн өрсөлдөх чадвар ямар хэмжээнд байгааг компанийн хувьд тодорхойлохоос гадна ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг дэмжих бизнесийн болон макро орчин хэрхэн бүрдсэнийг нарийвчлан тогтоох зайлшгүй шаардлага байна. Ингэснээр ЖДБ-ийн өрсөлдөх чадвар, түүний орчны нөхцөл байдлыг цогцоор нь тодорхойлж, цаашдын хэрэгцээ шаардлагыг үнэн зөв оновчлох боломж бүрдэнэ.

Энэ хүрээнд уг судалгаа нь Энэ аргачлал нь компанийн чадавхыг *өрсөлдөх чадвар, холбогдох чадвар, өөрчлөгдөх чадвар* гэсэн гурван түлгүүр хүчин зүйлээр үнэлж, эдийн засгийн гурван түвшний (микро, мисо, макро) хувьд авч үзэн ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг тодорхойлсон. Энэхүү судалгаа нь ЖДБ-ийн өрсөлдөх чадвар, түүний орчин нөхцөлийг цогцоор нь судалсан анхны ажил гэдгээрээ онцлог юм. Тус судалгааны үр дүнг хувийн сектор, бизнесийн орчныг дэмжих зорилго бүхий төрийн ба төрийн бус байгууллага, олон улсын байгууллагад танилцуулах, цаашид бодлогын шийдэл болгон ашиглах боломжтой.

Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймагт үйл ажиллагаа явуулж буй, албан ёсны бүртгэлтэй 703 ЖДБ-ээс судалгааны мэдээллийг биечлэн болон утсаар цуглууллаа. Судалгаанд хамрагдсан ЖДБ-ийг орлогоор нь ангилан үзвэл 57.9% нь бичил, 23.5%

1. Дэлхийн банк, Жижиг, дунд бизнесийн санхүү, Эх сурвалж: <https://www.worldbank.org/en/topic/sme/finance#:~:text=They%20represent%20about%2090%25%20of,when%20informal%20SMEs%20are%20included>.

2. Мэдээллийн эх сурвалж: ҮСХ-ны Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ ба Бизнес регистрийн мэдээллийн сан

нь жижиг, 18.6% нь дунд хэмжээтэй байна. Байршлын тухайд 69.8% нь Улаанбаатар хотоос, 30.2% нь орон нутгаас хамрагджээ. Эдийн засгийн салбарын хувьд 35.2% нь үйлчилгээний салбарт, 22.3% нь бөөний болон жижиглэнгийн салбарт, 12.3% нь боловсруулах салбарт, 10.8% нь барилгын салбарт, 10.1% нь хөдөө аж ахуйн салбарт, үлдсэн 9 орчим хувь нь бусад салбарт үйл ажиллагаагаа явуулж байна. Эндээс дүгнэхэд судалгаанд хамрагдсан ЖДБ-ийн талаас дээш хувь нь бичил, нэмүү өртөг багатай худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж байна. Энэхүү дүр зураг нь МУ-ын ЖДБ-ийн ерөнхий нөхцөл байдалтай нийцэхийн сацуу өмнөх судалгаануудын түүвэрлэлтийн³ шинж байдалтай нийцэж байна.

Судалгааны ажил нь үндсэн зургаан бүлгээс бүрдэх бөгөөд нэгдүгээр бүлэгт судалгааны аргачлал, мэдээлэл цуглуулалт, судалгааны шинжилгээний хүрээний талаар дэлгэрэнгүй тусгасан. Хоёрдугаар бүлэгт ОУХТ-ийн ЖДБ-ийн өрсөлдөх чадварын матрицын үзүүлэлтүүдийг нэгтгэн үзүүллээ. Гуравдугаар бүлэгт *компанийн чадавх* бүрэлдэхүүний үр дүнг, дөрөвдүгээр бүлэгт *бизнесийн экосистем* бүрэлдэхүүний үр дүнг, тавдугаар бүлэгт макро орчин бүрэлдэхүүний үр дүнг тус тусад нь авч үзсэн. Ингэхдээ бүрэлдэхүүн бүрийн хувьд тулгуур хүчин зүйлс, тэдгээрт харгалзах индикаторуудыг нарийвчлан тодорхойллоо. Зургаадугаар бүлэгт эдийн засгийн гурван түвшний үялдаа холбоог тодорхойлох зорилгоор өрсөлдөх чадварын гурван тулгуур хүчин зүйл бүрийн хувьд компани, бизнесийн экосистем, макро орчныг харьцуулан авч үзлээ. Ингэснээр ЖДБ-ийн өрсөлдөх чадварт компанийн чадавхаас гадна бизнесийн экосистем, макро орчин хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох боломж бүрдэнэ. Түүнчлэн бодлогын оновчлолын шинжилгээг пеналти ботэлник (penalty for bottleneck)⁴ аргаар үнэлж, индикаторуудын оновчтой түвшнийг тооцож, холбогдох зөвлөмжийг гаргалаа. Эцэст нь судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэв.

3. MEARC (2021), Монгол банк (2018)

4. Acs et al (2011)

1. СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ

Уг судалгаанд ОУХТ-ийн ЖДБ-ийн өрсөлдөх чадварын матрицан үнэлгээ ашигласан бөгөөд харгалзах индикаторуудыг МУ-ын ЖДБ-ийн нөхцөлд нийцүүлэн шинэчилсэн. Энэ хэсэгт эхлээд ОУХТ-ийн ЖДБ-ийн өрсөлдөх чадварын аргачлалын суурь ойлголт болох ЖДБ-ийн өрсөлдөх чадварын тодорхойлолт, өрсөлдөх чадварын матриц, түүнийг тооцох аргазүйг авч үзнэ. Хоёрдугаарт, судалгааны мэдээлэл цуглуулалтын талаар авч үзнэ. Судалгааны мэдээллийг анхдагч ба хоёрдогч эх үүсвэрээс цуглуулсан бөгөөд мэдээлэл цуглуулалтын аргыг товч танилцуулна. Эцэст нь, судалгааны шинжилгээг ямар хүрээнд хийх талаар авч үзнэ.

1.1. ОУХТ-ИЙН ЖДБ-ИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН АРГАЧЛАЛ

ЖДБ-ийн өрсөлдөх чадварын тодорхойлолт

Өрсөлдөх чадварын ялгаатай хандлага, үзэл баримтлалаас үүдэн өрсөлдөх чадварыг олон янзаар тодорхойлсон байдаг. Түүнчлэн өрсөлдөх чадварын утга тухайн нөхцөл байдлаас хамааран өөрчлөгддөг учраас үүнийг тодорхойлох нь хялбар биш. ОУХТ бизнесийн өрсөлдөх чадварыг тодорхойлохдоо бараа үйлчилгээг төлөвлөх шатнаас зах зээлд гаргах хүртэлх цогц үйл ажиллагааг авч үздэг бөгөөд дараах байдлаар тодорхойлсон:

“Өрсөлдөх чадвар гэдэг нь зорилтот зах зээлийн сегментүүдийн хэрэгцээг бүрэн, дахин давтагдахгүйгээр, тасралтгүй хангах тэрхүү санааг боловсруулах, үйлдвэрлэх, арилжаалах чадвараа харуулах явдал юм. Түүнчлэн бизнесийн орчинтой холбогдох, нөөцөө татах, ашигласан нөөцийнхөө тогтвортой үр өгөөжийг бий болгох үйл явц юм” (ИТС, 2015, хуу.109).

ОУХТ-ийн уг тодорхойлолт нь ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг бусад тодорхойлолтуудтай (UNESCAP, 2009) тэр дундаа өрсөлдөх чадварын динамик талуудын үүргийг онцолсон тодорхойлолттой илүү нийцэж байна. ОУХТ-ийн өрсөлдөх чадварын үзэл баримтлалыг илүү ойлгомжтой болгох үүднээс тодорхойлолтыг бүрэлдэхүүн хэсгүүдээр задлан авч үзье.

- **“санааг боловсруулах, үйлдвэрлэх, арилжаалах чадвараа харуулах явдал”** Энэ нь аливаа компани өрсөлдөх чадвартай байхын тулд зах зээлд бараа, үйлчилгээгээ гаргасан туршлагатай байх шаардлагатайг харуулж байна. Уг туршлага нь төлөвлөлт (дизайн гаргах), үйлдвэрлэл, худалдаа зэрэг үйл ажиллагааны бүхий л үе шатыг хамарна. Эдгээр нь компанийн түвшний хүчин зүйлс бөгөөд энэхүү тодорхойлолтын нийлүүлэлтийн талыг илэрхийлнэ.
- **“зорилтот зах зээлийн сегментүүдийн хэрэгцээг бүрэн, дахин давтагдахгүйгээр, тасралтгүй хангах”** Энэ нь компани хэрэглэгчдийнхээ хэрэгцээг дахин давтагдахгүйгээр, бүрэн гүйцэд хангах чадварыг илэрхийлнэ. Энэ нь компани

эрэлт бүхий бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байгааг баталгаажуулах бөгөөд тодорхойлолтын эрэлтийн талыг илэрхийлдэг. Мөн тодорхойлолтын энэ хэсэг компаниуд хэрэглэгчдийнхээ хэрэгцээг ойлгох, зах зээлийн ялгаатай сегментүүдийн үйл ажиллагааг ойлгох нь чухал гэдгийг тэмдэглэн харуулж байна.

- **“ашигласан нөөцийнхөө тогтвортой үр өгөөжийг бий болгох үйл явц”** Энэ хэсэг нь өрсөлдөх чадварын динамик байдлыг (цаг хугацааны хэмжүүр) илэрхийлнэ. Ашигласан нөөцөөс зохих өгөөжийг олж авахад хангалттай байгаа ч ирээдүйд өрсөлдөөний орчин өөрчлөгдөхөд хангалтгүй болж болзошгүй юм. Иймд компани нөөцөө тогтвортой ашиглаж, бизнесийнхээ бүхий л салбарт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, хөгжихөд бэлэн байгаа тохиолдолд л хангалттай өгөөж хүртэнэ гэж үзнэ.

ЖДБ-ийн өрсөлдөх чадварын матриц

ОУХТ-ийн ЖДБ-ийн өрсөлдөх чадварын матриц нь ААН-ийн өрсөлдөх чадварыг гурван тулгуур хүчин зүйл болох өрсөлдөх чадвар, холбогдох чадвар, өөрчлөгдөх чадварын хувьд тодорхойлж, эдгээрт эдийн засгийн микро, мисо, макро орчин хэрхэн оролцож буйг авч үздэг хэрэгсэл юм⁵. ЖДБ-ийн өрсөлдөх чадварын матриц нь микро, мисо, макро түвшний үзүүлэлтүүдийг хослуулж, улмаар бизнесийн орчин ба макро түвшний хүчин зүйлс нь компанийн өрсөлдөх чадварт нөлөөлдөг гэдгийг хүлээн зөвшөөрч, өрсөлдөх чадварын үнэлгээнд оруулж ирснээрээ бусад ижил төрлийн нийлмэл үзүүлэлтүүдээс давуу талтай. ЖДБ-ийн өрсөлдөх чадварын матриц нь дараах үндсэн хоёр хэсэгтэй. Үүнд:

1. Эдийн засгийн түвшин:

- **Компанийн чадавх (микро түвшин)** нь ААН өөрийн хяналтад байгаа нөөцөө удирдах чадвартай эсэхийг үнэлнэ. Энэ түвшинд компани банканд данстай байх, цахим шуудан ашиглах, үйлдвэрлэлийн хүчин чадлаа бүрэн ашиглах гэх мэт шилдэг туршлагыг дагаж мөрддөг эсэхийг шалгах үзүүлэлтүүдийг багтаана.
- **Бизнесийн экосистем (мисо түвшин)** нь компанийн өрсөлдөх чадварыг бий болгоход дэмжлэг үзүүлэх нөөц, мэдлэг чадварын орчныг бүрдүүлж байдаг. Энэ түвшинд цахилгаан эрчим хүчний хүртээмж, чадварлаг ажиллах хүч, эдийн засгийн үйл ажиллагааны төвлөрөл, хамтын ажиллагаа гэх мэт компаниас үл хамаарах хэдий ч бизнесийн орчинд нь нөлөөлдөг хүчин зүйлсийг авч үзнэ.
- **Макро орчин (макро түвшин)** нь зах зээлийн үйл ажиллагааны суурь нөхцөлийг бүрдүүлдэг. Ялангуяа засгийн газрын хэрэгжүүлж буй үйл ажиллагаа ЖДБ-ийн үйл ажиллагааг хөнгөвчлөх эсэхийг тодорхойлдог. Энэ түвшинд бизнес эрхлэлт, бизнесийн үйл ажиллагааг хөнгөвчлөхтэй холбоотой бодлого, худалдааны бодлого, засаглал, дэд бүтэц, нөөцийн хангагдсан байдал зэрэг макро түвшний хүчин зүйлсийг хамруулна.

5. Олон улсын худалдааны төв (2021а, хуудас 5) Эх сурвалж: (<https://intracen.org/file/cp2021technicalannexpdf>)

2. Өрсөлдөх чадварыг хэмжих тулгуур хүчин зүйлс:

- **Өрсөлдөх чадварын багана** нь өрсөлдөх чадварын статик хэмжигдэхүүн бөгөөд ААН-ийн одоогийн үйл ажиллагаа, тэдгээрийн зардал, цаг хугацаа, чанар, тоо хэмжээний хувьд хэр үр ашигтай байгааг авч үзнэ. Түүнчлэн энэ нь бизнесийн экосистем болон макро орчинд ч хамаатай. Тухайлбал, бизнесийн орчны статик үзүүлэлт гэдэгт дэд бүтцэд нэвтрэх боломж бүрдсэн эсэх, макро орчны тухайд тарифын доогуур түвшин байгаа эсэх зэргийг хамруулна.
- **Холбогдох чадварын багана** нь мэдээлэл, мэдлэгийг цуглуулах, ашиглах чадварыг хамарна. Компанийн түвшинд энэ нь орж буй мэдээллийг (хэрэглэгчийн профайл, таашаал сонирхол, эрэлт г.м.) цуглуулахад хүчин чармайлт гаргаж байгаа эсэх, мөн компаниас гарах мэдээллийн урсгалыг (маркетинг, зар сурталчилгаа) хөнгөвчлөхөд хүчин чармайлт гаргаж байгаа эсэхээр илэрхийлэгдэнэ. Бизнесийн экосистемийн түвшинд салбарын холбоод, худалдаа аж үйлдвэрийн танхим, бусад худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих байгууллагуудтай харилцах харилцаа юм. Макро орчны түвшинд мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэд бүтцийн хүрэлцээтэй холбоотой асуудлуудыг хамаарна. Мэдээллийг цуглуулах, ашиглах нь одоо ба ирээдүйн өрсөлдөх чадварт чухал ач холбогдолтой тул энэ багана нь статик өрсөлдөх чадвар ба динамик өрсөлдөх чадварын баганын хооронд холбоос болдог.
- **Өөрчлөгдөх чадварын багана** нь зах зээлийн динамик хүчинд компанийн зүгээс хариу үйлдэл үзүүлэх эсвэл урьдчилан таамаглах чадвар байгаа эсэх, мөн хүний болон санхүүгийн капиталд хөрөнгө оруулах замаар шинэчлэл хийх чадавх байгаа эсэхийг авч үзнэ. Энэ нь өрсөлдөх чадварын динамик хэмжигдэхүүн юм. Компани төрөл бүрийн өсөлт, бүүралтын үе шатуудтай тулгардаг бөгөөд үүнд дасан зохицох шаардлагатай байдаг. Тиймээс өөрчлөгдөх чадвар нь компаниуд санхүүгээ хэр зэрэг хүртээмжтэйгээр зохицуулж байгаа эсэх, хүн капитал, инновац, оюуны өмчийг хамгаалахад хөрөнгө оруулалт хийж байгаа эсэхийг багтаана. Бизнесийн болон макро түвшинд компаниудад эдгээр нөөцийг хүртэх орчин нөхцөл бүрдсэн эсэхээр хэмждэг.

ЖДБ-ийн өрсөлдөх чадварын матрицыг Зураг 1-д, харгалзах индикаторууд болон дэд индикаторуудыг Хавсралт 1-д тус тус харуулав. Өрсөлдөх чадварын матриц нь 9 үндсэн үзүүлэлт, 61 индикатораас бүрдэнэ.

Зураг 1. ЖДБ-ийн өрсөлдөх чадварын матриц



ЖДБ-ийн өрсөлдөх чадварын матрицын индикаторын утгыг тооцох

ЖДБ-ийн өрсөлдөх чадварын индикаторын нормчилсон утгыг тооцох. ЖДБ-ийн өрсөлдөх чадварын матрицыг өрсөлдөх чадварыг тодорхойлоход ашиглагддаг бүх индикаторын утгыг нормчилсон оноог харуулдаг. Эдгээр индикатор өрсөлдөх чадварын гурван түвшинд хуваагддаг бөгөөд түвшин бүр гурван баганад хуваагдана.

Индикаторуудыг өөр хооронд нь, эсвэл улс хооронд харьцуулалт хийхийн тулд 0-100 оноогоор нормчлох ба 100 оноо хамгийн сайн үр дүнг илэрхийлнэ. Их утгатай байх тусам илүү сайн үр дүнг илэрхийлэх эерэг индикаторын хувьд индикаторын анхны X утгыг дараах томъёогоор нормчилдог. Үүнд:

$$Y_{(+)} = 100 \frac{X - \min(X)}{\max(X) - \min(X)}$$

Их утгатай байх тусам муу үр дүнг илэрхийлэх сөрөг индикаторын хувьд индикаторын анхны X утгыг дараах томъёогоор нормчилдог. Үүнд:

$$Y_{(-)} = 100 \frac{\max(X) - X}{\max(X) - \min(X)}$$

Үүнтэй адилаар сөрөг индикаторын нормчлогдсон утгыг дараах томъёогоор үүсгэж болно. Үүнд:

$$Y_{(-)} = 100 - Y_{(+)}$$

Өрсөлдөх чадварын индикаторын харьцуулах түвшин, хүчтэй болон сул байдлыг тооцох. Өрсөлдөх чадварын индикаторын хүчтэй болон сул байдал (strength and weakness)-ыг тодорхойлоход ашиглагддаг харьцуулах түвшин нь тухайн улсын потенциалд тулгуурлана. Улс бүрийн харьцуулах түвшнийг тодорхойлохдоо ЖДБ-ийн өрсөлдөх чадварын индикаторуудыг улсаар нь дунджилж, 69 улсын түүврийг


ашиглан уг дунджилсан индикаторыг улсуудын нэг хүнд ноогдох ДНБ-ий логарифм авсан утгаас хамааруулан регресс үнэллээ (Зураг 2). Тодруулбал, энэ регрессийн хамааран хувьсагч болох ЖДБ-ийн өрсөлдөх чадварын индикаторуудын улсын дундаж утга бол бутархай хариу үйлдлийн хувьсагч бөгөөд уг регрессийг хийхэд Папке, Вулдриж нарын санал болгосон аргачлалыг ашигладаг. Тэдний аргачлал 0-100 гэсэн интервалд байх таамаглалын утгуудыг гаргаж өгдөг. 2021 оны мэдээллийг ИТС (2021b) тайлангаас авч үнэлгээг хийв. Үнэлэгдсэн регрессийн тэгшитгэл:

$$\widehat{ACI} = -32.427 + 9.265 \ln(GDPpc)$$

Энд: ACI-тухайн улсын өрсөлдөх чадварын индикаторуудын дундаж утга, GDPpc-нэг хүнд ноогдох ДНБ.

Улс бүрийн харьцуулах түвшнийг тооцохдоо дээрх үнэлэгдсэн тэгшитгэлд тухайн орны нэг хүнд ноогдох ДНБ-г орлуулж тодорхойлно. Монгол Улсын хувьд харьцуулах түвшин **44.2** гарч байна.


Зураг 2. ЖДБ-ийн өрсөлдөх чадварын дунджилсан индекс ба нэг хүнд ноогдох ДНБ-ий хамаарал



Эх сурвалж: Олон улсын худалдааны төв (2021b)-ийн мэдээлэлд үндэслэсэн судлаачийн тооцоолол

Энэхүү харьцуулах түвшинг ашиглаад индикаторын хүчтэй болон сул байдлыг тодорхойлно. Зураг 3 Хэрэв тухайн индикатор 100 гэсэн утга авах, эсвэл улсынхаа харьцуулах түвшний 160 хувийн босго утгаас хэтэрвэл тус индикаторыг хүчтэй байдалтай (ногоон өнгөөр тэмдэглэсэн) гэж үзнэ. Эсрэгээрээ, тухайн индикатор улсынхаа харьцуулах түвшний 60%-ийн босго утгаас бага байвал энэ индикаторыг сул байдалтай (улаан өнгөөр тэмдэглэсэн) гэж үзнэ. МУ-ын хувьд сул ба хүчтэй утга нь харгалзан 26.5 ба 70.7 байна.

Зураг 3. Өрсөлдөх чадварын харьцуулах түвшин



1.2. МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ

Компанийн чадавхын болон бизнесийн экосистемийн мэдээллийг түүвэр судалгаагаар, макро орчны мэдээллийг хоёрдогч эх үүсвэрээс тус тус цуглууллаа.

Түүвэр судалгааны мэдээлэл цуглуулалт

Түүврийн шалгуур үзүүлэлтүүд ба тэдгээрийн биелэлт. Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймагт үйл ажиллагаа явуулж байгаа албан бүртгэлтэй, идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 703 ЖДБ-ийг судалгаанд хамрууллаа. ЖДБ-үүдийг судалгаанд хамруулахдаа гурван шалгуур үзүүлэлтүүдийг ашигласан (Хүснэгт 1). Нэгдүгээрт, улсын бүртгэлд албан ёсны бүртгэлтэй, 2023 оны эхний хагас жилийн байдлаар идэвхтэй үйл ажиллагаагаа явуулж буй ЖДБ-ийг хамруулахыг зорьсон бөгөөд энэхүү шалгуур үзүүлэлтийг 100% хангаж ажиллаа. Хоёрдугаарт, борлуулалтын орлогод⁶ үндэслэн бичил, жижиг, дунд ангилалд багтах ААН-үүдийг тогтмол хувиар түүвэрт (харгалзан 55%, 30%, 15%) хамруулахыг зорьсон. Ингэхдээ ОУХТ-ийн ЖДБ-ийн өрсөлдөх чадварын аргачлалын тохиромжтой байдалд үндэслэн аль ч ангилалд 1-4 ажилчинтай бичил ААН-ийг хамруулаагүй. Жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих тухай хуульд заасан ангиллын дагуу 300 сая хүртэлх төгрөгийн борлуулалтын орлоготой ААН-ийг бичил, 300-999.9 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ААН-ийг жижиг, 1-2.4 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ААН-ийг дунд гэж ангилан

6. МУ-ын Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хуульд жижиг дунд үйлдвэрлэгчийг хэмжээгээр нь ангилахдаа ажилчны тоо, жилийн борлуулалтын орлогыг хамтад нь авч үздэг. Энэхүү ангиллын дагуу түүвэр судалгаа явуулахад ихээхэн хүндрэлтэй байдаг. Тухайлбал, 50-199 ажилчинтай ААН-ийг дунд ангилалд оруулна гэж уг хуульд заадаг ч бодит байдалд ийм хэмжээний ажилчинтай ЖДБ харьцангуй цөөн буюу 2021 оны байдлаар улсын хэмжээнд 160 байна. Иймд ийм хэмжээний эх олонлогоос түүвэрлэлт хийх нь учир дутагдалтай учраас ажилчдын тоог оролцуулан бизнесийн хэмжээг ангилах нь тохиромжгүй байна. Иймд энэ судалгаанд бизнесийн хэмжээг борлуулалтын орлого дээр үндэслэн авч үзэв.

авч үзлээ. Энэ шалгуур үзүүлэлтийн хувьд судалгаанд хамрагдах ЖДБ-ийн олдцоос шалтгаалан зорилтот төвшнөөс бага зэргийн зөрүүтэй мэдээллийг цуглуулсан. Ялангуяа жижиг бизнесийн нийт түүвэрт эзлэх хэмжээ төлөвлөсөн хэмжээнээс 6.5%-иар бага байна. Гэхдээ энэ нь жижиг бизнесийн төлөөлөх чадварт нөлөө үзүүлэхүйц хэмжээ биш гэдгийг тэмдэглэн хэлэх нь зүйтэй юм. Гуравдугаарт, байршлын хувьд нийт түүвэрт хамрагдсан ЖДБ-үүдийн 70% нь Улаанбаатар хотод, 30% нь орон нутагт байрлах шалгуурыг тавьсан бөгөөд энэхүү шалгуурыг 100 хувь хангаж ажиллаа.

Хүснэгт 1. Түүвэр судалгааны шалгуур үзүүлэлт ба тэдгээрийн биелэлт

Шалгуур	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Зорилтот түвшин		Бодит түвшин	
		Нийт түүвэрт эзлэх хувь			
Албан ёсны бүртгэлтэй байх	Улсын бүртгэлд албан ёсны бүртгэлтэй, идэвхтэй үйл ажиллагаагаа явуулж буй ЖДБ-ийг хамруулна.	100	100		
Бизнесийн хэмжээ	Борлуулалтын орлогод үндэслэн бичил, жижиг, дунд ангилалд багтах ААН-үүдийг хамруулна. Ингэхдээ бизнесийн аль ч ангилалд 1-4 ажилчинтай ЖДБ -ийг хамруулахгүй.	Бичил	55	Бичил	57.9
		Жижиг	30	Жижиг	23.5
		Дунд	15	Дунд	18.6
Байршил	ЖДБ-ийн үйл ажиллагаа явуулж буй байршил нь түүврийн зорилтот харьцааг хангахуйц байна.	УБ	70	УБ	69.8
		Орон нутаг	30	Орон нутаг	30.2

Түүврийн мэдээлэл цуглуулалт ба хяналт. Судалгааны мэдээллийг анх 1,000 ЖДБ эрхлэгчдээс зайнаас буюу CATI⁷ хэлбэрээр цуглуулахаар төлөвлөсөн ч мэдээлэл цуглуулалтын явцад судалгаанд оролцогчдын татгалзлын хувь өндөр байснаас мэдээлэл цуглуулалтыг биечлэн, ярилцлагын аргатай хослуулан хэрэгжүүлээ. Ярилцлагыг CAPI⁸ системд суурилан ЖДБ эрхлэгч, удирдлага, холбогдох албан тушаалтантай биечлэн уулзаж хийсэн. Түүнчлэн судалгааны шалгуур үзүүлэлтүүдийг хангах ЖДБ-ийг олоход хүндрэлтэй байсан тул захиалагчтай зөвшилцсөний дагуу нийт түүврийн тоог 700 болгож бууруулав. Нийт судалгааны 20%-ийг утсаар, 80%-ийг ярилцлагын аргаар хийж гүйцэтгэлээ. Мэдээлэл цуглуулалтын явцад үүссэн хүндрэлүүд, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэснийг доорх хүснэгтэд нэгтгэн үзүүлээ.

7. Компьютерын тусламжтай утсан судалгаа

8. Талбарын судалгаа

Хүснэгт 2. Мэдээлэл цуглуулалтын явцад гарсан хүндрэлүүд ба шийдвэрлэсэн аргууд

Асуудлын ангилал	Хүндрэлүүд	Шийдвэрлэсэн аргууд
Хүрэлцээ	<ul style="list-style-type: none"> Судалгааны үндсэн шалгуурыг хангах ЖДБ-ийг олох Орон нутгаас зорилтот түүвэрт хамрагдах бизнесийг олох (ялангуяа, жижиг, дунд хэмжээтэй ААН-ийг олох) 	<ul style="list-style-type: none"> Дүүргийн болон аймгийн ЖДҮ газрын мэргэжилтнүүдтэй хамтран ажилласан. Судалгаанд хамрагдахыг уриалсан, судалгааны ач холбогдлын таниулсан богино бичлэг хийж, сошиал медиагаар түгээсэн.
Судалгаанд оролцохоос татгалзах	<ul style="list-style-type: none"> Бизнесийн зарим мэдээлэл өгөхөөс татгалзах Судалгааны ач холбогдлыг ойлгохгүй татгалзах Цаг заваа зарцуулахыг хүсэхгүй байх, боломжгүй байх 	<ul style="list-style-type: none"> Судлаачдын тоог нэмсэн. ААН-үүдэд судалгаанд оролцохыг хүссэн мэдээллийг нэгдсэн журмаар хүргүүлсэн. Хөгжлийн Шийдэл ТББ-ын зохион байгуулж буй сургалтуудад очиж бизнес эрхлэгч нартай цаг товлосон.

Мэдээллийн чанарын хяналт: Мэдээлэл цуглуулалтын үед цугларч буй дата мэдээлэлд IRIM судалгааны хүрээлэнгийн чанарын хяналтын баг хяналт тавьж, мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг баталгаажууллаа. Ингэхдээ бөглөгдсөн анкет бүрийг агуулгын хувьд үнэн зөв бөглөгдсөн эсэхийг нягталж, нийт түүврийн 20%-д аудио бичлэгийг сонсох, 77%-д утсан хяналт хийлээ.

Зураг 4. Датаны чанарын хяналтын төрөл болон хянасан хувь



Түүвэрлэлт: МУ-д 2021 оны байдлаар үйл ажиллагаа явуулж буй 53,931 жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид байна⁹. Судалгааны түүвэрлэлтийг хийхдээ ЖДБ-үүдийн байршил, ажиллагсдын тоо, борлуулалтын орлогыг харгалзан үзэж, эх олонлогийг төлөөлөхүйц түүврийг санамсаргүй түүврийн аргаар сонгосон. Түүврийн оновчтой хэмжээг тодорхойлохдоо түүврийн харьцаа болон дунджийн хувьд 95%-ийн итгэх интервалд статистикийн хувьд найдвартай байхаар тооцон, таамаглаж байгаа алдааны хамгийн бага хязгаарыг 3.6% байхаар тооцов. Байршлын хувьд нийт түүврийн 30.2%-ийг орон нутгийн, 69.8%-ийг Улаанбаатар хотын ЖДБ эрхлэгчид эзэлж байна. Аймгуудын ЖДБ эрхлэгчдийн нийт түүвэрт эзлэх хувийн жин 1%-2.1% байгаа нь эх олонлогт эзлэх хувийн жинтэй ойролцоо, жигд тархалттай хамрагдав (Хүснэгт 3). Гэхдээ зарим аймагт шаардлага хангасан ЖДБ цөөн байсан учраас төлөвлөсөн түүврийн тоонд хүрэхгүй байх асуудлууд гарсан.

Хүснэгт 3. Түүврийн хуваарилалт

Байршил	Үйл ажиллагаа явуулж буй ЖДБ		Судалгаанд хамрагдсан ЖДБ	
	Тоо	Хувийн жин	Гүйцэтгэл	Хувийн жин
Баян-Өлгий	745	1.4	8	1.1
Говь-Алтай	459	0.9	8	1.1
Завхан	754	1.4	10	1.4
Увс	981	1.8	7	1.0
Ховд	1,016	1.9	11	1.6
Архангай	535	1.0	10	1.4
Баянхонгор	597	1.1	14	2.0
Булган	553	1.0	11	1.6
Орхон	1,469	2.7	14	2.0
Өвөрхангай	620	1.1	4	0.6
Хөвсгөл	898	1.7	14	2.0
Говьсүмбэр	157	0.3	7	1.0
Дархан-Уул	1,268	2.4	15	2.1
Дорноговь	561	1.0	4	0.6
Дундговь	324	0.6	15	2.1
Өмнөговь	1,212	2.2	15	2.1
Сэлэнгэ	1,200	2.2	8	1.1
Төв	644	1.2	15	2.1
Дорнод	815	1.5	7	1.0
Сүхбаатар	410	0.8	7	1.0
Хэнтий	630	1.2	8	1.1
Улаанбаатар	38,083	70.6	491	69.8
Нийт	53,931	100.0	703	100.0

Эх сурвалж: ҮСХ-ны Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч хуулийн этгээдийн бүртгэл, 2021 он

9. ҮСХ, Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээний статистик мэдээлэл (<https://www.1212.mn/mn/statistic/stat-cate/48171322/table/48171322>)

Судалгаанд хамрагдсан ЖДБ-ийн ерөнхий мэдээлэл. Судалгаанд хамрагдсан ЖДБ-ийн 93.2% нь компани, 6.8% нь хоршоо болон нөхөрлөлийн хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байна. Тэдний 90.9% нь дотоодын хөрөнгө оруулалттай, 9.1% нь гадаадын болон хамтарсан хөрөнгө оруулалттай бизнесүүд байна. Хүснэгт 4-д судалгаанд хамрагдсан ЖДБ-ийн гол үзүүлэлтүүдийг нэгтгэн харуулав. Нийт ЖДБ-ийн 57.9% нь жилийн 300 сая хүртэлх төгрөгийн орлоготой бичил бизнес, 23.5% нь 300-999 сая төгрөгийн орлоготой жижиг бизнес, 18.6% нь 1-2.4 тэрбум төгрөгийн орлоготой дунд бизнесүүд байна. Ажилчдын тооны тухайд 45.1% нь 5-9 ажилтантай, 39.5% нь 10-49 ажилтантай, 12.2% нь 50-199 ажилтантай бизнесүүд байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын тухайд 35.2% үйлчилгээний салбар, 22.3% нь бөөний, жижиглэн худалдаа, 12.8% нь боловсруулах үйлдвэрлэл, 10.8% нь барилга, 10.1% нь хөдөө аж ахуй, газар тариалан, үлдсэн 8.8% нь эрчим хүч, уул уурхай, тээвэр, мэдээлэл холбооны салбарын ЖДБ байна. Судалгаанд хамрагдсан ЖДБ-ийн 57.5% нь эрэгтэй удирдлагатай, 42.5% нь эмэгтэй удирдлагатай байна.

Хүснэгт 4. Судалгаанд хамрагдсан ЖДБ-үүдийн гол үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Түүврийн хэмжээ	Түүвэрт эзлэх хувь
Бизнесийн хэмжээ (борлуулалтын орлогоор)		
Бичил (300 сая хүртэлх)	407	57.9
Жижиг (300-999.9 сая)	165	23.5
Дунд (1-2.4 тэрбум)	131	18.6
Ажилчдын тоо		
5-9	317	45.1
10-49	278	39.5
50-199	86	12.2
200+	22	3.1
Байршил		
Улаанбаатар	491	69.8
Орон нутаг	212	30.2
Үйл ажиллагааны чиглэл (Олон сонголттой)		
Хөдөө аж ахуй, газар тариалан	79	10.1
Уул уурхай, олборлолт	18	2.3
Боловсруулах үйлдвэрлэл	100	12.8
Эрчим хүч, дулаан хангамж	15	1.9
Барилга	84	10.8
Бөөний болон жижиглэнгийн худалдаа	174	22.3
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	19	2.4
Мэдээлэл, холоо	17	2.2
Үйлчилгээ	275	35.2
Гүйцэтгэх удирдлагын хүйс		
Эрэгтэй	403	57.5
Эмэгтэй	299	42.5

Хоёрдогч эх үүсвэрийн мэдээлэл цуглуулалт

Макро орчны хэсэгт шаардагдах мэдээллийг албан ёсны дараах хоёрдогч эх үүсвэрүүдээс цуглууллаа. Үүнд:

- Монгол Улсын эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг олон улсад харьцуулагдах байдлыг нь харгалзан Дэлхийн банк (ДБ), Олон Улсын Валютын Сан (ОУХТ), Нэгдсэн Үндэсний байгууллага (НҮБ), Олон Улсын Валютын Сан (ОУВС)-ийн нээлттэй өгөгдлийн сангаас авч ашиглалаа.
- Макро орчны индикаторуудыг тооцоход шаардагдах мэдээллийг нээлттэй мэдээллийн өгөгдлийн сан, нээлттэй зарлагддаг индексүүд, тайлангуудаас цуглуулсан.
 - *Нээлттэй өгөгдлийн сан*: ОУХТ-ийн зах зээлийн шинжилгээний тоон мэдээлэл, ОУ-ын Харилцаа, Холбооны өгөгдлийн сан, ДБ-ны ОУ-ын санхүүгийн статистикийн өгөгдөл, ЮНЕСКО-ийн өгөгдлийн сан, Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагын өгөгдлийн сан.
 - *Индекс*: Дэлхийн банкны логистик гүйцэтгэлийн индекс, засаглалын индекс, хүртээмжтэй интернэтийн индекс
 - *Судалгааны тайлан*: ISO тайлан, НҮБ-ын цахим засгийн газар тайлан

1.3 ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭ

ОУХТ-ийн ЖДБ-ийн өрсөлдөх чадварын матрицтай уялдуулан судалгааны шинжилгээг хоёр түвшинд боловсруулав (Зураг 5).

Нэгдүгээрт, **эдийн засгийн түвшний бүрэлдэхүүнээр** өрсөлдөх чадварын гурван баганын үр дүнг нарийвчлан боловсруулна. Тодруулбал, Зураг 5-ийн босоо тэнхлэгийн дагуу, эдийн засгийн түвшний бүрэлдэхүүн (компанийн чадавх, бизнесийн экосистем, макро орчин) бүрийн хувьд ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг гурван баганаар (өрсөлдөх чадвар, холбогдох чадвар, өөрчлөгдөх чадвар) үнэлж, үр дүнг боловсруулна. Энэхүү шинжилгээнээс дараах гол үр дүнг боловсруулах зорилготой.

- ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг компани, бизнесийн экосистем, макро орчны түвшинд тодорхойлж, индикатор бүрийн сул, эсвэл хүчтэй эсэхийг үнэлж, шалтгааныг илрүүлэх

Компанийн болон бизнесийн экосистемийн түвшний индикаторуудыг **бизнесийн хэмжээ, байршил** (Улаанбаатар ба хөдөө), **эдийн засгийн салбар**¹⁰, гүйцэтгэх удирдлагын хүйс гэсэн дөрвөн үзүүлэлтээр харьцуулалтыг хийнэ. Ингэснээр бизнесийн хэмжээ, байршил, салбарын онцлогоос хамаарсан ЖДБ-ийн өрсөлдөх чадварын давуу тал, сорилтыг тодорхойлох боломжтой. Харин индикатор бүрийг


10. Шинжилгээг хялбарчлах үүднээс эдийн засгийн салбарыг худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл гэсэн ангилалд авч үзэв. Худалдааны салбарт бөөний болон жижиглэнгийн салбарыг, үйлчилгээний салбарт тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, мэдээлэл холбоо, үйлчилгээний салбарыг, үйлдвэрлэлд хөдөө аж ахуй, үүл уурхай, олборлолт, боловсруулах үйлдвэрлэл, эрчим хүч, дулаан хангамж гэсэн салбаруудыг тус тус хамрууллаа.

дэлгэрүүлж тайлбарлахдаа бизнесийн хэмжээ ба гүйцэтгэх удирдлагын хүйс гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглана.

Хоёрдугаарт, **өрсөлдөх чадварын баганын бүрэлдэхүүнээр** эдийн засгийн засгийн гурван түвшнийг харьцуулж, үр дүнг боловсруулна. Тодруулбал, Зураг 5-ийн хэвтээ тэнхлэгийн дагуу, өрсөлдөх чадварын багана (өрсөлдөх чадвар, холбогдох чадвар, өөрчлөгдөх чадвар) бүрийн хувьд эдийн засгийн түвшний бүрэлдэхүүнүүдийг (компани, бизнесийн экосистем, макро орчин) харьцуулж, тэдгээрийн уялдаа холбоог тодорхойлно. Энэхүү шинжилгээнээс дараах гол үр дүнг боловсруулах зорилготой.

- Компанийн чадавх, бизнесийн экосистем, макро орчны үзүүлэлтүүдийн аль нь ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг/холбогдох чадварыг/өөрчлөгдөх чадварыг дэмжиж, аль нь хязгаарлаж байгааг тодорхойлох

Зураг 5. Шинжилгээний хүрээний тойм зураглал



Дээрх хоёр түвшний шинжилгээний үр дүнд үндэслэн **бодлогын оновчлолын шинжилгээг** пеналти ботэлник (penalty for bottleneck) аргаар үнэлж, индикаторуудын оновчтой түвшнийг гаргаж, холбогдох зөвлөмжийг боловсруулна. Энэхүү шинжилгээнээс дараах гол үр дүнг боловсруулах зорилготой.

- ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг тодорхой хэмжээнд сайжруулахын тулд аль үзүүлэлтийг хэр хэмжээгээр нэмэгдүүлэх шаардлагатай тооцох

2. ЖДБ-ИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Энэ хэсэгт ЖДБ-ийн өрсөлдөх чадварын индикаторуудын нэгтгэлийг авч үзнэ (Хүснэгт 5). **Компанийн чадавхын** хувьд ерөнхий индекс 48.7, өрсөлдөх чадварын дундаж оноо 49.7, холбогдох чадварынх 42.9 оноо, өөрчлөгдөх чадварынх 53.3 оноо байна. Эдгээрээс холбогдох чадварын багана харьцуулах түвшнээс доогуур үнэлэгдсэн бөгөөд өрсөлдөх ба өөрчлөгдөх чадварын баганаас 7-10 орчим оноогоор доогуур үнэлэгджээ. Ялангуяа бичил бизнесийн хувьд холбогдох чадвар дутмаг байна. Иймд компанийн түвшинд холбогдох чадварыг сайжруулахад анхаарах шаардлага байна. **Бизнесийн экосистемийн** хувьд ерөнхий индекс 52.2, өрсөлдөх чадварын дундаж оноо 56.6, холбогдох чадварынх 42.9 оноо, өөрчлөгдөх чадварынх 57.0 оноо байна. Өрсөлдөх ба өөрчлөгдөх чадварын дундаж оноо харьцуулах түвшнээс дээгүүр, харин холбогдох чадварынх харьцуулах түвшнээс доогуур үнэлэгджээ. Иймд бизнесийн экосистемийн түвшинд мөн л холбогдох чадварыг сайжруулахад анхаарах шаардлага байна. **Макро орчны** хувьд ерөнхий индекс 57.9, өрсөлдөх чадварын дундаж оноо 39.2, холбогдох чадварынх 57.1 оноо, өөрчлөгдөх чадварынх 77.4 гарчээ. Өрсөлдөх чадварын баганын үнэлгээ харьцуулах түвшнээс доогуур, харин өөрчлөгдөх чадварынх хүчтэй түвшинд үнэлэгдсэн байна. Эдийн засгийн гурван түвшинд өөрчлөгдөх чадварын багана нөгөө хоёр баганаасаа өндрөөр үнэлэгдсэн байна.

Хүснэгт 5. ЖДБ-ийн өрсөлдөх чадварын матрицын хураангуй

Дундаж оноо [0-100]		Индекс	Өрсөлдөх	Холбогдох	Өөрчлөгдөх
Компанийн чадавх	Нийт	48.7	49.7	42.9	53.3
	Бичил	44.1	46.3	38.4	47.5
	Жижиг	52.1	52.6	47.0	56.8
	Дунд	58.3	56.8	51.7	66.5
Бизнесийн экосистем		52.2	56.6	42.9	57.0
Макро орчин		57.9	39.2	57.1	77.4

Харьцуулах түвшин: 44.2

Сул түвшин: ≤26.5 оноо

Хүчтэй түвшин: ≥70.7 оноо

Компанийн үндсэн үзүүлэлтийн түвшний үнэлгээг Хүснэгт 6 ба Зураг 5-д үзүүлэв. Өрсөлдөх чадварын баганаас чанарын удирдлага харьцуулах түвшнээс багаар үнэлэгджээ. ЖДБ-үүд хувьд бизнесийн хэмжээнээс үл хамааран дотоодын болон олон улсын чанарын гэрчилгээжүүлэлтэд хамрагдах нь бага байна. Харин *нөөцийн менежмент, үйлдвэрлэлийн үр ашгийн* хувьд харьцуулах түвшнээс дээгүүр үнэлэгдсэн бөгөөд дунд бизнесийн нөөцийн менежмент хүчтэй түвшинд байна. Холбогдох чадварын баганаас *хэрэглэгч, институт* гэсэн хоёр үндсэн үзүүлэлт харьцуулах түвшнээс доогуур байгаа нь холбогдох чадварын дундаж оноог

багаар үнэлэгдэхэд нөлөөлжээ. Тодруулбал, ЖДБ-үүдийн хувьд хэрэглэгчтэйгээ үр дүнтэй харилцаа үүсгэх, хэрэглэгчийн мэдээллийг ашиглахад төдийлөн хүчин чармайлт гаргаж чадахгүй байна. Ялангуяа бичил, жижиг бизнесүүдийн хувьд уг үзүүлэлт харьцуулах түвшнээс доогуур байна. Түүнчлэн бизнесийн хэмжээнээс үл хамааран бизнесээ институтийн хувьд бэхжүүлэх, салбарын холбоод, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах явдал бага байна. Өөрчлөгдөх чадварын баганын үндсэн үзүүлэлтүүд харьцуулах түвшнээс дээгүүр үнэлэгдсэн ч инновацын үнэлгээ бусад үзүүлэлтүүдээс бага буюу харьцуулах түвшнээс үл ялиг дээгүүр байна. Бичил бизнесийн хувьд инновац харьцуулах түвшнээс доогуур үнэлэгджээ. Ур чадвартай хүний нөөц дунд бизнесийн хувьд хүчтэй түвшинд үнэлэгдсэн байна.

Хүснэгт 6. ЖДБ-ийн өрсөлдөх чадварын матрицын хураангуй, үндсэн үзүүлэлтийн түвшинд

Багана	Үндсэн үзүүлэлт	Компанийн чадавх				Бизнесийн экосистем	Макро орчин
		Нийт	Бичил	Жижиг	Дунд		
Өрсөлдөх чадвар	Үйлдвэрлэлийн үр ашиг	56.4	54.9	57.7	59.9	55.2	49.3
	Нөөцийн менежмент	65.3	62.3	67.0	72.6	68.7	25.0
	Чанарын удирдлага	27.5	21.7	33.2	38	45.9	31.3
Холбогдох чадвар	Хэрэглэгч	33.9	28.2	37.9	46.4	41.0	51.3
	Нийлүүлэгч	58.8	54.0	63.6	67.8	40.2	68.9
	Институт	36.1	32.9	39.6	41.1	47.5	62.6
Өөрчлөгдөх чадвар	Бизнес төлөвлөлт ба санхүү	54.9	48.6	60.1	67.8	68.3	76.8
	Ур чадвар	59.6	54.6	61.4	72.9	53.2	85.6
	Инновац	45.3	39.4	49.0	58.7	49.5	73.7


Харьцуулах түвшин: 44.2

Сул түвшин: ≤26.5 оноо


Хүчтэй түвшин: ≥70.7 оноо

Компанийн чадавх, бизнесийн экосистем, макро орчны үндсэн үзүүлэлтүүдийн үнэлгээг Хүснэгт 6 ба Зураг 6-д үзүүлэв. Компанийн болон бизнесийн экосистемийн түвшинд үндсэн үзүүлэлтүүдийн үнэлгээ ойролцоо, харин макро орчны түвшинд өрсөлдөх чадварын үзүүлэлтүүд багаар, өөрчлөгдөх чадварын үзүүлэлтүүд өндрөөр үнэлэгдсэн дүр зураг ажиглагдаж байна. Өрсөлдөх чадварын баганаас макро түвшинд *нөөцийн менежмент сул түвшинд* үнэлэгдсэн бол *чанарын удирдлага* компани болон макро түвшинд харьцуулах түвшнээс доогуур үнэлэгджээ. Энэ нь бизнесийн экосистемийн хувьд ч харьцуулах түвшнээс үл ялиг дээгүүр байна. Холбогдох чадварын баганаас компанийн түвшинд хэрэглэгч ба институт, бизнесийн экосистемийн түвшинд хэрэглэгч ба нийлүүлэгч гэсэн үзүүлэлтүүд харьцуулах түвшнээс доогуур үнэлэгджээ. Өөрчлөгдөх чадварын баганаас гурван түвшинд харьцуулах түвшнээс доогуур үнэлэгдсэн үзүүлэлт байхгүй ч компани ба бизнесийн экосистемийн хувьд инновацын үнэлгээ харьцуулах түвшнээс үл ялиг дээгүүр үнэлэгджээ. Харин макро орчны өөрчлөгдөх чадварын үзүүлэлтүүд хүчтэй түвшинд байна.

Зураг 6. Компанийн чадавхын үнэлгээний харьцуулалт, бизнесийн хэмжээгээр, үндсэн үзүүлэлтийн түвшинд



Зураг 7. Компани, бизнесийн экосистем, макро орчны харьцуулалт, үндсэн үзүүлэлтийн түвшинд



3. КОМПАНИЙН ЧАДАВХ

Энэ хэсэгт компанийн чадавхын бүрэлдэхүүний үнэлгээг авч үзнэ. Компанийн чадавх нь нийт 21 индикатораар хэмжигдэх бөгөөд гурван чадвар тус бүр 7 индикатораар хэмжинэ. Зураг 8-д индикаторуудын үнэлгээг нэгтгэн харууллаа. Эдгээрээс 3 индикатор хүчтэй түвшинд, 12 индикатор харьцуулах түвшнээс дээгүүр, 2 индикатор харьцуулах түвшнээс доогуур, 4 индикатор сул түвшинд үнэлэгджээ. Харьцуулах түвшнээс доогуур болон сул түвшинд үнэлэгдсэн 7 индикаторын 3 сул нь холбогдох чадварынх байна. Энэ нь компанийн хувьд холбогдох чадвар өрсөлдөх ба өөрчлөгдөх чадвараас илэрхий доогуур байгааг харуулж байна. Дараагийн хэсгүүдэд компанийн чадавхын үнэлгээг багана бүрээр нарийвчлан авч үзнэ.

Зураг 8. Компанийн чадавхын нийт индикаторуудын нормчилсон оноо



3.1. КОМПАНИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАР

Энэ хэсэгт компанийн өрсөлдөх чадварын баганыг хэмжихэд ашигласан индикаторуудыг дэлгэрүүлэн авч үзнэ (Хүснэгт 7). Компанийн үйл ажиллагаа үр ашигтай байгаа эсэх, нөөцөө удирдах чадвартай эсэх, бүтээгдэхүүн, үйлчилгээндээ чанарын хяналт хийдэг эсэхийг (1) үйлдвэрлэлийн үр ашиг, (2) нөөцийн менежмент, (3) чанарын удирдлага гэсэн үндсэн үзүүлэлтүүдээр тодорхойлно.

Хүснэгт 7. Өрсөлдөх чадвар баганын индикаторуудын нормчилсон оноо, ЖДБ-ийн шинж байдлаар

	Үзүүлэлт	Нийт (N=703)	Бизнесийн хэмжээ			Салбар			Байршил		Удирдлагын хүйс	
			Бичил	Жижиг	Дунд	Худалдаа	Үйлчилгээ	Үйлдвэрлэл	Улаанбаатар	Орон нутаг	Эрэгтэй	Эмэгтэй
Үйлдвэрлэлийн үр ашиг	Үйл ажиллагааны үр ашиг	45.8	43.1	48.8	50.3	46.1	46.1	45.4	46.4	44.5	46.0	45.5
	Зардлын үр ашиг	48.7	48.6	48.0	50.0	50.1	48.8	47.6	48.4	49.4	48.5	49.0
	Цаг хугацааны үр ашиг	74.7	73.0	76.2	79.3	72.2	78.0	74.6	75.5	72.8	74.4	75.1
Нөөцийн менежмент	Орлого, зарлагын бүртгэл	76.6	72.7	80.8	83.6	79	78.2	74.9	76.8	76.2	75.7	77.9
	Банканд данс эзэмших байдал	49.7	46.3	49.7	60.3	53.7	46.4	52.1	51.1	46.5	51.1	47.8
	Мөнгөн хөрөнгийн удирдлага	69.6	67.8	70.6	73.9	68.4	71.6	68.7	70.5	67.5	69.6	69.5
Чанарын удирдлага	Чанарын хяналт, стандарт	27.5	21.7	33.2	38.0	31.0	28.2	28.0	29.1	23.6	28.4	26.2

Харьцуулах түвшин: 44.2

Индикаторын сул түвшин: ≤26.5 оноо

Индикаторын хүчтэй түвшин: ≥70.7 оноо

3.1.1. Үйлдвэрлэлийн үр ашгийн өрсөлдөх чадвар

Энэ үндсэн үзүүлэлтийн хүрээнд гурван индикатор авч үзсэнээс *үйл ажиллагааны үр ашиг*, *зардлын үр ашиг* **харьцуулах түвшнээс дээгүүр**, *цаг хугацааны үр ашиг* **хүчтэй түвшинд** үнэлэгджээ (Хүснэгт 7). *Үйл ажиллагааны үр ашиг* индикаторыг тухайн байгууллагын хүчин чадлын ашиглалт, ашигт ажиллагаа, хөдөлмөрийн бүтээмж гэсэн гурван дэд индикатораар хэмжив. *Зардлын үр ашиг* индикаторыг нэгж хөдөлмөрийн зардал ба бараа, материалын зардал хэр үр ашигтайг илэрхийлсэн хоёр дэд индикатораар хэмжив. *Цаг хугацааны үр ашиг* индикаторыг тухайн байгууллага үйлдвэрлэлийн төлөвлөгөөгөө цаг хугацаандаа биелүүлдэг эсэх, бүтээгдэхүүн, үйлчилгээгээ цаг хугацаандаа нийлүүлдэг эсэх гэсэн хоёр дэд индикатораар хэмжив (дэлгэрэнгүйг Хавсралт 1-ээс харна уу).

ЖДБ-ийн шинж байдлаар нь авч үзвэл дээрх гурван индикаторын хувьд ЖДБ-ийн шинж байдлаас хамаарсан ялгаа төдийлөн ажиглагдахгүй байна. Харин бичил,

худалдааны салбарын, орон нутгийн бизнесүүдийн хувьд цаг хугацааны үр ашиг бусад ангиллаас арай доогуур байна (Хүснэгт 7).

ЖДБ-ийн үйл ажиллагааны үр ашиг харьцуулах түвшинтэй ойролцоо (үл ялиг дээгүүр) үнэлэгдэхэд хөдөлмөрийн бүтээмжийн сул байдал гол хувь нэмэр оруулсан бол ашигт ажиллагаа тодорхой хувь нэмэр оруулжээ. Энэхүү индикаторыг үнэлэхэд гурван дэд индикаторыг ашиглаж байгаа талаар өмнө дурдсан. Нэгдүгээрт, ЖДБ-үүд үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалт хүчтэй түвшинд (75.9 оноо) үнэлэгдсэн. ЖДБ-үүд үйлдвэрлэлийн хүчин чадлынхаа 78.3%-ийг дунджаар ашиглаж байна. Судалгаанд хамрагдсан ЖДБ-ийн 45.1% нь хүчин чадлынхаа 81-100%-ийг, 30.6% нь 61-80%-ийг, 24.3% нь 60-аас доош хувийг тус тус ашигладаг байна. Түүнчлэн 28.7% нь үйлдвэрлэлийн хүчин чадлаа бүрэн (100%) ашигладаг бол 8.1% нь хүчин чадлынхаа 40-өөс доош хувийг л ашиглаж байна. Энэхүү хүчин чадлын бага ашиглалт бичил бизнесүүдэд түгээмэл байна (Хүснэгт 8). Бизнесийн хэмжээ томрох тусам үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалт өсч байна. Бичил бизнесүүд хүчин чадлынхаа 74.9%-ийг, жижиг бизнесүүд 82.6%-ийг, дунд бизнесүүд 83.1%-ийг ашиглаж байна. Салбарын хувьд мэдээлэл холбооны салбарын хүчин чадлын ашиглалт хамгийн сайн (89.1%) байгаа бол хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарын хүчин чадлын ашиглалт хамгийн бага (71.8%) байна.

Хоёрдугаарт, ЖДБ-ийн ашигт ажиллагаа харьцуулах түвшнээс доогуур (41.3 оноо) үнэлэгдсэн. Судалгаанд хамрагдсан ЖДБ-ийн 9% нь төлөвлөсөн ашгаа давуулан биелүүлсэн, 46.1% төлөвлөсөн ашгаа олсон, 23.3% төлөвлөснөөс бага ашигтай, 14.2% тэг ашигтай, 7.4% алдагдалтай ажилласан байна (Хүснэгт 8). Төлөвлөсөн ба түүнээс их ашиг олох явдал жижиг ба дунд бизнест илүү ажиглагдаж байгаа бол төлөвлөснөөс бага ашиг олох, тэг ашигтай ажиллах, алдагдалтай ажилласан явдал бичил бизнест илүү ажиглагдаж байна.


Гуравдугаарт, ЖДБ-ийн хөдөлмөрийн бүтээмж сул түвшинд (20.3 оноо) үнэлэгдсэн. Хөдөлмөрийн бүтээмжийн нэг ажилчинд ноогдох жилийн борлуулалтын орлогоор тооцов. Нэг ажилчинд ноогдох борлуулалтын орлого 2022 онд дунджаар 28.2 сая төгрөг¹¹ (Хүснэгт 8) гарсан бөгөөд нийт ЖДБ-ийн 65.7% нь дунджаас доогуур хөдөлмөрийн бүтээмжтэй байна (Зураг 8). Бизнесийн хэмжээгээр авч үзвэл бичил бизнесийн хөдөлмөрийн бүтээмж мэдэгдэхүйц бага буюу дунджаар 19.2 сая төгрөг байна. Түүнчлэн бичил бизнесийн олонх нь 19.2 сая орчим төгрөгийн хөдөлмөрийн бүтээмжтэй болохыг Зураг 9-д харуулсан боксплотоос харагдаж байна. Сонирхолтой нь жижиг бизнес дунд бизнесээс илүү хөдөлмөрийн бүтээмжтэй байна. Жижиг бизнесийн дундаж хөдөлмөрийн бүтээмж дунд бизнесээс даруй 16.1 сая төгрөгөөр илүү байна. Түүнчлэн эмэгтэй удирдлагатай бизнесийн хөдөлмөрийн бүтээмж эрэгтэй удирдлагатай бизнесээс бага зэрэг илүү байна.

11. УСХ-ны мэдээлснээр 2022 онд МУ-ын хөдөлмөрийн бүтээмж 28.2 сая төгрөгт хүрсэн байна. Үүнийг нэг ажилчинд ноогдох ДНБ-ээр тооцдог тул энэ судалгааны үр дүнтэй шууд харьцуулах нь учир дутагдалтай.


Хүснэгт 8. ЖДБ-ийн үйл ажиллагааны үр ашиг, хувиар

Үзүүлэлт	Нийт (n=703)	Бизнесийн хэмжээ			Удирдлагын хүйс	
		Бичил (n=407)	Жижиг (n=165)	Дунд (n=131)	Эрэгтэй (n=404)	Эмэгтэй (n=299)
Хүчин чадлын ашиглалт						
Дундаж хувь	78.3	74.9	82.8	83.1	78.3	78.2
40%-иас доош	8.1	10.3	4.8	4.7	7.9	8.4
41-60%	16.2	21.6	10.9	6.2	15.8	16.7
61-80%	30.6	28.0	32.1	35.2	31.4	29.4
81-100%	45.1	40.0	52.1	54.1	44.8	45.5
Ашигт ажиллагаа						
Төлөвлөсөн ашгаа давуулсан	9.0	6.1	10.3	16.7	9.2	8.7
Төлөвлөсөн ашгаа олсон	46.1	40.3	59.4	48.6	43.3	49.8
Төлөвлөснөөс бага ашиг олсон	23.3	27.8	18.2	15.4	24.3	22.1
Тэг ашигтай	14.2	17.0	7.3	13.2	13.9	14.7
Алдагдалтай	7.4	8.8	4.8	6.2	9.4	4.7
Хөдөлмөрийн бүтээмж						
Дундаж утга (сая.төг)	28.2	19.2	48.2	32.1	26.8	30.0
Хамгийн их утга (сая.төг)	156.2	120.0	133.0	156.2	135.0	156.2
Хамгийн бага утга (сая.төг)	0.04	0.36	1.0	0.04	0.04	0.05

Зураг 9. ЖДБ-ийн хөдөлмөрийн бүтээмжийн тархалт, хэвийн тархалтын хамтаар



Зураг 10. ЖДБ-ийн хөдөлмөрийн бүтээмж, бизнесийн хэмжээгээр



Иймд ЖДБ-ийн өрсөлдөх чадварын гол индикатор болох үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд нэн тэргүүнд анхаарах, цаашлаад ашигт ажиллагааг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

ЖДБ-үүдэд зардлын үр ашиг төдийлөн хангалттай биш байна. Ялангуяа цалингийн зардал нь бараа материалын зардлаас үр ашиг багатай гэжээ. Судалгаанд хамрагдсан ЖДБ-үүдийн 24.6% нь нэгж хөдөлмөрт гаргаж буй зардал нь зах зээлийн дунджаас дээгүүр, 64.9% нь зах зээлийн дундажтай ойролцоо зардал

гаргадаг гэжээ (Хүснэгт 9). Ялангуяа жижиг бизнесийн гуравны нэг (34.6%) гаруй нь зах зээлийн дунджаас илүү зардал гаргадаг байна. ЖДБ-үүдийн 26.5% нь түүхий эд, бараа, материалаа хямд/бөөний үнээр авч чаддаггүй, 44% нь заримдаа л хямд үнээр авдаг гэжээ. Иймд ихэнх ЖДБ-д түүхий эд, бараа материалаа хямд үнээр авах, зардлаа хэмнэх, үр ашигтай байхад нь тодорхой хэмжээний хүндрэл учирдаг ажээ. Ялангуяа бичил болон эмэгтэй удирдлагатай бизнесүүдэд түүхий эд, бараа материалаа хямдаар авч чаддаггүй байна.

Хүснэгт 9. ЖДБ-ийн зардлын үр ашиг, хувиар

Үзүүлэлт	Нийт (n=703)	Бизнесийн хэмжээ			Удирдлагын хүйс	
		Бичил (n=407)	Жижиг (n=165)	Дунд (n=131)	Эрэгтэй (n=404)	Эмэгтэй (n=299)
Нэгж хөдөлмөрийн үр ашиг						
Цалингийн дундаж зардал зах зээлийн дунджаас өндөр	24.6	20.7	34.6	23.8	26.2	22.4
Цалингийн дундаж зардал зах зээлийн дундажтай ойролцоо	64.9	66.3	55.8	72.8	63.1	67.2
Цалингийн дундаж зардал зах зээлийн дунджаас доогуур	10.6	13.0	9.7	3.5	10.6	10.4
Бараа материалын зардлын үр ашиг						
Түүхий эд, бараа материалаа хямд үнээр авдаг	29.6	28.2	32.1	30.9	28	31.8
Түүхий эд, бараа материалаа заримдаа хямд үнээр авдаг	44.0	40.5	43.6	54.6	47.5	39.1
Түүхий эд, бараа материалаа хямд үнээр авч чаддаггүй	26.5	31.2	24.2	14.6	24.5	29.1

ЖДБ-үүдийн олонх нь бараа, үйлчилгээгээ төлөвлөсөн цаг хугацаандаа үйлдвэрлэж, нийлүүлж байна. Гэхдээ бичил бизнесийн гуравны нэг орчим нь хугацааны алдагдалтай ажиллаж байна. Судалгаанд хамрагдсан ЖДБ-ийн 67.6% нь бараа, үйлчилгээгээ төлөвлөсөн хугацаандаа үйлдвэрлэлдэг, 23.8% нь зарим үед хоцордог, 8.7% нь төлөвлөсөн хугацаанаасаа хоцордог гэжээ (Хүснэгт 10). Ялангуяа бичил бизнесүүдэд бараа, үйлчилгээгээ төлөвлөсөн цагтаа үйлдвэрлэж амжихгүй байх асуудал түгээмэл байна.

Тэдний гуравны нэг гаруй (37.6%) нь төлөвлөсөн хугацаанаасаа ямар нэгэн байдлаар хоцордог гэжээ. ЖДБ-ийн 74.7% бараа, үйлчилгээгээ тогтсон хугацаанд хэрэглэгчдэд хүргэдэг, 20.3% нь заримдаа хоцроодог, 5% нь тогтсон хугацаанаасаа хоцроодог гэжээ. Түүнчлэн бичил бизнесүүд энэ асуудал мөн л илүү түгээмэл байна.

Хүснэгт 10. ЖДБ-ийн цаг хугацааны үр ашиг, хувиар

Үзүүлэлт	Нийт (n=703)	Бизнесийн хэмжээ			Удирдлагын хүйс	
		Бичил (n=407)	Жижиг (n=165)	Дунд (n=131)	Эрэгтэй (n=404)	Эмэгтэй (n=299)
Бараа, үйлчилгээг төлөвлөсөн цагтаа үйлдвэрлэдэг эсэх						
Төлөвлөсөн хугацаандаа	67.6	62.4	71.5	79.7	67.9	67.2
Заримдаа хоцордог	23.8	27.0	20.6	17.0	23.8	23.7
Төлөвлөснөөсөө хоцордог	8.7	10.6	7.8	3.5	8.4	9.1
Бараа, үйлчилгээг тогтсон хугацаанд хэрэглэгчдэд хүргэдэг эсэх						
Тогтсон хугацаандаа	74.7	69.8	78.2	86	73.8	75.9
Заримдаа хоцордог	20.3	23.6	18.8	11.4	20.8	19.7
Тогтсон хугацаанаасаа хоцордог	5.0	6.6	3.0	2.8	5.5	4.3

3.1.2. Нөөцийн менежментийн өрсөлдөх чадвар

Энэ үндсэн үзүүлэлтийн хүрээнд гурван индикатор авч үзсэнээс *банканд данс эзэмших байдал*, *мөнгөн хөрөнгийн удирдлага* гэсэн хоёр индикатор **харьцуулах түвшнээс дээгүүр**, *орлого*, *зарлагын бүртгэл* хүчтэй түвшинд үнэлэгджээ (Хүснэгт 7). *Орлого*, *зарлагын бүртгэл* индикаторыг тухайн байгууллага нөөцийн удирдлага, мөнгөн хөрөнгийн удирдлага, зохицуулалт хийх зорилгоор бизнесийн орлого, зардлаа хэр давтамжтай бүртгэдгээр хэмжив. Банканд данс эзэмших индикаторыг тухайн байгууллага банканд данстай эсэх болон дансны төрлөөр, мөнгөн хөрөнгийн удирдлага индикаторыг тухайн байгууллага мөнгөн хөрөнгөө хэр удирдаж, шаардлагатай зохицуулалт хийж чаддаг эсэхээр тус тус хэмжив (дэлгэрэнгүйг Хавсралт 1-ээс харна уу).

ЖДБ-ийн шинж байдлаар авч үзвэл орлого, зарлагын бүртгэлийн индикатор ЖДБ-ийн шинж байдлаас үл хамааран бүгд хүчтэй түвшинд байгаа ч бичил, худалдааны салбарын, орон нутгийн бизнесүүдийн хувьд бусад ангиллаас арай доогуур үнэлэгджээ. *Банканд данс эзэмших* байдлын индикатор мөн л ЖДБ-ийн шинж байдлаас үл хамааран бүгд харьцуулах түвшнээс дээгүүр байгаа ч бичил, үйлчилгээний салбарын, орон нутгийн, эмэгтэй гүйцэтгэх удирдлагатай бизнесүүдийн хувьд бусад ангиллаас арай доогуур үнэлэгдсэн байна. *Мөнгөн хөрөнгийн удирдлага* индикатор дунд бизнесийн хувьд хүчтэй түвшинд үнэлэгдсэн бол бусад бүх ангилалд харьцуулах түвшнээс дээгүүр байна (Хүснэгт 7).

ЖДБ-үүдийн олонх нь бизнесийн орлого, зарлагын бүртгэлээ байнга хийж байна. Гэхдээ бичил бизнесийн орлого, зарлагын бүртгэлийг сайжруулах шаардлага байна. Орлого, зарлагын бүртгэлээ тогтмол хийх нь нөөц ба мөнгөн хөрөнгөө удирдах, шаардлагатай зохицуулалт хийх гол суурь нь болдог. Судалгаанд хамрагдсан ЖДБ-ийн 69.6% нь бизнесийн орлого, зарлагаа байнга бүртгэдэг бол 23.2% нь заримдаа бүртгэдэг, 7.3% нь бүртгэдэггүй гэжээ (Хүснэгт 11). Заримдаа бүртгэл хийдэг болон бүртгэл хөтөлдөггүй байдал бичил бизнесийн 37%-д байна. Иймд бичил бизнесийн орлого, зарлагын бүртгэлийг тогтмолжуулахад анхаарах шаардлага байна.

ЖДБ-ийн 87.3% нь данстай, харин 12.7% нь дансгүй байгаа нь тийм ч бага тоо биш юм. Аливаа аж ахуй нэгж дансгүй байна гэдэг нь санхүүгийн бүхий л үйл ажиллагаанаас гадуур орхигдохын сацуу өдөр тутмын үйл ажиллагаа тогтвортой явуулах, санхүүгийн тайлан тооцоо гаргах, бизнесээ институтийн хувьд бэхжүүлэх, өсөж хөгжихөд нь хүндрэл учруулдаг. Дансгүй байх явдал бичил, жижиг, эмэгтэй удирдлагатай бизнест илүү ажиглагдаж байна. Эдгээр байгууллагууд голдуу хувь хүний дансыг бизнесийн үйл ажиллагаандаа ашигладаг байх талтай. Иймд бизнесийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд байгууллагын хувьд данстай болгоход анхаарах шаардлагатай. Данстай ААН-үүдийн хувьд дансны төрлөөр нь авч үзвэл ЖДБ-ийн 57.9% нь төгрөгийн харилцах/хугацаагүй хадгаламжийн данстай, 20.1% нь төгрөгийн хугацаатай хадгаламжийн данстай, 8% нь гадаад валютын харилцах/хугацаагүй хадгаламжийн данстай, 1.4% гадаад валютын хугацаатай хадгаламжийн данстай байна (Хүснэгт 11). ЖДБ-ийн тавны нэг нь хадгаламжийн данстай байгаа нь өөрсдийн эх үүсвэрээр санхүүгийн асуудлаа зохицуулах боломж бүрдсэнийг харуулж байна. Түүнчлэн 12% нь нэгээс дээш төрлийн данстай байна.

ЖДБ-ийн 61.2% нь мөнгөн хөрөнгөө хангалттай сайн удирдаж, шаардлагатай зохицуулалтыг хийж чаддаг гэжээ. Гэвч бичил бизнесийн хувьд мөнгөн хөрөнгөө удирдахад хүндрэл учирдаг байна. Харин 36.1% нь мөнгөн хөрөнгийн удирдлагаа дунд зэрэг, 2.7% нь хангалтгүй гэж үнэлжээ. Ялангуяа бичил бизнесийн 42.7% нь мөнгөн хөрөнгийн удирдлагаа дунд зэрэг, хангалтгүй гэж үнэлсэн байна. Цаашлаад дансгүй бизнес эрхлэгчдэд мөнгөн хөрөнгөө зохицуулахад хүндрэл учирдаг байна. Иймд бичил бизнесийн хувьд мөнгөн хөрөнгөө хэрхэн удирдах, шаардагдах зохицуулалт хийх, данстай болохын ач холбогдлын талаар мэдлэг олгох шаардлага байна.

Хүснэгт 11. ЖДБ-ийн нөөцийн менежмент, хувиар

Үзүүлэлт	Нийт (n=703)	Бизнесийн хэмжээ			Удирдлагын хүйс	
		Бичил (n=407)	Жижиг (n=165)	Дунд (n=131)	Эрэгтэй (n=404)	Эмэгтэй (n=299)
Бизнесийн орлого, зарлагын бүртгэл						
Байнга бүртгэдэг	69.6	63.1	75.2	82.5	68.3	71.2
Заримдаа бүртгэдэг	23.2	27.8	20.0	13.0	23.8	22.4
Бүртгэдэггүй	7.3	9.1	4.9	4.6	7.9	6.4
Банканд данс эзэмших байдал						
Төгрөгийн харилцах/хугацаагүй хадгаламжийн данстай	57.9	65.4	55.2	38.2	56.7	59.5
Төгрөгийн хугацаатай хадгаламжийн данстай	20.1	17.2	20.0	29.0	21.0	18.7
Гадаад валютын харилцах/хугацаагүй хадгаламжийн данстай	8.0	3.0	9.1	22.1	9.7	5.7
Гадаад валютын хугацаатай хадгаламжийн данстай	1.4	0.5	1.8	3.8	1.2	1.7
Ямар нэгэн дансгүй	12.7	14.0	13.9	6.9	11.4	14.4

Мөнгөн хөрөнгийн удирдлагын өөрийн үнэлгээ						
Хангалттай	61.2	57.2	63.6	72	61.6	60.5
Дунд зэрэг	36.1	39.3	34.5	25	35.4	37.1
Хангалтгүй	2.7	3.4	1.8	2	2.9	2.4

3.1.3. Чанарын удирдлагын өрсөлдөх чадвар

Энэ үндсэн үзүүлэлтийг *чанарын хяналт, стандарт* гэсэн нэг индикатораар хэмжиж байгаа бөгөөд энэ нь **харьцуулах түвшнээс үл ялиг дээгүүр** үнэлэгджээ (Хүснэгт 7). *Чанарын хяналт, стандарт* индикаторыг тухайн байгууллага бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанарт ямар нэгэн стандарт (байгууллагын дотоод, үндэсний, олон улсын) баримталдаг эсэхээр хэмжив (дэлгэрэнгүйг Хавсралт 1-ээс харна уу). ЖДБ-ийн шинж байдлаар авч үзвэл *чанарын хяналт, стандартын* индикатор жижиг болон орон нутгийн бизнесийн хувьд сул түвшинд байна (Хүснэгт 7).

ЖДБ-ийн бараа, үйлчилгээний чанарын хяналт, баталгаажуулалтын стандарт хангалтгүй байна. Судалгаанд хамрагдсан 703 ЖДБ-ийн 324 (46.1%) нь бараа, үйлчилгээнийхээ чанарт хяналт хийдэггүй, 221 (31.4%) нь тогтсон стандарт баримталдаггүй ч байгууллагын дотоод чанарын хяналтыг хийдэг, 40 (5.7%) үндэсний түвшний чанар, баталгаажуулалтын стандарт баримталдаг, 118 (16.8%) олон улсын чанар, баталгаажуулалтын стандарт баримталдаг гэжээ. Бараа, үйлчилгээний чанарт хяналт тавьдаггүй байдал бичил бизнесийн дунд хамгийн түгээмэл буюу тал хувь нь чанарт анхаарал тавьдаггүй байна. Нөгөө талаас 165 жижиг бизнесийн 37 (22.4%), 131 дунд бизнесийн 40 (30.5%) нь олон улсын чанарын баталгаажуулалтын стандарт баримталж байгаа нь сайшаалтай явдал юм. Олон улсын чанарын баталгаажуулалт баримталдаг ААН-үүдийн хувьд чанарын удирдлагын тогтолцоо (ISO 9000 цуврал), хүнсний аюулгүй байдлын HACCP тогтолцоог голдуу баримталж байна.

Хүснэгт 12. ЖДБ-ийн чанарын хяналт, стандарт хувиар

Үзүүлэлт	Нийт (n=703)	Бизнесийн хэмжээ			Удирдлагын хүйс	
		Бичил (n=407)	Жижиг (n=165)	Дунд (n=131)	Эрэгтэй (n=404)	Эмэгтэй (n=299)
Чанарын хяналт хийдэггүй	46.1	50.1	38.8	42.8	46.8	45.2
Тогтсон стандартгүй ч дотоод чанарын хяналт хийдэг	31.4	32.7	34.6	23.7	30.0	33.4
Үндэсний түвшний чанар, баталгаажуулалтын стандарт баримталдаг	5.7	7.1	4.2	3.1	4.7	7.0
Олон улсын чанар, баталгаажуулалтын стандарт баримталдаг	16.8	10.1	22.4	30.5	18.6	14.4

3.2. КОМПАНИЙН ХОЛБОГДОХ ЧАДВАР

Энэ хэсэгт компанийн холбогдох чадварын баганыг хэмжихэд ашигласан индикаторуудыг дэлгэрүүлэн авч үзнэ (Хүснэгт 13). Зах зээл болон бизнесийн орчинд ЖДБ-үүдийн холбогдох чадвар хэр бэлэн байгааг (1) хэрэглэгч, (2) нийлүүлэгч, (3) институт гэсэн 3 хүрээнд тодорхойлно.

Хүснэгт 13. Холбогдох чадвар баганын индикаторуудын нормчилсон оноо, ЖДБ-ийн шинж байдлаар

Үндсэн үзүүлэлт	Индикатор	Нийт үнэлгээ	Бизнесийн хэмжээ			Салбар			Байршил		Удирдлагын хүйс	
			Бичил	Жижиг	Дунд	Худалдаа	Үйлчилгээ	Үйлдвэрлэл	Улаанбаатар	Орон нутаг	Эрэгтэй	Эмэгтэй
Хэрэглэгч	Мэдээллийн сувгууд	25.6	17.8	31.5	42.4	29	25.4	25.6	29.1	17.5	26.6	24.2
	Хэрэглэгчийн мэдээлэл бүрдүүлэлт	21.9	18	23.6	31.7	24.9	20.7	20.8	23.6	17.9	22.2	21.4
	Борлуулалт, маркетингийн сувгууд	54.1	48.8	58.5	65.1	57.2	50.7	58.7	55.4	51.2	53.6	54.8
Нийлүүлэгч	Ханган нийлүүлэгчийн харилцаа	68	62.5	73.9	78.0	69.2	67.4	69.6	70.3	62.9	68.8	67.1
	Ханган нийлүүлэгчийн гүйцэтгэлийн үнэлгээ	49.6	45.5	53.3	57.6	50.6	46.3	52.8	53.6	40.2	49.9	49.2
Институт	Гишүүнчлэл	25.0	20.3	30.6	32.8	22.1	24.1	30.1	22.0	32.1	24.5	25.8
	Гишүүнчлэлийн үнэлгээ	47.2	45.5	48.5	49.3	45.8	44.5	50.7	48.2	45.5	47.4	46.9

Харьцуулах утга: **44.2**

Индикаторын сул түвшин: **≤26.5 оноо**

Индикаторын хүчтэй түвшин: **≥70.7 оноо**

3.2.1. Хэрэглэгчтэй холбогдох чадвар

Энэ үндсэн үзүүлэлтийн хүрээнд гурван индикатор авч үзсэнээс *мэдээллийн сувгууд*, *хэрэглэгчийн мэдээлэл бүрдүүлэлт* гэсэн хоёр индикатор **сул түвшинд**, *борлуулалт*, *маркетингийн сувгийн* индикатор **харьцуулах түвшнээс дээгүүр** үнэлэгджээ (Хүснэгт 13). *Мэдээллийн сувгууд* индикаторыг тухайн байгууллага хэр олон мэдээллийн суваг ашиглаж байгаагаар хэмжив. *Хэрэглэгчийн мэдээлэл бүрдүүлэлт* индикаторыг тухайн байгууллага хэрэглэгчтэйгээ харилцах тогтолцоог бий болгосон эсэх болон хэр олон сувгаар хэрэглэгчийн мэдээллийг (хэрэглэгчийн профайл, таашаал сонирхол, сэтгэл ханамж) бүрдүүлж байгаагаар хэмжив. *Борлуулалт*, *маркетингийн сувгийн* индикаторыг бараа үйлчилгээний борлуулалт, сурталчилгааг хэчнээн сувгаар хийж байгаагаар хэмжив (дэлгэрэнгүйг Хавсралт 1-ээс харна уу). Холбогдох чадварын тухайд тухайн байгууллага тодорхой сувгуудтай байгаа эсэхээс илүү хэдэн сувгаар хэрэглэгчтэйгээ холбогдож, зах зээлд хүрч байгааг хэмжихийг зорьсныг тэмдэглэн


хэлэх нь зүйтэй юм. Тодруулбал, холбогдох үйл ажиллагаанд хэр өрсөлдөх чадвартай байгааг энд авч үзнэ.

ЖДБ-ийн шинж байдлаар авч үзвэл *харилцаа мэдээллийн сувгууд, хэрэглэгчийн мэдээлэл бүрдүүлэлт* гэсэн хоёр индикатор нийтлэг сул түвшинд үнэлэгдсэн. Гэхдээ *харилцаа мэдээллийн сувгууд* индикаторын хувьд жижиг, дунд, худалдааны салбарын, Улаанбаатарын бизнесүүд сул түвшнээс дээгүүр, харьцуулах түвшнээс доогуур байна. Эдгээрээс дунд бизнесүүд *харилцаа мэдээллийн сувгууд, хэрэглэгчийн мэдээлэл бүрдүүлэлт* индикаторуудын хувьд хамгийн өндөр үнэлгээтэй нь байна. Борлуулалт, маркетингийн сувгийн индикаторын хувьд ЖДБ-ийн шинж байдлаас үл хамааран бүгд харьцуулах түвшнээс дээгүүр байгаа ч бичил, үйлчилгээний салбарын, орон нутгийн бизнесүүд бусад ангиллаас арай доогуур үнэлэгджээ (Хүснэгт 13).

ЖДБ-ийн мэдээллийн гол суваг нь фейсбүүк бөгөөд олонх нь нэг мэдээллийн сувгаар хэрэглэгчдэдээ мэдээллээ хүргэж байна. ЖДБ-ийн 80.5% нь фейсбүүкээр, 31.6% нь цахим хуудсаараа, 31.4% нь бусад сошиал сувгуудаар, 2.4% нь бусад сувгаар дамжуулан хэрэглэгчдэдээ мэдээлэл дамжуулж байна (Зураг 10). Харин 5.7% нь мэдээллийн суваггүй гэж хариулсан бөгөөд эдгээрийн олонх нь бичил болон эмэгтэй удирдлагатай бизнесүүд байна. 57.5% нь нэг сувгаар, 22.6% нь хоёр сувгаар, 14.2% нь гурав ба түүнээс дээш сувгаар мэдээллээ дамжуулж байна (Хүснэгт 14). Нэг мэдээллийн сувагтай байх явдал бичил бизнесүүдэд (64.9%) түгээмэл байгаа бол хоёр, гурваас дээш сувагтай байх явдал жижиг ба дунд бизнесүүдэд түгээмэл байна.

ЖДБ-ийн гуравны нэг гаруй (35.6%) нь хэрэглэгчээ татах, байнгын хэрэглэгчээ халамжлах, хэрэглэгчтэйгээ харилцах тогтолцоог бий болгоогүй байна. Хэрэглэгчтэй харилцах тогтолцоог бий болгох нь дан ганц хэрэглэгчээ урамшуулах, хэрэглээг нь дэмжих үйл ажиллагаа биш бөгөөд компанийн зүгээс хэрэглэгчийн мэдээллийг бүрдүүлэх замаар тэдний үйл хөдлөлийг (таашаал сонирхол, сэтгэл ханамж, худалдан авалтын давтамж, г.м.) таньж мэдэх, цаашлаад энэ мэдээлэлд үндэслэн үйл ажиллагаагаа оновчлох, өрсөлдөх чадвараа сайжруулах боломжтой юм. Хэрэглэгчтэйгээ харилцах тогтолцоогүй байх явдал бичил (43.7%) болон эмэгтэй удирдлагатай (37.8%) бизнест түгээмэл байна (Хүснэгт 14). Хэрэглэгчтэйгээ харилцах тогтолцоог бий болгоход ЖДБ-үүдэд хамгийн түгээмэл ашигладаг арга нь хэрэглэгчдэд зориулсан урамшууллыг явуулдаг бөгөөд 35.2% нь үүнийг ашигладаг ажээ (Зураг 11). 21.9% нь хэрэглэгчийн сэтгэл ханамжийг судалгааг тогтмол зохион байгуулдаг, 20.2% нь хэрэглэгчийн лоялти, урамшууллын картын системтэй байна. ЖДБ-ийн 53.2% нь эдгээр аргын нэгийг ашигладаг, 7.5% нь хоёр аргыг хослуулдаг, 3.7% нь гурав ба түүнээс дээш аргыг ашигладаг байна (Хүснэгт 14).

Зураг 11. ЖДБ-ийн мэдээллийн сувгууд




Зураг 12. ЖДБ-ийн хэрэглэгчийн мэдээлэл бүрдүүлэлтийн тогтолцоо



ЖДБ-ийн борлуулалт, маркетингаа голдуу социал хуудсаараа хийдэг бөгөөд талаас дээш хувь нь нэгээс дээш сувгаар борлуулалт, маркетингаа хийж байна. ЖДБ-үүд социал хуудаснаас гадна нэрийн дэлгүүр, үзэсгэлэн худалдаа, цахим хуудас, захиалга зэргийг борлуулалтдаа түгээмэл ашиглаж байна. (Зураг 12). Гэхдээ 8.5% нь борлуулалт, маркетингийн суваггүй бөгөөд энэ нь бичил (10.3%) болон эмэгтэй удирдлагатай (10.4%) бизнест түгээмэл байна (Хүснэгт 14). ЖДБ-ийн 35.2% нь нэг сувгаар, 22.9% нь хоёр сувгаар, 14.8% нь гурван сувгаар, 18.5% дөрөв ба түүнээс дээш сувгаар борлуулалт, маркетингаа хийдэг аж.

Зураг 13. ЖДБ-ийн борлуулалт, маркетингийн сувгууд



Хүснэгт 14. Хэрэглэгчтэй холбогдох чадвар, хувиар

Үзүүлэлт	Нийт (n=703)	Бизнесийн хэмжээ			Удирдлагын хүйс	
		Бичил (n=407)	Жижиг (n=165)	Дунд (n=131)	Эрэгтэй (n=404)	Эмэгтэй (n=299)
Мэдээллийн сувгууд						
Мэдээллийн суваггүй	5.7	7.6	4.2	1.5	4.7	7.0
Нэг мэдээллийн сувагтай	57.5	64.9	50.9	42.8	56.7	58.5
Хоёр мэдээллийн сувагтай	22.6	19.4	26.7	27.5	24.3	20.4
Гурав ба түүнээс дээш мэдээллийн сувагтай	14.2	8.1	18.2	28.2	14.4	14.1
Хэрэглэгчийн мэдээлэл бүрдүүлэлтийн тогтолцоо						
Тогтолцоо байхгүй	35.6	43.7	29.1	18.3	33.9	37.8
Нэг сувагтай	53.2	49.1	58.2	59.5	54.2	51.8
Хоёр сувагтай	7.5	3.9	11.5	13.7	8.2	6.7
Гурав ба түүнээс дээш сувагтай	3.7	3.2	1.2	8.4	3.7	3.7
Борлуулалт, маркетингийн сувгууд						
Суваг байхгүй	8.5	10.3	7.9	3.8	7.2	10.4
Нэг сувгаар	35.3	41.0	33.3	19.9	35.2	35.5
Хоёр сувгаар	22.9	22.9	17.6	29.8	25.5	19.4
Гурван сувгаар	14.8	15.2	15.2	13.0	14.9	14.7
Дөрөв ба түүнээс дээш сувгаар	18.5	10.6	26.1	33.6	17.3	20.1

3.2.2. Ханган нийлүүлэгчтэй холбогдох чадвар

Энэ үндсэн үзүүлэлтийн хүрээнд хоёр индикатор авч үзсэнээс ханган нийлүүлэгчийн харилцаа индикатор **харьцуулах түвшнээс дээгүүр**, ханган нийлүүлэгчийн гүйцэтгэлийн үнэлгээ **харьцуулах түвшнээс доогуур** үнэлэгджээ (Хүснэгт 13). Ханган нийлүүлэгчийн харилцаа индикаторыг хоёр дэд үзүүлэлтээр хэмжсэн ба тухайн байгууллага ханган нийлүүлэгч талтай албан ёсны гэрээ байгуулсан байдал болон тогтмол нэг эсвэл цөөн тооны ханган нийлүүлэгчтэй байнга хамтран ажилладаг байдлыг хэмжив. Ханган нийлүүлэгчийн гүйцэтгэлийн үнэлгээ индикаторыг тухайн байгууллага ханган нийлүүлэгчдээ жил, хагас жил, улирал тутам үнэлдэг тогтолцоог бий болгосон эсэхээр үнэлсэн. Холбогдох чадварын тухайд тухайн байгууллага тодорхой ханган нийлүүлэгчтэй байгаа эсэхээс илүү ханган нийлүүлэгчтэйгээ албан ёсны гэрээ байгуулдаг эсэх, тогтмол ханган нийлүүлэгчтэй эсэх, үнэлдэг байдал зэргийг хэмжихийг зорьсныг тэмдэглэн хэлэх нь зүйтэй юм. Тодруулбал, ханган нийлүүлэгчтэйгээ холбогдох үйл ажиллагаанд хэр өрсөлдөх чадвартай байгааг энд авч үзнэ.

ЖДБ-ийн шинж байдлаар авч үзвэл ханган нийлүүлэгчийн харилцаа үүсгэж буй байдал болон ханган нийлүүлэгчтэй үнэлдэг байдалд ялгаа бага байна. Гэхдээ ханган нийлүүлэгчийн харилцааны индикаторын хувьд бичил, орон нутгийн бизнесүүд бусад бизнесүүдтэй харьцуулахад сул түвшинтэй, харьцуулах түвшнээс доогуур

үнэлэгдэж байна. Эдгээрээс жижиг, дунд болон Улаанбаатар хотын бизнесүүд ханган нийлүүлэгчийн харилцаа индикаторуудын хувьд хамгийн дээгүүр үнэлгээтэй нь байна. Ханган нийлүүлэгчдийн гүйцэтгэлийн үнэлгээ индикаторын хувьд ЖДБ-ийн шинж байдлаас үл хамааран бүгд харьцуулах түвшнээс доогуур байгаа ч бичил, үйлчилгээний салбарын, орон нутгийн бизнесүүд бусад ангиллаас арай доогуур үнэлэгджээ (Хүснэгт 13).

ЖДБ-ийн ханган нийлүүлэгчтэй албан ёсны гэрээнд суурилсан найдвартай харилцаа үүсгэж байгаа байдал хангалтгүй байна. ЖДБ-ийн 48.4% нь бичгээр, 22% нь аман тохиролцоо, 22.9% нь шууд худалдан авалт, 6.7% нь танилын харилцаагаар дамжуулан ханган нийлүүлэгчтэйгээ холбогдож байна Мөн бичил, эмэгтэй удирдлагатай бизнесүүд албан бичгээр гэрээ байдал сул байна.

ЖДБ-ийн тогтмол нэг, эсвэл цөөн тооны ханган нийлүүлэгчтэй харилцах байдал хангалтгүй хэвээр буюу тухайн нөхцөл байдлаас хамаарах, ханган нийлүүлэгчээ байнга солих, тогтмол ханган нийлүүлэгч байхгүй байх тохиолдол (46.3) байна. Ханган нийлүүлэгчтэй тогтмол хамтран ажиллах тогтолцоог бий болгох нь ханган нийлүүлэлтэд тасралт үүсгэхгүй байх, бараа материалыг худалдан авах урамшуулал, хөнгөлөлт эдлэх, итгэлцэл бий болох, хүндрэлтэй үеийг ухаалгаар даван түүлах гэх мэт өрсөлдөх чадвараа сайжруулах боломжтой юм. Тогтмол нэг, эсвэл цөөн тооны ханган нийлүүлэгчгүй байдал бичил (52.9%) болон эрэгтэй удирдлагатай (48.4%) бизнест түгээмэл байна.

ЖДБ-ийн хувьд ханган нийлүүлэгчдээ улирал, хагас жил, жилийн эцэст үнэлдэг байдал сайн (67.5%) байна. ЖДБ-үүд 22.5% хагас жил тутамд, 18.5% хагас жил тутам, 26.5% жилийн эцэст ханган нийлүүлэгчдээ үнэлж байна. Гэхдээ 32.6% нь ханган нийлүүлэгчдээ огт үнэлэхгүй байна. Ханган нийлүүлэгчдийн гүйцэтгэлийн үнэлгээ хувьд бизнесийн хэмжээ, бизнесийн удирдлагын хүйсээс хамаарсан ялгаа байхгүй байна.

Хүснэгт 15. Ханган нийлүүлэгч талын индикаторууд, хувиар

Үзүүлэлт	Нийт (n=703)	Бизнесийн хэмжээ			Удирдлагын хүйс	
		Бичил (n=407)	Жижиг (n=165)	Дунд (n=131)	Эрэгтэй (n=404)	Эмэгтэй (n=299)
Гэрээ байгуулсан эсэх						
Албан ёсны гэрээг бичгээр үйлддэг	48.4	35.9	58.2	74.8	52.2	43.1
Ихэвчлэн аман тохиролцоо хийдэг	22.0	28.5	19.4	5.3	19.6	25.4
Тохиролцох шаардлагагүй тул шууд худалдан авдаг	22.9	26.8	17	18.3	21.5	24.7
Танилын харилцаан дээр үндэслэдэг	6.7	8.8	5.5	1.5	6.7	6.7
Ханган нийлүүлэлтийн харилцаа						
Тогтмол нэг ханган нийлүүлэгчтэй хамтран ажилладаг	31.0	22.6	38.8	47.3	31.2	30.8

Цөөн тооны ханган нийлүүлэгчтэй ээлжлэн хамтран ажилладаг	22.6	24.6	24.2	14.5	20.3	25.8
Тухайн үеийн нөхцөлөөс хамааран өөр өөр ханган нийлүүлэгчтэй харилцдаг	38.5	43.5	28.5	35.9	40.3	36.1
Ханган нийлүүлэгчид байнга солигддог	2.3	2.0	4.2	0.8	2.7	1.7
Тогтсон ханган нийлүүлэгчид байхгүй	5.5	7.4	4.2	1.5	5.4	5.7
Ханган нийлүүлэгчийн үнэлгээ						
Улирал тутамд үнэлдэг	22.5	21.1	24.2	24.2	22.3	22.7
Хагас жил тутамд үнэлдэг	18.5	16.7	20.6	21.4	18.3	18.7
Жилийн эцэст үнэлдэг	26.5	23.6	27.3	34.4	27.7	24.7
Огт үнэлдэггүй	32.6	38.6	27.9	19.8	31.7	33.8

3.2.3. Институтүүдтэй холбогдох чадвар

Энэ үндсэн үзүүлэлтийг хоёр индикатор авч үзсэнээс *гишүүнчлэлийн индикатор харьцуулах түвшнээс сул* түвшинд, *гишүүнчлэлийн гүйцэтгэлийн үнэлгээ харьцуулах түвшнээс доогуур* түвшинд үнэлэгджээ. *Гишүүнчлэлийн* индикаторыг тухайн байгууллага худалдааны танхимүүд, бизнесийн холбоод, мэргэжлийн холбоод, бусад худалдаа хамтын ажиллагааны байгууллагад гишүүнчлэлтэй эсэхээр хэмжив. Харин *гишүүнчлэлийн үнэлгээ* индикаторыг эдгээр гишүүнчлэл бүхий байгууллагынхаа үйл ажиллагаанд өгч буй үнэлгээгээр хэмжлээ.

ЖДБ-ийн шинж байдлаар авч үзвэл гишүүнчлэл, гишүүнчлэлийн үнэлгээ индикаторуудын хувьд төдийлөн ялгаа байхгүй байна.

ЖДБ-ийн талаас илүү нь холбогдох бизнесийн болон мэргэжлийн байгууллагуудад гишүүнчлэлгүй байна. Харин гишүүнчлэлтэй бизнесүүд гишүүнчлэл бүхий байгууллагынхаа үйл ажиллагаанаас үр өгөөж хүртэх байдал төдийлөн хангалтгүй байна. Бизнесийн болон мэргэжлийн холбоо, байгууллагуудад гишүүнчлэлтэй байснаар бизнес, зах зээлийн нөхцөл байдал, боломж, эрсдэлийн талаар мэдээлэл авах, мэргэжлийн зөвлөгөө авах, бизнесийн үйл ажиллагаагаа хамтын зохион байгуулалтад оруулах зэрэг давуу талуудыг бий болгож, улмаар өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх боломжтой юм. Судалгаанд хамрагдсан ЖДБ-ийн 58.3% нь гишүүнчлэлгүй, 21.1% нь мэргэжлийн холбоонд, 17.4% нь худалдааны танхимд, 12.5% нь бизнесийн холбоонд, 1.7% нь бусад байгууллагад гишүүнчлэлтэй байна. Гишүүнчлэлгүй байх явдал бичил бизнест давамгайл байна. Гишүүнчлэлтэй ЖДБ-ийн 28% нь гишүүнчлэлтэй байгууллагынхаа үйл ажиллагаанаас үр өгөөжийг нь хүртдэг, 41% нь дунд зэрэг, 21.9% үр өгөөж хүртдэггүй гэсэн бол 9.9% нь гишүүнчлэлтэй байгууллагынхаа үйл ажиллагааг үнэлж мэдэхгүй байв.

Хүснэгт 16. Гишүүнчлэл, гишүүнчлэлийн үнэлгээний индикаторууд, хувиар

Үзүүлэлт	Нийт (n=703)	Бизнесийн хэмжээ			Удирдлагын хүйс	
		Бичил (n=407)	Жижиг (n=165)	Дунд (n=131)	Эрэгтэй (n=404)	Эмэгтэй (n=299)
Гишүүнчлэл (Олон сонголттой)						
Гишүүнчлэл байхгүй	58.3	64.4	50.9	48.9	58.9	57.5
Худалдааны танхимууд (МҮХАҮТ г.м)	17.4	9.3	9.1	13.7	9.9	10.4
Бизнесийн холбоод	12.5	6.6	13.3	11.5	8.7	9.7
Мэргэжлийн холбоод	21.1	18.4	24.2	23.7	20.8	20.7
Бусад (худалдаа, хамтын ажиллагааг дэмжих байгууллага)	1.7	1.2	2.4	2.3	1.7	1.7
Гишүүнчлэлийн үнэлгээ						
	Нийт (n=293)	Бичил (n=145)	Жижиг (n=81)	Дунд (n=67)	Эрэгтэй (n=166)	Эмэгтэй (n=127)
Сэтгэл ханамжтай	28.0	24.9	29.7	33.0	28.3	27.6
Дунд зэрэг	41.0	40.0	43.2	39.0	41.0	40.9
Сэтгэл ханамжгүй	21.2	26.2	17.2	15.0	21.1	21.2
Мэдэхгүй	9.9	9.0	9.9	12.0	9.6	10.2

3.3. КОМПАНИЙН ӨӨРЧЛӨГДӨХ ЧАДВАР

Энэ хэсэгт компанийн өөрчлөгдөх чадварын баганыг хэмжихэд ашигласан индикаторуудыг дэлгэрүүлэн авч үзнэ (Хүснэгт 17). Зах зээл, бизнесийн орчны аливаа өөрчлөлтөд ЖДБ-үүд хэр бэлэн байгааг (1) бизнес төлөвлөлт ба санхүү, (2) хүний нөөцийн үр чадвар, (3) инновац гэсэн хүрээнд тодорхойлно.

Хүснэгт 17. Өөрчлөгдөх чадвар баганын индикаторуудын нормчилсон оноо, ЖДБ-ийн шинж байдлаар

Үндсэн үзүүлэлт	Индикатор	Нийт үнэлгээ	Бизнесийн хэмжээ			Салбар		Байршил		Удирдлагын хүйс		
			Бичил	Жижиг	Дунд	Худалдаа	Үйлчилгээ	Үйлдвэрлэл	Улаанбаатар	Орон нутаг	Эрэгдэй	Эмэгтэй
Бизнес төлөвлөлт ба санхүү	Бизнесийн төлөвлөлт	25.5	17.9	33.8	38.4	27.3	24.6	27.2	26.9	22.1	26.2	24.2
	Санхүүгийн боломжит эх үүсвэр	80.0	77.0	81.7	87.4	86.1	74.6	83.3	78.2	84.3	83.4	75.6
	Санхүүгийн тайлагналт ба баталгаажуулалт	59.1	51.0	64.7	77.5	56.9	57.9	63.3	59.3	58.8	61.6	55.8

Ур чадвар	Ур чадвартай хүний нөөц	61.1	57.8	64.1	67.7	62.1	61.4	60.3	61.0	61.4	60.2	62.4
	Ур чадвартай хүний нөөцийг бүрдүүлэх	58.1	51.4	58.6	78.1	53.2	59.3	60.2	62.0	48.6	59.2	56.5
Инновац	Инновац ашиглалт	58.6	49.6	64.8	78.6	56.3	61.8	61.6	63.3	47.6	61.2	55.2
	Инновац хөгжүүлэлт	32.0	29.2	33.2	38.8	28.9	29.4	36.7	34.2	26.8	33.4	30.1

Харьцуулах түвшин: 44.2

Индикаторын сул түвшин: ≤26.5 оноо

Индикаторын хүчтэй түвшин: ≥70.7 оноо

3.3.1. Бизнес төлөвлөлт ба санхүүгийн боломжид хүрэх чадвар

Энэ үндсэн үзүүлэлтийн хүрээнд гурван индикатор авч үзсэнээс *бизнес төлөвлөлтийн* индикатор сул түвшинд, *санхүүгийн боломжит эх үүсвэрийн* индикатор **хүчтэй түвшинд**, *санхүүгийн тайлагналт ба баталгаажуулалтын* индикатор **харьцуулах түвшнээс дээгүүр** үнэлэгджээ. (Хүснэгт 17). *Бизнес төлөвлөлтийн* индикаторыг тухайн байгууллага бизнес төлөвлөгөө боловсруулдаг эсэх болон боловсруулалтын түвшингөөр, *санхүүгийн боломжит эх үүсвэрийн* индикаторыг санхүүгийн зайлшгүй хэрэгцээгээ ямар эх үүсвэрээс шийдэх боломжтойгоор тус тус хэмжив. *Санхүүгийн тайлагналт ба баталгаажуулалтын* индикаторыг тухайн байгууллага санхүүгийн тайлангаа хэр түвшинд боловсруулдаг, санхүүгийн тайлангаа баталгаажуулдаг эсэх гэсэн хоёр дэд индикатораар хэмжив (дэлгэрэнгүйг Хавсралт 1-ээс харна уу).

ЖДБ-ийн шинж байдлаар авч үзвэл *бизнес төлөвлөлтийн индикатор* бичил болон орон нутгийн бизнесийн хувьд сул түвшинд үнэлэгдсэн бөгөөд үүнийг цаашид онцгой анхаарах шаардлагатай. *Санхүүгийн боломжит эх үүсвэрийн* индикаторууд ЖДБ-ийн шинж байдлаас үл хамааран бүгд хүчтэй ангилалд байгаа ч бичил, үйлчилгээний салбарын, эмэгтэй удирдлагатай бизнест уг боломж бусад ангиллаас доогуур байна. Сонирхолтой нь орон нутгийн ЖДБ-үүд санхүүжилтэд хүрэх боломж Улаанбаатар хотынхоос илүү байна. *Санхүүгийн тайлагналт ба баталгаажуулалтын* индикатор дунд бизнесийн хувьд хүчтэй түвшинд үнэлэгдсэн бол бусад бүх ангилалд харьцуулах түвшнээс дээгүүр байна. Түүнчлэн дунд бизнесийн хувьд хоёр индикатор хүчтэй түвшинд үнэлэгдсэн нь бизнес төлөвлөлт ба санхүүгийн хувьд өөрчлөлтийг даван туулах, шинэчлэл хийх чадавх суусныг илтгэж байна (Хүснэгт 17).

ЖБД-үүдийн хувьд бизнес төлөвлөгөө боловсруулах явдал хангалтгүй байна.

Бизнесийн төлөвлөгөө нь бизнесийн үндсэн ба дэмжих үйл ажиллагааг төлөвлөж, тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлэх талаарх нарийвчилсан төлөвлөгөө юм. Бизнесийн төлөвлөгөөг боловсруулах нь бизнесээ удирдах, хянахаас гадна болзошгүй асуудлыг урьдчилан илрүүлэх, хөрөнгө оруулагчдыг татах зэрэг компанийн цаашдын өсөлтөд чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэтэл судалгаанд хамрагдсан ЖДБ-ийн бараг тал (47.5%) нь

бизнес төлөвлөгөө боловсруулдаггүй ажээ¹². Энэ нь бичил бизнес (56%), эмэгтэй удирдлагатай бизнесүүдэд (50%) илүү түгээмэл байна. Түүнчлэн бизнес төлөвлөгөө боловсруулдаг ЖДБ-үүдийн хувьд ч бүрэн хэмжээний¹³ төлөвлөгөө боловсруулах явдал хангалтгүй байна. Нийт ЖДБ-ийн зөвхөн 11% нь бүрэн хэмжээний бизнес төлөвлөгөө боловсруулсан байна. Бизнес төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүдийн тухайд санхүү ба бараа, үйлчилгээний үйлдвэрлэлийн төлөвлөгөөг түлхүү боловсруулдаг ажээ (Зураг 14). Төлөвлөгөө боловсруулдаг ЖДБ-ийн талаас дээш хувь нь нэг жилээр бизнесээ төлөвлөдөг байна. Бизнес төлөвлөлтийн дундаж хугацаа 9 сар, хамгийн ихдээ 5 жилээр, хамгийн багадаа 1 сараар төлөвлөгөөгөө хийдэг ажээ (Зураг 15).

Бизнес төлөвлөгөө боловсруулах байдал хангалтгүй байгаа нь ЖДБ-үүд ирээдүйн өсөлтөд бэлэн бус байгааг харуулж байна. Иймд бизнес төлөвлөгөөгөө боловсруулахад онцгой анхаарч, үйл ажиллагаандаа ашиглах шаардлага байна. Ингэснээр ААН бизнесийнхээ ирээдүйн өсөлт, хөгжлийн чиглэлийг тодорхойлох боломж бүрдэнэ.

Зураг 14. Бизнес төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүд (n=369)



Зураг 15. Бизнес төлөвлөгөөний хугацаа (n=369)



12. Энэхүү үр дүн Хөдөө аж ахуйн салбарын суурь судалгааны үр дүнтэй нийцэж байна. Уг судалгаагаар хөдөө аж ахуй салбарын бүртгэлтэй бизнес эрхлэгчдийн 45.7%-63.8% нь бизнес төлөвлөгөө боловсруулдаг гэжээ (Байгаль орчин, хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэн, 2023).

13. Бизнес төлөвлөгөөний 3 ба түүнээс бүрэлдэхүүн хэсгийг хамарсан бол бүрэн хэмжээний бизнес төлөвлөгөө гэж үзэв. Тухайлбал ААН санхүү, үйлдвэрлэл, хүний нөөцийн төлөвлөгөө боловсруулсан бол бүрэн хэмжээний бизнес төлөвлөгөөтөйд тооцогдоно.

ЖДБ-ийн олонх нь эрсдэл багатай эх үүсвэрээс зайлшгүй шаардлагатай санхүүгийн хэрэгцээгээ шийдэх боломжтой гэжээ¹⁴. Гэхдээ бичил болон эмэгтэй удирдлагатай бизнесийн дөрөвний нэг орчимд санхүүжилтээ шийдэх боломж хомс байна. Судалгаанд хамрагдсан ЖДБ-үүдийн 80.4% нь эрсдэл багатай эх үүсвэрээс шаардлагатай санхүүгийн хэрэгцээгээ хангах боломжтой гэжээ (Хүснэгт 18). Ялангуяа дунд хэмжээтэй бизнесийн олонх нь (90.1%) эрсдэл багатай санхүүгийн эх үүсвэрээс хэрэгцээгээ хангах боломжтой гэсэн бол бичил бизнесийн хувьд уг боломж арай хязгаарлагдмал байна. Бичил бизнесийн 77.4% нь эрсдэл багатай эх үүсвэрээс санхүүжилтээ шийдэх боломжтой гэжээ. Түүнчлэн эмэгтэй удирдлагатай компанийн хувьд энэхүү боломж эрэгтэй удирдлагатай компаниас найм орчим хувиар доогуур байна. Эрсдэл багатай санхүүжилтийн үүсвэрүүдээс банкны зээл, өөрийн хөрөнгийн эх үүсвэрийг түгээмэл ашигладаг аж. Судалгаанд хамрагдсан ЖДБ-ийн 38.8% нь банкнаас зээл авч санхүүгийн хэрэгцээгээ хангах боломжтой гэсэн бөгөөд үүнийг өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад бага зэргийн өсөлт ажиглагдаж байна. Монгол банк (2018) судалгаанд ЖДБ эрхлэгчдийн 31 орчим хувь нь тухайн хугацаанд банкнаас зээл авсан гэсэн бол MEARC (2021)-ийн судалгаагаар энэ нь 25 орчим хувь гарчээ. Бичил ба жижиг бизнесийн тухайд банкны зээлийг санхүүжилтдээ илүүтэй ашиглах хандлагатай бол дунд бизнесийн хувьд өөрийн хөрөнгөөр санхүүгийнхээ хэрэгцээг хангах явдал илүү байна. Нөгөө талаас ЖДБ-үүдийн тавны нэг (19.6%) нь эрсдэл өндөртэй, тодорхойгүй эх үүсвэрээс зайлшгүй шаардлагатай санхүүгийн хэрэгцээгээ шийднэ гэсэн бөгөөд энэ нь бичил, жижиг, эмэгтэй удирдлагатай бизнесүүдэд илүүтэй ажиглагдаж байна.

Монгол банк (2018) судалгаанд ЖДБ эрхлэгчдийн 30 орчим хувь нь санхүүгийн байгууллагын зээлийн нөхцөл хангаагүй учраас зээл авч чадаагүй гэсэн бол MEARC (2021)-ийн судалгаагаар энэ нь 23 орчим хувь гарчээ.

Гэхдээ санхүүжилт авч чадаагүй шалтгаануудыг нь авч үзвэл олонх нь компаниас үл шалтгаалах бизнесийн экосистем (зээлийн хугацаа богино, процесс удаан, чирэгдэлтэй г.м.), макро орчны (хүүгийн түвшин өндөр г.м.) шинжтэй асуудлууд давамгайлж байна.

14. Энэ судалгааны хүрээнд санхүүжилтийн хэрэгцээгээ шийдэх эх үүсвэрийн боломжийг асуусан бөгөөд яг тухайн хугацаанд санхүүжилт авсан эсэхийг асуугаагүйг тэмдэглэн хэлэх нь зүйтэй юм.

Хүснэгт 18. ЖДБ-ийн санхүүгийн боломжит эх үүсвэр, хувиар

Үзүүлэлт		Нийт (n=703)	Бизнесийн хэмжээ			Удирдлагын хүйс	
			Бичил (n=407)	Жижиг (n=165)	Дунд (n=131)	Эрэгтэй (n=404)	Эмэгтэй (n=299)
Эрсдэл багатай эх үүсвэр	Компанийн өөрийн эх үүсвэр	29.9	24.6	34.5	40.5	31.4	27.8
	Банкны зээл	38.8	40.5	37.0	35.9	41.1	35.8
	ЖДҮ-ийг дэмжих сангийн зээл	7.7	8.4	4.8	9.2	8.7	6.4
	Бусад хөнгөлөлттэй зээл	4.0	3.9	3.6	4.6	2.7	5.7
	Нийт	80.4	77.4	80.0	90.1	83.9	75.6
Эрсдэлтэй эх үүсвэр	ББСБ-ын зээл	2.1	2.0	3.6	0.8	2.0	2.3
	Ханган нийлүүлэгчийн зээл/ бартер	2.1	2.5	3.0	0.0	1.2	3.3
	Хэрэглэгчид, эсвэл хамтрагчдын урьдчилсан санхүүжилт	1.8	1.7	3.6	0.0	2.2	1.3
	Бусад хувь зээл (мөнгө зээлдэгч, найз нөхөд, хамаатан, г.м.)	2.1	2.7	1.2	1.5	2.0	2.3
	Санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй	11.4	13.8	8.5	7.6	8.7	15.1
	Нийт	19.6	22.6	20.0	9.9	16.1	24.4

ЖДБ-үүдийн хувьд санхүүгийн тайлангаа боловсруулах, түүний баталгаажуулалтыг хийлгэх явдал боломжийн түвшинд хүрсэн байгаа ч тайлагналт ба баталгаажуулалтыг хийлгэх зорилго, үр нөлөөг ухамсарлаж, цааш нэг шат ахиулах шаардлага байна. Судалгаанд хамрагдсан ЖДБ-үүдийн бараг тал (48.5%) нь бүрэн хэмжээний санхүүгийн тайлан, дөрөвний нэг (25.3%) нь санхүүгийн тайлангийн шаардлагатай хэсгийг боловсруулж, үйл ажиллагаандаа ашигладаг гэжээ (Хүснэгт 19). Бүрэн хэмжээний санхүүгийн тайланг жижиг, том, эрэгтэй удирдлагатай бизнесүүд илүүтэй боловсруулж байна. Харин ЖДБ-үүдийн 26.2% нь зөвхөн татварын зорилгоор л санхүүгийн тайлан боловсруулдаг бөгөөд энэ нь бичил бизнес (33.9%), эмэгтэй удирдлагатай бизнесүүдэд (30.4%) илүүтэй ажиглагдаж байна. ЖДБ-үүдийн олонх нь (79.4%) санхүүгийн тайландаа баталгаажуулалт хийлгэдэг бөгөөд эдгээрийн 34.7% нь хөндлөнгийн аудитаар, 44.7% нь байгууллагын дотоод хяналтаар санхүүгийн тайлангаа баталгаажуулдаг байна. Харин 20.6% нь санхүүгийн тайландаа баталгаажуулалт хийлгэдэггүй байна. Бичил бизнесийн дөрөвний нэг нь баталгаажуулалт хийлгэдэггүй бол дунд бизнесийн хувьд баталгаажуулалт хийлгэдэггүй ААН цөөн байна.

Санхүүгийн тайлагналт ба баталгаажуулалтын индикатор дундаж түвшинд үнэлэгдсэн хэдий ч ЖДБ-үүдийн хувьд (ялангуяа бичил, жижиг бизнес) санхүүгийн тайлангаа баталгаажуулах, тэр дундаа хөндлөнгийн аудитаар санхүүгийн тайлангаа баталгаажуулах явдлыг нэмэгдүүлэх шаардлага байна. Ингэснээр ЖДБ санхүүгийн

тайлангийнхаа үнэн зөв эсэхийг тогтоохоос гадна санхүүгийн сахилга батаа сайжруулах, үүсэж болох эрсдэлээс хамгаалах, цаашлаад үнэн зөв шийдвэрийг гаргах боломж бүрдэнэ.

Хүснэгт 19. ЖДБ-ийн санхүүгийн тайлагналт ба баталгаажуулалт, хувиар

Үзүүлэлт	Нийт (n=703)	Бизнесийн хэмжээ			Удирдлагын хүйс	
		Бичил (n=407)	Жижиг (n=165)	Дунд (n=131)	Эрэгтэй (n=404)	Эмэгтэй (n=299)
Санхүүгийн тайлагналт						
Бүрэн хэмжээний санхүүгийн тайлан	48.5	39.3	58.2	64.9	51.5	44.5
Санхүүгийн тайлангийн шаардлагатай хэсэг	25.3	26.8	21.8	25.2	25.5	25.1
Татварын зорилго бүхий санхүүгийн тайлан	26.2	33.9	20.0	9.9	23.0	30.4
Санхүүгийн баталгаажуулалт						
Хөндлөнгийн аудит	34.7	24.1	40.6	60.3	37.1	31.4
Байгууллагын дотоод хяналт	44.7	50.1	39.4	34.4	43.8	45.8
Баталгаажуулалт хийдэггүй	20.6	25.8	20.0	5.3	19.1	22.7

3.3.2. Ур чадвартай хүний нөөц бүрдүүлэх чадвар

Энэ үндсэн үзүүлэлтийн хүрээнд ур чадвартай хүний нөөц, *ур чадвартай хүний нөөцийг бүрдүүлэх* гэсэн хоёр индикаторыг авч үзсэн ба хоёул **харьцуулах түвшнээс дээгүүр** үнэлэгджээ (Хүснэгт 17). *Ур чадвартай хүний нөөц индикаторыг* тухайн байгууллага шаардлагад нийцсэн ур чадвартай мэргэшсэн ажилчдаар хэр хангагдсан, тухайн байгууллагыг ахалж буй гол менежерийн ажилласан жил гэсэн хоёр дэд индикатораар хэмжив. *Ур чадвартай хүний нөөцийг бүрдүүлэх* индикаторыг ажилтны сонгон шалгаруулалтын схем бүрдсэн эсэх, ажилчдынхаа чадавхыг дээшлүүлдэг эсэх гэсэн хоёр дэд индикатораар хэмжив (дэлгэрэнгүйг Хавсралт 1-ээс харна уу).

ЖДБ-ийн шинж байдлаар авч үзвэл *ур чадвартай хүний нөөцийн* индикатор бичил бизнесийн хувьд бусад ангиллаас доогуур, харин *ур чадвартай хүний нөөцийг бүрдүүлэх* индикатор бичил, худалдааны салбарын, орон нутгийн бизнесүүдэд мэдэгдэхүйц доогуур үнэлэгджээ. Харин дунд хэмжээний бизнес уг хоёр индикаторын хувьд хүчтэй түвшинд үнэлэгдсэн нь ур чадвартай хүний нөөцөө бүрдүүлсэн, хүний нөөцөө бүрдүүлэх, хөгжүүлэхэд хүчин чармайлт гаргадаг болох нь харагдаж байна (Хүснэгт 17).

ЖБД-үүдэд ур чадвартай хүний нөөц тодорхой хэмжээнд бүрдсэн ч туршлагатай тэргүүлэх менежерийн хэрэгцээ байна. Судалгаанд хамрагдсан ЖДБ-ийн 29% нь шаардлагад нийцсэн ур чадвар бүхий мэргэшсэн ажилчдаар бүрэн хангагдсан, 39.8% нь тодорхой хэмжээнд хангагдсан, 24.8% нь дунд зэрэг хангагдсан, 6.4% хангагдаагүй гэжээ (Хүснэгт 20). Тодруулбал, олонх (68.9%) нь ур чадвартай хүний нөөцтэй гэжээ.

Харин ур чадвартай хүний нөөц нь дунд зэрэг хангагдсан болон хангагдаагүй гэж хариулсан хувь бичил бизнес болон эмэгтэй удирдлагатай бизнест илүү ажиглагдаж байна. Хэдийгээр ур чадвартай хүний нөөц олонх ЖДБ-д тодорхой хэмжээгээр бүрдсэн ч тухайн бизнесийг удирдан манлайлах туршлагатай тэргүүлэх менежер¹⁵ дутагдалтай байна. Уг дэд индикатор 49.8 оноогоор үнэлэгджээ. ЖДБ-ийн тэргүүлэх менежерүүдийн дундаж ажилласан хугацаа 9.2 жил байгаа бөгөөд 38.1% нь 1-5 жил, 31.4% нь 6-10 жил, 15.7% нь 10-15 жилийн ажлын туршлагатай байна. Харин 14.1% нь 16 ба түүнээс дээш ажилласан туршлагатай тэргүүлэх менежерүүдтэй байна.

Хүснэгт 20. ЖДБ-ийн ур чадвартай хүний нөөц, хувиар

Үзүүлэлт	Нийт (n=703)	Бизнесийн хэмжээ			Удирдлагын хүйс	
		Бичил (n=407)	Жижиг (n=165)	Дунд (n=131)	Эрэгтэй (n=404)	Эмэгтэй (n=299)
Ур чадвартай хүний нөөцөөр хангагдсан эсэх						
Бүрэн хангагдсан	29.0	25.6	32.7	35.1	28.0	30.4
Тодорхой хэмжээнд хангагдсан	39.8	37.3	41.2	45.8	41.6	37.5
Дунд зэрэг хангагдсан	24.8	29.0	20.0	17.6	23.5	26.4
Хангагдаагүй	6.4	8.1	6.1	1.5	6.9	5.7
Тэргүүлэх менежерийн туршлага (ажилласан жилээр)						
Дундаж ажилласан жил	9.2	8.6	9.9	10.3	8.9	9.6
1-5 жил	38.1	43.0	35.8	26.0	39.6	36.1
6-10 жил	31.4	30.5	27.9	38.9	33.4	28.8
10-15 жил	15.7	14.7	17.0	16.8	13.1	19.1
16+ жил	14.8	11.8	19.4	18.3	13.9	16.1

ЖДБ-үүдэд ур чадвартай хүний нөөцийг бүрдүүлэх суурь бүрдсэн ч ажилчдаа хөгжүүлэх явдал хангалтгүй байна. Судалгаанд хамрагдсан ЖДБ-ийн 36.8% нь нээлттэй сонгон шалгаруулалтаар, 42.1% нь хязгаарлагдмал сонгон шалгаруулалтаар, 24.1% нь сонгон шалгаруулалтгүйгээр хүний нөөцөө бүрдүүлдэг байна (Хүснэгт 21). Бичил, жижиг, эмэгтэй удирдлагатай бизнесүүд ажилтан сонгон шалгаруулахдаа хязгаарлагдмал сонгон шалгаруулалтын аргыг түлхүү ашиглаж байна. Тодруулбал, ажлын байрыг нээлттэй зарладаг ч дан ганц удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг ажилд авдаг. Харин дунд бизнесийн тухайд нээлттэй сонгон шалгаруулалтын аргыг түлхүү ашиглаж байна. Ажлын байрыг нээлттэй зарлаад, байгууллагын ажилтан сонгон шалгаруулах дүрмийн дагуу сонгон шалгаруулалтыг хийдэг ажээ. Харин сонгон шалгаруулалтгүйгээр, танилын хүрээгээр хүний нөөцөө бүрдүүлдэг байдал бичил, жижиг бизнесүүдэд, мөн удирдлагын хүйсээс үл хамааран ажиглагдаж байна.

Судалгаанд хамрагдсан ЖДБ-ийн тавны нэг гаруй (22.1%) нь бүх ажилчдаа хамруулсан сургалтын хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлж байгаа бөгөөд эдгээрийн ихэнх нь дунд бизнесүүд байна. Гуравны нэг гаруй (35.6%) нь сургах шаардлагатай

15. 16 ба түүнээс дээш жил ажилласан менежерийг туршлагатай гэж тооцов.

ажилчнаа л сургалтад хамруулдаг гэсэн бөгөөд энэ нь бичил, жижиг бизнесүүдэд түлхүү ажиглагдаж байна. Харин дөрөвний нэг орчим (23.3%) нь сургалт явуулдаггүй болон зөвхөн төлбөргүй сургалтад л ажилчдаа хамруулдаг гэсэн бөгөөд бичил бизнесийн 29% нь уг хариултыг өгчээ.

Хүснэгт 21. ЖДБ-ийн үр чадвартай хүний нөөцийг бүрдүүлэх, хувиар

Үзүүлэлт	НИЙТ (n=703)	Бизнесийн хэмжээ			Удирдлагын хүйс	
		Бичил (n=407)	Жижиг (n=165)	Дунд (n=131)	Эрэгтэй (n=404)	Эмэгтэй (n=299)
Ажилтны сонгон шалгаруулалт						
Нээлттэй сонгон шалгаруулалт	36.8	26.3	38.2	67.9	39.4	33.4
Хязгаарлагдмал сонгон шалгаруулалт*	42.1	47.9	40.6	26.0	39.1	46.2
Сонгон шалгаруулалт байхгүй	21.1	25.8	21.2	6.1	21.5	20.4
Ажилчдын сургалтын хөтөлбөр						
Тогтмол сургалтын хөтөлбөртэй	22.1	17.2	18.2	42.0	22.0	22.1
Тогтмол бус сургалтын хөтөлбөртэй	19.1	19.7	15.8	21.4	19.1	19.1
Сургах шаардлагатай ажилчныг л сургалтад хамруулдаг	35.6	34.2	46.7	26.0	35.9	35.1
Төлбөргүй сургалтад л хамрагддаг	4.8	4.4	6.7	3.8	6.2	3.0
Сургалт явуулдаггүй	18.5	24.6	12.7	6.9	16.8	20.7

Тэмдэглэгээ: *-Тухайлбал, ажлын байрыг нээлттэй зарлаад, байгууллагын удирдлага өөрөө шийдээд ажилд авдаг.

3.3.3. Инновац ашиглах, хөгжүүлэх чадвар

Энэ үндсэн үзүүлэлтийн хүрээнд инновац ашиглалт, инновац хөгжүүлэлт гэсэн хоёр индикаторыг авч үзсэн ба инновац ашиглалт **харьцуулах түвшнээс дээгүүр**, инновац хөгжүүлэлт харьцуулах **түвшнээс доогуур** үнэлэгджээ (Хүснэгт 17). Инновац ашиглалт индикаторыг тухайн байгууллага ямар нэгэн лицензтэй программ хангамж ашигладаг эсэхээр хэмжсэн. Инновац хөгжүүлэлт индикаторыг тухайн байгууллага шинэ (инновац шингэсэн) бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхэд хүчин чармайлт гаргаж байгаа эсэх болон патент эзэмшдэг эсэх гэсэн хоёр дэд индикатораар хэмжсэн (дэлгэрэнгүйг Хавсралт 1-ээс харна уу).

ЖДБ-ийн шинж байдлаар авч үзвэл инновац ашиглалтын индикатор бичил, худалдааны салбарын, орон нутгийн, эмэгтэй удирдлагатай бизнесүүдэд доогуур үнэлэгджээ. Харин дунд бизнесийн хувьд инновац ашиглалт хүчтэй түвшинд байна. Инновац хөгжүүлэлтийн индикатор бизнесийн шинж байдлаас үл хамааран доогуур түвшинд үнэлэгдсэн бөгөөд дунд болон үйлдвэрлэлийн салбарын бизнесүүдэд арай дээгүүр үнэлэгдсэн байна (Хүснэгт 17).

ЖДБ-үүдийн талаас дээш (58.6%) нь лицензтэй программ хангамж ашиглаж байна. Жижиг (65%) ба дунд (79%) бизнесүүдийн олонх нь ямар нэгэн лицензтэй программ хангамж ашиглаж байгаа бол бичил бизнесийн хувьд тал нь ашигладаг аж

(Хүснэгт 22). Санхүү ба оффисын программ хангамжийг хамгийн түгээмэл ашиглаж байна.

Хүснэгт 22. ЖДБ-ийн инновац ашиглалт, хувиар

Үзүүлэлт	Нийт (n=703)	Бизнесийн хэмжээ			Удирдлагын хүйс	
		Бичил (n=407)	Жижиг (n=165)	Дунд (n=131)	Эрэгтэй (n=404)	Эмэгтэй (n=299)
Лицензтэй программ хангамж ашигладаг	58.6	50	65	79	61	55
Лицензтэй программ хангамж ашигладаггүй	41.4	50	35	21	39	45

ЖДБ-үүдийн олонх нь шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхэд ямар нэгэн хүчин чармайлт гаргаж байгаа ч шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний патент эзэмшлийн тоо бага байна. Судалгаанд хамрагдсан ЖДБ-ийн 35.7% нь шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжүүлэлтэд шаардагдах тоног төхөөрөмжид хөрөнгө оруулалт хийдэг, 21.5% нь шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжүүлэлтийн багтай, 12.7% нь судалгаа, хөгжүүлэлтэд тодорхой зардал төсөвлөдөг гэжээ (Хүснэгт 23). Түүнчлэн 7% нь эдгээр шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжүүлэх ажлыг хослуулдаг байна. Харин 30.2% нь шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхэд ямар нэгэн хүчин чармайлт гаргадаггүй бөгөөд энэ нь бичил, жижиг, эмэгтэй удирдлагатай бизнесүүдэд илүү ажиглагдаж байна. Судалгаанд хамрагдсан ЖДБ-ийн 11.7% нь шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний патенттай байна. Дунд бизнесийн 15.3%, жижиг бизнесийн 13.9%, бичил бизнесийн 9.6% патенттай байна.

Хүснэгт 23. ЖДБ-ийн инновац хөгжүүлэлт, хувиар


Үзүүлэлт	Нийт (n=703)	Бизнесийн хэмжээ			Удирдлагын хүйс	
		Бичил (n=407)	Жижиг (n=165)	Дунд (n=131)	Эрэгтэй (n=404)	Эмэгтэй (n=299)
Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхэд гаргадаг хүчин чармайлт						
Судалгаа, хөгжүүлэлтэд тодорхой зардал төсөвлөх	12.7	10.6	12.1	19.8	12.4	13.0
Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжүүлэлтийн багтай	21.5	18.7	23.6	27.5	21.8	21.1
Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжүүлэлтэд шаардагдах тоног төхөөрөмжид хөрөнгө оруулалт хийх	35.7	37.6	32.7	33.6	38.1	32.4
Хүчин чармайлт гаргадаггүй	30.2	33.2	31.5	19.1	27.7	33.4
Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний патентын тоо						
Нийт патентын эзлэх хувь	11.7	9.6	13.9	15.3	12.1	11.0
Дундаж патентын тоо	6.2	2.6	5.9	13.5	6.4	5.9
Хамгийн их утга	55	13	20	55	55	50

4. БИЗНЕСИЙН ЭКОСИСТЕМ

Энэ хэсэгт ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг бий болгоход дэмжлэг үзүүлэх бизнесийн экосистемийн бүрэлдэхүүнийг үнэлнэ. Үнэлгээний үр дүнд Монголын бизнесийн орчны ямар үзүүлэлт ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг дэмжиж, ямар үзүүлэлт хязгаарлаж байгааг тодорхойлох болно.

Бизнесийн экосистем нийт 23 индикатораар хэмжигдэх бөгөөд 9 нь өрсөлдөх чадварын, 6 нь холбогдох чадварын, үлдсэн 8 нь өөрчлөгдөх чадварын экосистемийг тус тус хэмжинэ. Зураг 15-д индикаторуудын үнэлгээг нэгтгэн харууллаа. Эдгээрээс 1 индикатор хүчтэй түвшинд, 16 индикатор харьцуулах түвшнээс дээгүүр, 5 индикатор харьцуулах түвшнээс доогуур, 1 индикатор сул түвшинд үнэлэгджээ. Харьцуулах түвшнээс сул үнэлэгдсэн 1 индикатор холбогдох чадварын экосистемийнх, доогуур түвшинд үнэлэгдсэн 5 индикаторын 3 нь холбогдох чадварынх, 1 нь өрсөлдөх, нөгөө нь өөрчлөгдөх чадварын экосистемийн индикаторууд байна. Энэ нь ЖДБ-ийн холбогдох чадварыг дэмжих, нөлөөлөх бизнесийн экосистем муу бүрдсэнийг илтгэнэ. Дараагийн хэсгүүдэд бизнесийн экосистемийн үнэлгээг багана бүрээр нарийвчлан авч үзэх болно.

Зураг 16. Бизнесийн экосистемийн нийт индикаторуудын нормчилсон оноо



4.1. ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг дэмжих бизнесийн экосистемийн үнэлгээ

Энэ хэсэгт ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг дэмжих бизнесийн экосистемийн баганыг хэмжихэд ашигласан индикаторуудыг дэлгэрүүлэн авч үзнэ. (Хүснэгт 24) ЖДБ-ийн (1) үйлдвэрлэлийн үр ашгийг хангах гадаад орчин, (2) нөөцийн менежментийг үр ашигтай явуулах нөхцөл, (3) чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх боломж хэр бүрдсэнийг үнэлэх замаар ЖДБ-ийн өрсөлдөх чадварын экосистемийн баганыг хэмжинэ.

Хүснэгт 24. Өрсөлдөх чадварын экосистемийн индикаторуудын нормчилсон оноо, ЖДБ-ийн шинж байдлаар

Үндсэн үзүүлэлт	Индикатор	Нийт үнэлгээ	Бизнесийн хэмжээ			Салбар			Байршил		Удирдлагын хүйс	
			Бичил	Жижиг	Дунд	Худалдаа	Үйлчилгээ	Үйлдвэрлэл	Улаанбаатар	Орон нутаг	Эрэгтэй	Эмэгтэй
Үйлдвэрлэлийн үр ашиг	Эрчим хүчний найдвартай байдал	53.5	53.5	55.8	50.8	53.3	53.6	51.2	52.4	56.1	53.1	54.1
	Зам тээвэр, дэд бүтцийн хөгжил	47.4	49.7	46.7	41.4	46.8	49.7	42.7	43.3	57.1	43.8	52.3
	Хөдөлмөрийн зах зээлийн хөгжил	55.7	55.2	58.5	54.0	57.6	55.7	52.3	56.1	54.8	54.7	57.1
	Төрийн байгууллагын үйл ажиллагаа	57.8	57.0	60.5	57.1	58.6	57.7	55.7	57.1	59.4	55.8	60.6
	Албан хэлцлийн хэрэгжилт	61.7	61.0	63.2	62.2	60.6	63.8	60.0	62.7	59.4	61.5	62.0
Нөөцийн менежмент	Дотоодын тээврийн найдвартай байдал	68.7	68.7	72.4	64.1	67.7	70.6	65.4	67.1	72.4	66.0	72.3
	Гаалийн бүрдүүлэлтийн үр ашиг	68.7	69.0	72.7	63.2	72.0	64.3	72.5	67.3	74.3	68.2	69.7
Чанарын удирдлага	Дотоодын тохирлын гэрчилгээний талаар мэдээлэл авах боломж	50.1	47.3	55.8	51.9	51.0	48.5	52.7	51.1	48.0	50.0	50.3
	Олон улсын гэрчилгээжүүлэлтийн талаар мэдээлэл авах боломж	41.7	37.3	46.5	49.2	42.1	40.1	44.0	44.8	34.6	42.2	41.1

Харьцуулах түвшин: 44.2

Индикаторын сул түвшин: ≤26.5 оноо

Индикаторын хүчтэй түвшин: ≥70.7 оноо

4.1.1. Үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх экосистем

Үйлдвэрлэлийн үр ашгийн экосистемийг *эрчим хүчний найдвартай байдал, зам тээвэр, дэд бүтцийн хөгжил, хөдөлмөрийн зах зээлийн хөгжил, төрийн байгууллагын үйл ажиллагаа, албан хэлцлийн хэрэгжилт* гэсэн таван индикатораар үнэлсэн ба бүгд **харьцуулах түвшнээс дээгүүр** үнэлэгдсэн хэдий ч **хүчтэй түвшинд** хүрсэн индикатор байхгүй байна. (Хүснэгт 24) *Эрчим хүчний найдвартай байдлын индикаторыг* ЖДБ-ийн байгууллагын ашигт ажиллагаанд цахилгаан, эрчим хүчний тасалдал хэр нөлөөлдгөөр, *зам тээвэр, дэд бүтцийн хөгжлийн индикаторыг* дотоодын зам тээврийн хөгжлөөс шалтгаалж, ЖДБ-ийн үйл ажиллагаа удааширч, саатдаг эсэхээр, *хөдөлмөрийн зах зээлийн хөгжлийн индикаторыг* шаардлагатай тооны ажилчин олдохгүйгээс шалтгаалж, ЖДБ хэр зэрэг алдагдал хүлээдгээр, *төрийн байгууллагын үйл ажиллагааны индикаторыг* засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагууд, зохицуулалт хийдэг төрийн байгууллагуудын үйл ажиллагаа ЖДБ-ийн ашигт ажиллагаанд хэр нөлөөлдгөөр, *албан хэлцлийн хэрэгжилтийн индикаторыг* хувийн хэвшлийн байгууллагууд тохирсон гэрээ, хэлцлээ хэр сайн биелүүлдгээр тус тус хэмжив. (Дэлгэрэнгүйг Хавсралт 1-ээс харна уу)

ЖДБ-ийн шинж байдлаар авч үзвэл *эрчим хүчний найдвартай байдлын индикатор* үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулдаг, дунд хэмжээний бизнесийн хувьд харьцангуй доогуур үнэлэгдсэн байна. Энэ нь манай улсын эрчим хүчний дэд бүтэц, хангамж томоохон үйлдвэрлэл явуулахад хүрэлцээ муутай, найдваргүй байгааг илтгэнэ. Үйлдвэрлэлийн үр ашгийн экосистемийг үнэлсэн индикаторууд дотроос *зам тээвэр, дэд бүтцийн хөгжлийн индикатор* хамгийн бага оноотой үнэлэгджээ. Ялангуяа, үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, дунд хэмжээний, Улаанбаатар хотод байрладаг, эрэгтэй удирдлагатай бизнесийн байгууллагуудын хувьд энэ индикатор харьцангуй доогуур байна. *Хөдөлмөрийн зах зээлийн хөгжлийн индикатор* үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, дунд хэмжээний, хөдөө орон нутгийн, эрэгтэй удирдлагатай ЖДБ-ийн байгууллагуудын хувьд бусдаас доогуур үнэлэгдсэн байна. Мөн *төрийн байгууллагын үйл ажиллагааны индикатор* бичил, дунд хэмжээний, үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, нийслэл хотод байрладаг, эрэгтэй удирдлагатай байгууллагуудын хувьд харьцангуй доогуур үнэлэгджээ. Үйлдвэрлэлийн үр ашгийн индикаторууд дотроос салбар дахь хувийн хэвшлийн байгууллагуудын *албан хэлцлийн хэрэгжилтийн индикатор* хамгийн сайн үнэлгээтэй байна.

МУ-ыг эрчим хүч, зам тээвэр, дэд бүтцийн хөгжил нь бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд саад хязгаарлалт болж байна. Ялангуяа, нийслэлд төвлөрсөн, худалдаа, үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бизнесийн байгууллагуудын ашигт ажиллагаанд улсын эрчим хүч, зам тээврийн салбарын хөгжил муугаар нөлөөлж байна. Эрчим хүч, зам тээвэр, дэд бүтцийн хангамж, хүртээмж муу, найдваргүй байдал үүсвэл улс орны аюулгүй, бие даасан байдалд нөлөөлөөд зогсохгүй бизнесийн үйл ажиллагааг доголдуулах, өсөн нэмэгдэх боломжийг хумих, ирээдүйн томоохон хөрөнгө оруулалтыг хязгаарлах сөрөг

нөлөөтэй. Судалгаанд хамрагдсан нийт 703 ААН-ийн 62.9% нь цахилгааны тасалдлаас шалтгаалж, 71.8% нь зам тээвэр, дэд бүтцийн хөгжлөөс шалтгаалж тус тус бизнесийн үйл ажиллагаанд алдагдал хүлээдэг гэж үзжээ. Эдгээр алдагдал хүлээдэг ААН-үүдийн 41.9% нь үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулдаг байхад алдагдал хүлээдэггүй гэж хариулсан ААН-үүдийн 45.4% үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг ажээ. Түүнчлэн, бичил ААН-ийн 60.7% цахилгааны тасалдлаас, 67.1% зам, тээврийн хөгжлөөс, жижиг ААН-ийн 63.0% цахилгааны тасалдлаас, 72.7% зам, тээврийн хөгжлөөс, дунд ААН-ийн 69.5% цахилгааны тасалдлаас, 85.5% зам, тээврийн хөгжлөөс шалтгаалж, тус тус бизнесийн үйл ажиллагаандаа алдагдал хүлээдэг гэж хариулснаас үзэхэд бизнесийн хэмжээ томрохын хэрээр цахилгаан, эрчим хүчний найдваргүй байдал, зам, тээврийн хөгжлийн сул байдал бизнест сөргөөр нөлөөлөх магадлал нэмэгдэж байна. Мөн, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг ААН-үүдтэй харьцуулахад Улаанбаатар хотод байрладаг ААН-үүд цахилгааны тасалдлаас үүдэж, ашигт ажиллагаанд нөлөөлсөн, зам, тээврийн хөгжлөөс шалтгаалж, бизнестээ алдагдал хүлээсэн гэж түлхүү хариулсан байна. Энэ нь **Улаанбаатарт хотод айл өрх, ААН-үүдийн төвлөрөл үүсэж, эрчим хүчний станцуудын ачаалал өссөн, замын түгжрэл нэмэгдсэн зэрэг нь бизнесийн байгууллагын ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж байгааг илтгэнэ.** МУ-ын урт хугацааны бодлого “Алсын хараа 2050”-ыг хэрэгжүүлэх дунд шатны эдийн засаг, дэд бүтцийн дэд хөтөлбөр болох “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг боловсруулах үндэслэл, суурь судалгаанд эрчим хүч, зам тээвэр, дэд бүтцийн хөгжил нь МУ-ын эдийн засгийн хөгжлийг хязгаарлагч хамгийн гол хүчин зүйлс болохыг тогтоожээ. Иймд эдгээр асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Шинэ сэргэлтийн бодлого”-оор “Эрчим хүчний сэргэлт”, “Боомтын сэргэлт”-ийг бий болгох зорилт дэвшүүлж, 2023 он хүртэл хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг төлөвлөн, хэрэгжүүлж байна. (Монгол Улсын Засгийн Газар, 2021)

Үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, орон нутагт байрладаг, дунд хэмжээний бизнесийн байгууллагууд ажиллах хүчний дутагдалд орж, үйлдвэрлэлийн үр ашиг буурах магадлалтай байна. Судалгаанд хамрагдсан 703 ЖДБ-ийн 62.6% нь шаардлагатай тооны ажилчин олдохгүйгээс шалтгаалж, байгууллага тодорхой хэмжээний алдагдал хүлээдэг гэж хариулсан нь хөдөлмөрийн зах зээл ажиллах хүчний хомсдолтой байгааг илэрхийлнэ. Ялангуяа, жижиг хэмжээний ААН-тэй харьцуулахад дунд хэмжээний ЖДБ (67.2%) дээр энэ хариулт элбэг, худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж буй ЖДБ-тэй харьцуулахад үйлчилгээ (63.1%), үйлдвэрлэл (65.5%)-ийн салбар дахь ААН-ийн хувьд нийтлэг, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ЖДБ-тэй харьцуулахад Улаанбаатар (63.7%)-т үйл ажиллагаа явуулж буй ЖДБ-үүд болон эмэгтэй удирдагчтай ЖДБ-тэй харьцуулахад эрэгтэй удирдагчтай (65.3%) ЖДБ-үүдэд илүү нийтлэг байна.

Төрийн байгууллагын үйл ажиллагаа ЖДБ-ийн ашигт ажиллагаанд тодорхой хэмжээгээр нөлөөлдөг байна. Ялангуяа, бизнесийн хэмжээ томрохын хэрээр засгийн газрын зохицуулалт бизнесийн ашигт ажиллахад сөргөөр нөлөөлдөг байж болзошгүй. Мөн, хөдөө орон нутагтай харьцуулахад нийслэлд үйл

ажиллагаа явуулж буй ЖДБ-үүдэд төрийн байгууллагын үйл ажиллагаа төвөг, чирэгдэл учруулдаг байх магадлалтай байна. Тодруулбал, судалгаанд хамрагдсан нийт 703 ЖДБ-ийн 60.2% нь төрийн байгууллагын үйл ажиллагаа бизнесийн ашигт ажиллагаанд тодорхой хэмжээгээр сөрөг нөлөө үзүүлдэг гэсэн ба бизнесийн хэмжээгээр ялгавал, жижиг ЖДБ-үүдийн 53.9%, дунд ЖДБ-үүдийн 66.4% нь төрийн зохицуулалт, засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагуудын үйл ажиллагаанаас үүдэж, алдагдал хүлээдэг гэжээ. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ЖДБ-үүдийн 54.2%, Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ЖДБ-үүдийн 62.7% тус тус засгийн газрын зохицуулалтаас үүдэж, бизнесийн үйл ажиллагаанд алдагдал хүлээдэг гэж үзсэн байна.

ЖДБ-ийн үйлдвэрлэлийн үр ашигт байдалд нөлөөлөх бизнесийн экосистемийг үнэлэх индикаторуудын дотроос хувийн хэвшлийн байгууллагуудын албан хэлцлийн хэрэгжилт хамгийн өндөр үнэлэгдсэн төдийгүй олон жил үйл ажиллагаа явуулсан ЖДБ-үүд салбар дахь хувийн хэвшлийн ЖДБ-үүдийн албан хэлцлийн хэрэгжилтийг эерэг, сайнаар үнэлэх хандлагатай байна. Судалгаанд хамрагдсан нийт 703 ЖДБ-ийн 6.4% нь салбар дахь хувийн ААН-үүд албан хэлцлээ биелүүлдэггүй гэж үзсэн бол 47.5% нь дунд түвшинд, 38.0% нь сайн, 8.1% нь маш сайн биелүүлдэг гэж үзжээ. Тэдний хариулт ЖДБ-ийн үйл ажиллагаа явуулсан жилээс хамааралтай эсэхийг шинжилж, 0.57 корреляцийн коэффициенттой гарав. Өөрөөр хэлбэл, үйл ажиллагаа явуулсан жил нэмэгдэхийн хэрээр тухайн ЖДБ салбарт хувийн хэвшлийн албан хэлцэл сайн хэрэгждэг гэж хариулах хандлага нэмэгдэж байна. Салбараар ялгаж харвал, үйлчилгээний салбарт албан хэлцлийн хэрэгжилт хамгийн өндөр (96.1%), худалдааны салбарт түүнээс арай бага (93.7%), үйлдвэрлэлийн салбарт хамгийн бага (90.0%) байна. Байршлын хувьд, орон нутагтай харьцуулахад Улаанбаатарт гэрээний хэрэгжилт илүү сайн. Эрэгтэй удирдагчтай ЖДБ (92.8%)-тэй харьцуулахад эмэгтэй удирдагчтай ЖДБ (94.6%) салбар дахь хувийн хэвшлийн албан гэрээний хэрэгжилтийг арай илүү үнэлсэн байна.

4.1.2. Нөөцийн менежментийг хангах экосистем


Нөөцийн менежментийн экосистемийг *дотоодын тээврийн найдвартай байдал, гаалийн бүрдүүлэлтийн үр ашиг* гэсэн хоёр индикатораар үнэлсэн ба бүгд **харьцуулах түвшнээс дээгүүр** үнэлэгдсэн байна. (Хүснэгт 24) *Дотоодын тээврийн найдвартай байдлын индикаторыг* дотоодын зах зээлд бараа нийлүүлэхээр тээвэрлэх явцад хэр зэрэг эвдрэл, гэмтэл гардгаар, *гаалийн бүрдүүлэлтийн үр ашгийн индикаторыг* бараа экспортлоход тухайн бараа гаалийн цэг дээр байршсанаас хойш гаалийн бүрдүүлэлт хийх хүртэл дунджаар зарцуулдаг өдөр болон тухайн ЖДБ-ийн байгууллага түүхий эд, материал, хангамжийг импортлохдоо гаалийн цэг дээр орж ирснээс хойш гаалиас нэхэмжлэх хүртэл дунджаар зарцуулдаг өдрүүдийн дунджаар үнэлэв. (Дэлгэрэнгүйг Хавсралт 1-ээс харна уу)

ЖДБ-ийн шинж чанараар авч үзвэл, бичил болон дунд бизнесүүдтэй харьцуулахад жижиг бизнесүүд дотоодын тээврийн найдвартай байдал, гаалийн бүрдүүлэлтийн


үр ашгийг илүү өндрөөр үнэлсэн байна. Үйлчилгээний салбартай харьцуулахад худалдаа, үйлдвэрлэлийн салбарын ЖДБ-үүд дотоодын тээврийн найдвартай байдлыг харьцангуй доогуур үнэлсэн бол орон нутгийн ЖДБ-үүдтэй харьцуулахад Улаанбаатарт үйл ажиллагаа явуулж буй ЖДБ-үүд дотоодын тээврийн найдвартай байдлыг арай доогуур үнэлжээ. Эрэгтэй удирдагчтай ЖДБ-үүдтэй харьцуулахад эмэгтэй удирдагчтай ЖДБ-үүд дотоодын тээврийн найдвартай байдлыг илүү өндрөөр үнэлсэн байна. Гаалийн бүрдүүлэлтийн үр ашгийн судалгаанд хамрагдсан ЖДБ-үүд харьцангуй дээгүүр үнэлэв. Ялангуяа, жижиг хэмжээтэй, худалдаа, үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, орон нутагт байрлалтай ЖДБ-үүд гаалийн бүрдүүлэлтийн үр ашгийг илүү өндрөөр үнэлсэн байна.

ЖДБ-ийн үйл ажиллагааны чиглэл, байршлаас хамаарч дотоодын тээврийн найдвартай байдалд ялгаатай үнэлгээ өгсөн байна. Өөрөөр хэлбэл, үйлчилгээний салбартай харьцуулахад худалдаа, үйлдвэрлэлийн салбарын ЖДБ эрхлэгчид дотоодын тээврийн найдвартай байдал харьцангуй доогуур үнэлгээ өгчээ. Сонирхолтой нь орон нутгийн ЖДБ-үүдтэй харьцуулахад Улаанбаатарт байршилтай ЖДБ-үүд дотоодын тээвэрт барааны эвдрэл, гэмтэл гардаг гэж үзэх хандлагатай байна. Судалгаанд хамрагдсан нийт 703 ЖДБ-ийн 55.8% нь дотоодын тээврээр бараа тээвэрлүүлэх үед эвдрэл, гэмтэл бараг гардаггүй, эсвэл бага гардаг гэж үзсэн бол 34.4% нь дунд зэрэг, үлдсэн 9.8% нь их, эсвэл маш их эвдэрч, гэмтдэг гэж үзжээ. Үүнийг ЖДБ-ийн үйл ажиллагааны чиглэлээр ялган Зураг 16-д, байршлаар ялган, Зураг 17-д тус тус үзүүлэв.

Зураг 17. Дотоодын зах зээлд бараа нийлүүлэхээр тээвэрлэхэд гардаг эвдрэлийн зэрэг, ЖДБ-ийн үйл ажиллагааны чиглэлээр, хувиар




Зураг 18. Дотоодын зах зээлд бараа нийлүүлэхээр тээвэрлэхэд гардаг эвдрэлийн зэрэг, ЖДБ-ийн байршлаар, хувиар




Нийт ЖДБ-үүдийн цөөн хувь нь гадаад худалдаа эрхэлдэг. Тодруулбал, судалгаанд хамрагдсан таван ЖДБ тутмын нэг нь импортоор бараа оруулдаг бол арван ЖДБ тутмын нэг нь экспортоор бүтээгдэхүүн гаргаж байна. Мөн, импортын гаалийн бүрдүүлэлттэй харьцуулахад экспортын гаалийн бүрдүүлэлтэд илүү хугацаа зарцуулдаг. Судалгаанд хамрагдсан 703 ЖДБ-үүдийн 75 нь буюу 10.7% нь экспортоор бараа гаргадаг ба барааг гаалийн цэг дээр хүргэснээс хойш гаалийн бүрдүүлэлт хийж дуусах хүртэл дунджаар 12.1 өдөр зарцуулдаг байна. Харин судалгаанд хамрагдсан 703 ЖДБ-үүдийн 143 нь буюу 20.3% нь импорт хийдэг ба бараа, материал гаалийн цэг дээр ирснээс хойш гаалийн бүрдүүлэлт хийж дуусах хүртэл дунджаар 8.1 өдөр зарцуулдаг байна.

Дунд хэмжээний ААН-үүд экспортын гаалийн бүрдүүлэлтэд дунджаас илүү хугацаа зарцуулж, гаалийн бүрдүүлэлтэд үр ашиггүй байна. Харин жижиг, бичил ААН-үүдийн хувьд дунд хэмжээний бизнестэй харьцуулахад гаалийн бүрдүүлэлтэд зарцуулах хугацаа дунджаас бага байх нь давамгайлж байна. Зураг 18-өөс харахад бүтээгдэхүүн экспортолдог 75 ААН-ийн 18.9% нь экспортын гаалийн бүрдүүлэлтэд дунджаас олон хоног зарцуулж, үр ашиггүй байдаг бол 20.3% нь дундаж түвшинд, үлдсэн 60.8% нь дунджаас цөөн өдрийг гаалийн бүрдүүлэлтэд зарцуулж, үр ашигтай байна. Бичил болон жижиг ААН-үүдийн хувьд ойролцоогоор 66.7%, 67.9% хувь нь тус тус экспортын гаалийн бүрдүүлэлт үр ашигтай байхад дунд хэмжээний ААН-үүдийн дөнгөж 42.1% нь үр ашигтай байна. Экспортын гаалийн бүрдүүлэлтийн үр ашгийг салбараар ялгаж үзвэл, худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж буй ЖДБ-үүд хамгийн сайн үр ашигтай буюу экспортын гаалийн бүрдүүлэлтэд хамгийн бага хугацаа зарцуулдаг байна. Харин худалдааны салбартай харьцуулахад үйлчилгээний болон үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж буй ЖДБ-үүд экспортын гаалийн бүрдүүлэлтэд илүү хугацаа зарцуулж, үр ашиг харьцангуй муу байдаг ажээ. (Зураг 19)

Зураг 19. Экспортын гаалийн бүрдүүлэлтийн үр ашиг, бизнесийн хэмжээгээр, хувиар




Зураг 20. Экспортын гаалийн бүрдүүлэлтийн үр ашиг, салбараар, давхардсан тоогоор, хувиар




Бичил бизнестэй харьцуулахад жижиг, дунд хэмжээний ААН-үүд импортын гаалийн бүрдүүлэлтэд их хугацаа зарцуулж, үр ашиггүй байх хандлагатай байна. (Зураг 20) Салбараар ангилж харвал, үйлдвэрлэлийн салбарт ажиллаж буй ААН-үүд үр ашигтай байх хандлагатай бол үйлчилгээний салбарын ААН-үүд импортын гаалийн бүрдүүлэлтэд их цаг зарцуулж, үр ашиггүй байна. (Зураг 21)

Зураг 21. Импортын гаалийн бүрдүүлэлтийн үр ашиг, бизнесийн хэмжээгээр, хувиар



Зураг 22. Импортын гаалийн бүрдүүлэлтийн үр ашиг, салбараар, давхардсан тоогоор, хувиар



4.1.3. Чанарын удирдлагыг нэвтрүүлэх экосистем

Чанарын удирдлагын экосистемийг дотоодын болон олон улсын чанарын стандартын гэрчилгээжүүлэлтийн талаар мэдээлэл авах боломжтой холбоотой хоёр индикатораар үнэлсэн ба үнэлгээний үр дүн бизнесийн экосистемийн бусад индикаторуудын үнэлгээнээс хамгийн бага үнэлгээг авав. Энэ нь МУ-д үйл ажиллагаа явуулж буй ЖДБ-үүдэд бүтээгдэхүүний чанарын хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх экосистем сул хөгжсөнийг илтгэнэ. Авч үзсэн хоёр индикаторын нэг болох *дотоодын тохирлын гэрчилгээний талаар мэдээлэл авах боломжийн индикатор харьцуулах түвшнээс дээгүүр* гарсан хэдий ч нөгөө нь болох *олон улсын гэрчилгээжүүлэлтийн талаар мэдээлэл авах боломжийн индикатор харьцуулах түвшнээс доогуур* үнэлэгдлээ. (Хүснэгт 24) (Дэлгэрэнгүйг Хавсралт 1-ээс харна уу)

ЖДБ-ийн шинж байдлаар авч үзвэл, *дотоодын тохирлын гэрчилгээний талаар мэдээлэл авах боломжийн индикатор* орон нутагт үйл ажиллагаа явуулдаг, үйлчилгээний салбарын, бичил бизнесүүдэд харьцангуй сул оноотой үнэлэгдсэн байна. *Олон улсын гэрчилгээжүүлэлтийн талаар мэдээлэл авах боломжийн индикатор* ЖДБ-ийн шинж байдлаас үл хамааран ерөнхийдөө тааруу оноотой үнэлэгджээ. Түүний дотор, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг, бичил бизнесүүдийн хувьд энэ индикатор нэлээд бага оноог авсан байна. (Хүснэгт 24)

ЖДБ-үүд дотоодын болон олон улсын чанарын гэрчилгээжүүлэлтийн талаар мэдээлэл авах боломж бага байна. Ялангуяа, хөдөө, орон нутагт үйл ажиллагаа

явуулдаг ЖДБ-үүд бүтээгдэхүүний чанарын гэрчилгээний талаар мэдээлэл авах боломж бага байна. Тодруулбал, судалгаанд хамрагдсан гурван ЖДБ-ийн нэг нь дотоодын чанарын тохирлын гэрчилгээний талаар, таван ЖДБ-ийн хоёр нь олон улсын чанарын гэрчилгээжүүлэлтийн талаар мэдээлэл бага, мэдээлэл бараг авдаггүй гэж үзжээ. Улаанбаатарт байрладаг ЖДБ-үүдийн 33.4% нь дотоодын тохирлын гэрчилгээний талаар мэдээлэл авах боломж харьцангуй сайн гэж үзсэн байхад орон нутагт үйл ажиллагаа явуулдаг ЖДБ-үүдийн 25.5% нь л энэ төрлийн мэдээлэл авах боломжтой гэжээ. Харин олон улсын чанарын гэрчилгээжүүлэлтийн талаар Улаанбаатарт байрладаг ЖДБ-үүдийн 37.5% нь мэдээлэл бараг авдаггүй гэсэн байхад орон нутгийн ЖДБ-үүдийн 51.9% нь мөн хариултыг өгсөн байна. Эндээс үзэхэд Улаанбаатарт үйл ажиллагаа явуулж буй ЖДБ-үүдтэй харьцуулахад орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ЖДБ-үүд дотоодын болон олон улсын чанарын баталгаажуулалт, гэрчилгээжүүлэлтийн талаар мэдээлэл авах боломж хомс байна.


Худалдаа, үйлдвэрлэлийн салбартай харьцуулахад үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй ЖДБ-үүд дотоод, гадаадын чанарын гэрчилгээжүүлэлтийн талаар мэдээлэл багатай байна. Судалгаанд хамрагдсан, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг гурван ЖДБ тутмын нэг нь дотоодын тохирлын гэрчилгээний талаар мэдээлэл авдаггүй байхад худалдаа, үйлдвэрлэлийн салбарын дөрвөн ЖДБ тутмын нэг нь мөн дотоодын тохирлын гэрчилгээний талаар мэдээлэл авах боломж байдаггүй гэжээ. Харин олон улсын чанарын гэрчилгээжүүлэлтийн талаар худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж буй ЖДБ-үүдийн 36.8% нь мэдээлэл авах боломж бага, 44.8% нь дунд зэрэг, 18.4% нь мэдээлэл авах боломж ихтэй гэж үзсэн бол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын ЖДБ-үүдийн 45.6%, 40.2% тус тус мэдээлэл авах боломж бага гэж үзжээ.

Жижиг, дунд хэмжээний ААН-үүдтэй харьцуулахад бичил бизнес эрхлэгчид дотоод, гадаадын чанарын баталгаажуулалт, гэрчилгээжүүлэлтийн талаар мэдээлэл авах боломж сул байна. Тодруулбал, судалгаанд хамрагдсан бичил бизнесүүдийн 33.7% нь дотоодын, 46.9% нь олон улсын чанарын гэрчилгээжүүлэлтийн талаар мэдээлэл авдаггүй, мэдээлэл авах боломж бага гэж үзжээ. Гэтэл жижиг бизнесүүдийн 35.8%, дунд хэмжээний бизнесүүдийн 33.6% нь дотоодын тохирлын гэрчилгээний талаар мэдээлэл авах боломж бага гэж үнэлсэн байна. Харин жижиг бизнесүүдийн 35.8%, дунд бизнесүүдийн 33.6% нь олон улсын гэрчилгээжүүлэлтийн талаар мэдээлэл авах боломж бага гэж үзсэн нь бичил бизнесүүдтэй харьцуулахад харьцангуй сайн үзүүлэлт юм.


Үүсгэн байгуулагдаад удаагүй, цөөн жил үйл ажиллагаа явуулсан ЖДБ-үүдтэй харьцуулахад олон жил үйл ажиллагаа явуулсан ЖДБ-үүд дотоодын болон олон улсын чанарын баталгаажуулалт, гэрчилгээжүүлэлтийн талаар мэдээлэл авах боломж ихтэй гэж үзэх хандлага давамгайл байна. Судалгаанд хамрагдсан нийт 703 ЖДБ-ын 31.0% нь дотоодын тохирлын гэрчилгээний талаар мэдээлэл авах

боломж их гэж үзсэн бол 21.9% нь олон улсын гэрчилгээжүүлэлтийн талаар мэдээлэл авах боломжтой гэжээ. Эндээс ЖДБ-үүд дотоодын чанарын гэрчилгээжүүлэлтийн мэдээлэл авах боломж илүү байдаг бол гадаадын гэрчилгээжүүлэлтийн талаар мэдээлэл авах боломж хомс байгаа нь харагдана. Иймд дотоодын болон олон улсын чанарын стандартын талаар ЖДБ-үүдэд чиглэсэн мэдээлэл түгээж, чанарын хяналт, гэрчилгээжүүлэлтийг өргөн нэвтрүүлж, ЖДБ-үүдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Зураг 23. Дотоодын тохирлын гэрчилгээний талаар мэдээлэл авах боломж, ЖДБ-ийн үйл ажиллагаа явуулсан жилээр, хувиар



Зураг 24. Олон улсын гэрчилгээжүүлэлтийн талаар мэдээлэл авах боломж, ЖДБ-ийн үйл ажиллагаа явуулсан жилээр, хувиар



4.2. ЖДБ-ИЙН ХОЛБОГДОХ ЧАДВАРЫГ ДЭМЖИХ БИЗНЕСИЙН ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ

Энэ хэсэгт ЖДБ-ийн холбогдох чадварыг дэмжих бизнесийн экосистемийн баганыг хэмжихэд ашигласан индикаторуудыг дэлгэрүүлэн авч үзнэ. (Хүснэгт 25) Тодруулбал, ЖДБ-үүд (1) хэрэглэгч, (2) ханган нийлүүлэгч, (3) салбарын институтүүдтэй холбогдох орчин, нөхцөл хэр бүрдсэнийг үнэлэх замаар ЖДБ-ийн холбогдох чадварын экосистемийн баганыг хэмжинэ.

Хүснэгт 25. Холбогдох чадварын экосистемийн индикаторуудын нормчилсон оноо, ЖДБ-ийн шинж байдлаар

Үндсэн үзүүлэлт	Индикатор	Нийт үнэлгээ	Бизнесийн хэмжээ			Салбар			Байршил		Удирдлагын хүйс	
			Бичил	Жижиг	Дунд	Худалдаа	Үйлчилгээ	Үйлдвэрлэл	Улаанбаатар	Орон нутаг	Эрэгтэй	Эмэгтэй
Хэрэглэгч	Хэрэглэгчдийн сонголт хийх боловсрол	20.3	17.8	27.1	19.7	28.2	19.4	19.5	19.2	22.9	19.6	21.3
	Хэрэглэгчтэйгээ холбогдох боломж	61.6	61.1	63.6	60.5	61.8	63.3	59.0	62.6	59.3	62.1	61.0
Ханган нийлүүлэгч	Ханган нийлүүлэгчид мэдээллээ солилцох байдал	38.2	39.6	34.8	38.2	38.5	36.9	38.2	38.8	36.8	37.0	39.9
	Ханган нийлүүлэгчдийн хамтын ажиллагаа	38.4	40.3	34.7	37.4	37.2	36.7	39.9	39.1	37.0	37.5	39.7
	Ханган нийлүүлэгчийн үнэлгээний тогтолцоо	43.9	44.5	38.5	48.9	43.1	41.6	46.2	44.6	42.3	43.4	44.5
Институт	Салбарын байгууллагуудын хамтын ажиллагааны орчин	47.5	44.3	50.6	53.4	45.8	48.6	47.9	48.0	46.5	47.8	47.1

Харьцуулах түвшин: 44.2

Индикаторын сул түвшин: ≤26.5 оноо

Индикаторын хүчтэй түвшин: ≥70.7 оноо

4.2.1. Хэрэглэгчтэйгээ холбогдох экосистем

ЖДБ-үүд хэрэглэгчтэйгээ холбогдох экосистемийг хоёр индикатораар үнэлсэн ба эхний индикатор болох *хэрэглэгчдийн сонголт хийх боловсролын индикатор сул түвшинд*, хоёр дахь индикатор болох *хэрэглэгчтэйгээ холбогдох боломжийн индикатор харьцуулах түвшнээс дээгүүр* үнэлэгдлээ. (Хүснэгт 25) Хэрэглэгчдийн сонголт хийх боловсролын *индикаторыг* хэрэглэгчид сонголт хийхдээ бүтээгдэхүүний чанар, үнэ, брэнд, өнгө, үзэмж, загвар, зар сурталчилгаа зэрэг хүчин зүйлсээс ямар хүчин зүйлсийг илүү чухалчилж байгаад тулгуурлан үнэлсэн бол ЖДБ-үүд *хэрэглэгчтэйгээ холбогдох боломжийн индикаторыг* судалгаанд хамрагдсан ЖДБ-үүд хэрэглэгч, үйлчлүүлэгчтэйгээ холбогдоход хэр хүндрэл, бэрхшээлтэй тулгардгийг тодруулах замаар хэмжив. (Дэлгэрэнгүйг Хавсралт 1-ээс харна уу)

ЖДБ-ийн шинж байдлаар авч үзвэл *хэрэглэгчдийн сонголт хийх боловсрол индикатор* худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж буй, жижиг бизнесүүдийн хувьд харьцангуй сайн үнэлэгдсэн бол үйлчилгээ, үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулдаг, бичил, дунд бизнесүүдийн хувьд доогуур оноотой үнэлэгдэв. Түүнчлэн, энэ индикатор ЖДБ-ийн байршил, удирдлагын хүйсийн ялгаанаас

хамаарахгүйгээр сул түвшинд үнэлэгдсэн байна. Харин судалгаанд хамрагдсан ЖДБ-үүд хэрэглэгч, үйлчлүүлэгчтэйгээ холбогдох боломжийг харьцуулах түвшнээс дээгүүр үнэлсэн хэдий ч оноо нь хүчтэй түвшинд хүрээгүй байна. (Хүснэгт 25)

Хэрэглэгчид сонголт хийхдээ олон хүчин зүйлсийг харгалздаггүй байдал нь тухайн ЖДБ эрхлэгч хэрэглэгчийн сэтгэл ханамж, хэрэгцээ, төсөвт нийцсэн бараа, үйлчилгээ нийлүүлэхээр хэрэглэгчтэйгээ холбогдох боломжийг хязгаарлаж байна.

Өөрөөр хэлбэл, судалгаанд хамрагдсан 703 ЖДБ-ийн 420 нь буюу 59.7% нь хэрэглэгч бүтээгдэхүүний чанар, үнэ, брэнд, өнгө, үзэмж, загвар, зар сурталчилгаа зэрэг хүчин зүйлсээс зөвхөн нэгийг чухалчилж, сонголт хийдэг гэж үзсэн байхад үлдсэн 283 ЖДБ буюу 40.3% нь хэрэглэгч хоёр хүчин зүйлийг харгалзаж, сонголтоо хийдэг гэжээ. Хэрэглэгч гурав болон түүнээс олон хүчин зүйлийг харгалзан сонголт хийдэг гэж үзсэн ЖДБ эрхлэгч байхгүй байна.

Судалгаанд хамрагдсан 10 ЖДБ тутмын нэг нь хэрэглэгчтэйгээ холбогдоход хүндрэл, бэрхшээл ихтэй гэж үзсэн. Ялангуяа, хөдөө, орон нутагт байрладаг, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, эмэгтэй удирдагчтай, бичил бизнес эрхлэгчид хэрэглэгчтэйгээ холбогдоход хүндрэл, бэрхшээлтэй байна.

Тодруулбал, судалгаанд хамрагдсан, Улаанбаатарт байрладаг ЖДБ-үүдийн 7.5% нь хэрэглэгчтэйгээ холбогдоход бэрхшээлтэй гэж хариулсан байхад орон нутагт үйл ажиллагаа явуулдаг ЖДБ-үүдийн 13.7% нь хэрэглэгчтэйгээ холбогдоход хүндрэл, бэрхшээлтэй гэжээ. Мөн жижиг бизнес эрхлэгчдийн 7.9%, дунд хэмжээний бизнес эрхлэгчдийн 8.4% нь хэрэглэгчтэйгээ холбогдоход бэрхшээлтэй гэсэн байхад бичил бизнес эрхлэгчдийн 10.3% нь хэрэглэгчтэйгээ холбогдоход хүндрэлтэй гэж үзжээ. Эрэгтэй удирдагчтай ЖДБ-үүдийн 8.4% хэрэглэгчтэйгээ холбогдоход бэрхшээлтэй гэсэн байхад эмэгтэй удирдагчтай ЖДБ-үүдийн 10.7% ингэж үзсэн байна. Харин үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ЖДБ-үүдийн 8.5%, худалдааны чиглэлийн ЖДБ-үүдийн 9.8% тус тус хэрэглэгчтэйгээ холбогдоход бэрхшээлтэй гэсэн бол үйлчилгээний салбарын ЖДБ-үүдийн 10.0% нь хэрэглэгчтэйгээ холбогдоход бэрхшээлтэй гэжээ. Эндээс үзэхэд, үйлдвэрлэлийн салбар дахь ЖДБ-тэй харьцуулахад худалдаа, үйлчилгээний салбарын ЖДБ-үүд хэрэглэгчтэйгээ холбогдоход хүндрэл, бэрхшээлтэй байх хандлагатай байна.

4.2.2. Ханган нийлүүлэгчтэй холбогдох экосистем

ЖДБ-үүд ханган нийлүүлэгчтэйгээ холбогдох экосистемийг ханган нийлүүлэгчид мэдээллээ солилцох байдал, ханган нийлүүлэгчдийн хамтын ажиллагаа, ханган нийлүүлэгчийн үнэлгээний тогтолцоо гэсэн гурван индикатораар үнэлсэн ба гурвуул харьцуулах түвшнээс доогуур үнэлэгдлээ. (Хүснэгт 25) Ханган нийлүүлэгчдийн мэдээллээ солилцох байдлын индикаторыг тухайн салбарт үйл ажиллагаа явуулж буй ЖДБ-үүд өөр хоорондоо мэдээллээ хэр нээлттэй, чөлөөтэй солилцдог эсэхээр, ханган нийлүүлэгчдийн хамтын ажиллагааны индикаторыг салбар дахь ханган нийлүүлэгчдийн хамтын ажиллагааны талаар судалгаанд оролцогч ЖДБ-үүдийн үнэлгээгээр, ханган нийлүүлэгчийн үнэлгээний тогтолцооны индикаторыг салбар

дахь ханган нийлүүлэгч бие биеэ үнэлэх тогтолцоотой эсэхээр хэмжлээ. (Дэлгэрэнгүйг Хавсралт 1-ээс харна уу)

ЖДБ-ийн шинж байдлаар авч үзвэл, *ханган нийлүүлэгчид мэдээллээ солилцох байдлын индикатор* орон нутагт байрладаг, үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, жижиг бизнесүүдийн хувьд харьцангуй бага оноотой байна. *Ханган нийлүүлэгчдийн хамтын ажиллагааны индикатор* үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, жижиг бизнесүүдийн хувьд бусдаас доогуур үнэлгээтэй гарчээ. Ханган нийлүүлэгчийн үнэлгээний тогтолцооны индикатор бусадтай харьцуулахад жижиг бизнесүүдийн хувьд нэлээд доогуур оноогоор үнэлэгджээ. (Хүснэгт 25)

4.2.3. Институтүүдтэй холбогдох экосистем

ЖДБ-үүд салбарын институтүүдтэйгээ холбогдох экосистемийг *салбарын байгууллагуудын хамтын ажиллагааны орчин* гэсэн ганц индикатораар үнэлсэн ба индикаторын утга **харьцуулах түвшнээс дээгүүр** үнэлэгдлээ. (Хүснэгт 25) *Салбарын байгууллагуудын хамтын ажиллагааны орчны индикаторыг* судалгаанд хамрагдсан ЖДБ-үүд салбарын холбоод, худалдаа аж үйлдвэрийн танхим, бусад худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих байгууллагууд хамтран ажиллах орчин, экосистем хэр бүрдсэн гэж үнэлж байгаагаар хэмжив.

Жижиг, дунд ААН-үүдтэй харьцуулахад бичил бизнес эрхлэгчид салбарын байгууллагууд хамтран ажиллах орчин, систем бүрдээгүй гэж үзэх хандлагатай байна. Тодруулбал, дунд хэмжээний ААН-үүд салбарын байгууллагуудын хамтын ажиллагааны орчныг 53.4 оноогоор үнэлсэн бол жижиг ААН-үүд 50.6 оноогоор, бичил ААН-үүд 44.3 оноогоор үнэлжээ. Судалгаанд хамрагдсан дунд хэмжээтэй ААН-ийн 18.3% нь, бичил ААН-үүдийн 32.7% нь тус тус салбарын холбоод, худалдаа аж үйлдвэрийн танхим, бусад худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих байгууллагууд хамтран ажиллах орчин, экосистем бүрдээгүй гэж үзсэн байна.

4.3. ЖДБ-ийн өөрчлөгдөх чадварыг дэмжих бизнесийн орчны үнэлгээ

Энэ хэсэгт ЖДБ-ийн өөрчлөгдөх чадварыг дэмжих бизнесийн экосистемийн баганыг хэмжихэд ашигласан индикаторуудыг дэлгэрүүлэн авч үзнэ. (Хүснэгт 26) ЖДБ-ийн (1) бизнес төлөвлөлт, санхүүжилтийн орчин, (2) үр чадвартай ажиллах хүч олох, ажиллуулах боломж, (3) инновац нэвтрүүлэх боломж хэр бүрдсэнийг үнэлэх замаар ЖДБ-ийн өөрчлөгдөх чадварын экосистемийн баганыг хэмжинэ.

Хүснэгт 26. Өрсөлдөх чадварын экосистемийн индикаторуудын нормчилсон оноо, ЖДБ-ийн шинж байдлаар

Үндсэн үзүүлэлт	Индикатор	Нийт үнэлгээ	Бизнесийн хэмжээ			Салбар			Байршил		Удирдлагын хүйс	
			Бичил	Жижиг	Дунд	Худалдаа	Үйлчилгээ	Үйлдвэрлэл	Улаанбаатар	Орон нутаг	Эрэгтэй	Эмэгтэй
Бизнес төлөвлөлт ба санхүү	Санхүүгийн хүртээмж	83.6	83.7	83.0	84.0	84.3	80.4	86.0	83.6	83.6	84.7	82.2
	Санхүүгийн хүртээмжийн нөлөө	53.0	50.7	54.7	57.8	51.0	56.1	50.4	54.1	50.4	51.6	54.8
Ур чадвар	Ур чадвартай ажиллах хүчний хүрэлцээ	54.2	53.1	55.9	55.3	52.9	55.4	51.9	56.2	49.5	55.4	52.5
	Ур чадвартай ажиллах хүчний хүртээмжийн нөлөө	58.5	58.4	61.2	55.5	57.5	59.5	56.1	60.6	53.8	57.9	59.4
	Салбарын сургалтын байгууллагын хүртээмж, чанар	46.9	48.6	45.8	42.9	49.3	44.9	48.5	45.5	50.1	47.2	46.4
Инноваци	Бизнес эрхлэх лиценз, зөвшөөрөл	56.2	54.8	58.9	57.3	58.0	59.3	50.7	57.2	54.0	55.9	56.7
	Патент, лиценз, зөвшөөрлийн зардал	48.8	49.5	49.1	46.4	51.9	49.3	46.4	48.9	48.6	49.6	47.8
	Инновацийн төлөөх мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагаа	43.5	42.0	45.6	45.8	42.7	42.6	45.4	43.1	44.6	44.2	42.6

Харьцуулах түвшин: 44.2

Индикаторын сул түвшин: ≤26.5 оноо

Индикаторын хүчтэй түвшин: ≥70.7 оноо

4.3.1. Санхүүжилт авах боломж, экосистем

ЖДБ-үүд санхүүжилт авах боломж, экосистем хэр бүрдсэнийг хоёр индикатораар үнэлсэн ба эхний индикатор болох *санхүүгийн хүртээмжийн индикатор хүчтэй түвшинд*, хоёр дахь индикатор болох *санхүүгийн хүртээмжийн нөлөөний индикатор харьцуулах түвшнээс дээгүүр* үнэлэгдлээ. (Хүснэгт 26) *Санхүүгийн хүртээмжийн индикаторыг* санхүүжилт авах эх үүсвэрүүдээс тухайн салбарт аль нь түгээмэл байдгийг тодорхойлох замаар, *санхүүгийн хүртээмжийн нөлөөний индикаторыг* судалгаанд хамрагдсан ЖДБ-ийн одоогийн үйл ажиллагаанд санхүүжилт олох боломж хэр зэрэг саад болж байгааг үнэлүүлэх замаар тус тус хэмжлээ. (Дэлгэрэнгүйг Хавсралт 1-ээс харна уу)

Санхүүгийн хүртээмжийн индикатор ЖДБ-ийн шинж, байдлаас үл хамаарч, өндөр оноогоор, хүчтэй түвшинд үнэлэгдсэн. Түүнчлэн, *санхүүгийн хүртээмжийн нөлөөний индикатор* ЖДБ-ийн шинж, байдлаас үл хамаарч, харьцуулах түвшнээс өндөр гарсан хэдий ч хүчтэй түвшинд хүрээгүй.

4.3.2. Ур чадвартай ажиллах хүч олох, ажиллуулах боломж, экосистем

ЖДБ-үүд ур чадвартай ажиллах хүч олох, ажиллуулах боломж, экосистемийг ур чадвартай ажиллах хүчний хүрэлцээний индикатор, ур чадвартай ажиллах хүчний хүртээмжийн нөлөө, салбарын сургалтын байгууллагын хүртээмж, чанар гэсэн гурван индикатораар үнэлсэн ба индикаторууд бүгд **харьцуулах түвшнээс дээгүүр** оноогоор үнэлэгдлээ. (Хүснэгт 26)

ЖДБ-ийн шинж байдлаар авч үзвэл ур чадвартай ажиллах хүчний хүрэлцээний индикатор Улаанбаатарт байрладаг, эрэгтэй удирдлагатай, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, жижиг, дунд хэмжээтэй бизнесүүдэд харьцангуй өндөр оноогоор үнэлэгдсэн бол орон нутагт байрладаг, эмэгтэй удирдагчтай, бичил бизнесүүдэд харьцангуй доогуур үнэлэгдсэн байна. Ур чадвартай ажиллах хүчний хүртээмжийн нөлөөний индикатор орон нутагт байрладаг, дунд хэмжээний бизнесүүдэд харьцангуй бага оноотой үнэлэгдсэн байна. Ур чадвартай ажиллах хүчтэй холбоотой эдгээр индикаторуудын үнэлэгдсэн утгаас харахад орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ЖДБ-үүд ур чадвартай ажиллах хүч олох, ажиллуулахад хүндрэлтэй байдаг нь ажиглагдаж байна. Мөн бизнесийн хэмжээ, цар хүрээнээс хамаарч, ур чадвартай ажиллах хүчний хүрэлцээ, хүртээмжийн нөлөө ялгаатай байна. Ур чадвартай ажиллах хүчний экосистемийн үнэлгээнд ашигласан индикаторууд дотроос салбарын сургалтын байгууллагын хүртээмж, чанарын индикатор хамгийн бага оноогоор үнэлэгджээ. Түүний дотор, Улаанбаатар хотод байрлалтай, жижиг, дунд хэмжээтэй бизнесийн байгууллагууд салбарын сургалтын байгууллагын хүртээмж, чанарыг харьцангуй бага оноогоор үнэлсэн байна.

4.3.3. Инновац нэвтрүүлэх боломж, экосистем

ЖДБ-үүд инновац нэвтрүүлэх боломж, экосистемийг бизнес эрхлэх лиценз, зөвшөөрөл, патент, лиценз, зөвшөөрлийн зардал, инновацын төлөөх мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагаа гэсэн мөн гурван индикатораар үнэлсэн ба индикаторууд бүгд **харьцуулах түвшнээс дээгүүр** оноогоор үнэлэгдсэн байна. (Хүснэгт 26)

ЖДБ-ийн шинж байдлаар авч үзвэл бизнес эрхлэх лиценз, зөвшөөрлийн индикатор худалдаа, үйлчилгээний салбарт харьцангуй өндөр оноогоор үнэлэгдсэн бол үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж буй ЖДБ-үүдийн хувьд харьцангуй бага оноогоор үнэлжээ. Энэ нь үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахад үйл ажиллагаа явуулах тусгай лиценз, зөвшөөрөл авах шаардлага үүсдэг ба тэдгээр лиценз, зөвшөөрлийг авахад хөрөнгө, нөөц зарцуулах нь ЖДБ-ийн үйл ажиллагаанд нөлөөлдгийг илтгэнэ. Патент, лиценз, зөвшөөрлийн зардлын индикатор

худалдааны салбарт хамгийн өндөр оноогоор үнэлэгдсэн бол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, дунд хэмжээний, эмэгтэй удирдагчтай ЖДБ-үүдийн хувьд харьцангуй бага оноогоор үнэлэгдсэн байна. Инновацыг нэвтрүүлэх боломж, экосистемийг үнэлэх индикаторууд дотроос *инновацын төлөөх мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагааны индикатор* хамгийн муу буюу харьцуулах түвшнээс доогуур үнэлгээ авсан байна. Ялангуяа, эмэгтэй удирдагчтай, худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, бичил бизнесүүдийн хувьд энэ индикатор доогуур үнэлэгджээ. Энэ нь инновацын төлөө салбарын мэргэжлийн байгууллагууд хамтарч ажиллах шаардлагатай байгааг илтгэнэ.

5. МАКРО ОРЧИН

5.1. ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Бараа, үйлчилгээ, үйлдвэрлэлийн хүчин зүйл, санхүүгийн зах зээлүүд үр ашигтай ажиллах суурь нөхцөлийг бүрдүүлэхэд макро орчин (national environment) нэн чухал. Тодруулбал, аливаа улсын засгийн газраас эдийн засаг, бизнесийн орчны тухайд хэрэгжүүлж байгаа бодлого аль ч салбарт бизнес эрхлэхэд амар хялбар, цаашилбал, бүх түвшинд (микро, месо, макро) институтийн сайн орчныг бүрдүүлэхэд зайлшгүй чиглэж байх ёстой. Өрсөлдөх чадварын *макро орчин* гэсэн түвшин нөөцийн хангагдсан байдал, дэд бүтэц, засаглал, олон улсын худалдааны бодлого, бизнес эрхлэх амар хялбар байдал, бизнесийн орчны талаар баримталж буй бодлогууд зэрэг үндэсний түвшин дэх бүх хүчин зүйлийг агуулна. Хүснэгт 27-д Олон улсын худалдааны төв (ОУХТ)-ийн *Жижиг, дунд үйлдвэрийн өрсөлдөх чадварын хэтийн төлөв тайлан*-д авч үздэг эдийн засгийн гол үзүүлэлтийг Монгол Улсын хувьд хамгийн сүүлийн байдлаар харууллаа. Эндээс харвал эдийн засгийн өсөлт, хөгжлийн суурь хэмжүүр болох ДНБ 2022 онд 52.9 их наяд төгрөг болсон бол худалдан авах чадварын паратит (ХАЧП)-аар хэмжсэн нэг хүнд ноогдох ДНБ 11,832 ам.долларт хүрчээ. Дэлхийн банкны Атласын аргаар тооцсон нэг хүнд ноогдох үндэсний нийт орлого (ҮНО)-ын ангиллаар Монгол Улс дундаас доогуур (1,136 ба 4,465 ам.долларын хооронд байх) гэсэн ангилалд багтаж байна. 2022 оны байдлаар манай улсын дэлхийн ДНБ-д эзлэх хувь маш бага буюу 0.03% байна.

Хүснэгт 27. Монгол Улсын эдийн засгийн гол үзүүлэлтүүд

#	Үзүүлэлт	Утга	Он
1	Хүн ам (саяар)	3.46	2022 ¹
2	Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ), (тэрбум төгрөгөөр)	52,867.37	2022 ¹
3	Нэг хүнд ноогдох ДНБ (ХАЧП, ам.доллараар)	11,832.14	2022 ¹
4	Дэлхийн ДНБ-д эзлэх хувь (ХАЧП, хувиар)	0.03	2022 ¹
5	Худалдааны тэнцлийн илүүдэл/алдагдал (ДНБ-д эзлэх хувиар)	-15.76	2022 ¹
6	Тарифын хөнгөлөлтийн зөрүү (хувиар)	0.0565	2019 ²
7	Импорт ба экспорт (бараа, үйлчилгээ, ДНБ-д эзлэх хувиар)	126.56	2022 ^{1,2}
8	Үйлчилгээний экспорт (нийт экспортод эзлэх хувиар)	9.04	2022 ²
9	Газарзүйн бүс	Зүүн Ази ³	
10	Орлогын ангилал	Дундаас доогуур орлого	2022 ⁴

Эх сурвалж:

(1): World Economic Outlook: A Rocky Recovery, April 2023, IMF

(2): International Trade Centre: <https://marketanalysis.intracen.org>

(3): United Nations: <https://unstats.un.org/unsd/methodology/m49>

(4): World Bank: <https://datahelpdesk.worldbank.org/knowledgebase/articles/906519-world-bank-country-and-lending-groups>

5.2. ЭДИЙН ЗАСГИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ

Дэлхийн ихэнх улс орон, тэр дундаа буурай хөгжилтэй, хөгжиж буй орнууд Ковид-19 цар тахлын дараа харьцангуй удаан сэргэж байна гэдгийг Дэлхийн банк, Олон улсын валютын сан, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагууд эдийн засгийн хэтийн төлөв тайландаа удаа дараа онцолсоор байгааг тэмдэглэх нь зүйтэй. Жижиг, дунд бизнес эрхлэгчид дэлхийн эдийн засгийн ирээдүйн төлөв төдийгүй өөрийн болон хөрш улс орнуудын ирээдүйн хандлагын талаар тодорхой мэдээлэлтэй байж, өөрийн ажиллаж байгаа салбар, байгууллагын түвшинд шийдвэр гаргахдаа эдгээр мэдээллийг тогтмол ашиглаж байх нь чухал байдаг. Манай улсын төрийн байгууллага, хувийн секторын ямар нэг байгууллага богино, дунд, урт хугацааны эдийн засгийн төсөөллийн талаар судалгаа хийж, олон нийтэд танилцуулдаггүй. Гэхдээ бусад улс орны төв банкуудын ашигладаг орчин судалгааны аргазүйг ашиглаж, богино, дунд хугацааны эдийн засгийн төсөөллийг зөвхөн Монголбанк улирал тутам хийдэг боловч олон нийтэд зарладаггүй, уг мэдээлэл мөнгөний бодлогын хорооны хуралд нүүцэн зэрэглэлтэйгээр зориулагддаг. Жижиг, дунд бизнес эрхлэгчид хугацааны хоцрогдолтойгоор Монголбанкнаас эрхлэн гаргадаг улирал тутмын *Инфляцын тайлан*, жил тутмын *Санхүүгийн тогтвортой байдлын тайлан*-гаас эдийн засгийн хэтийн төлөвийн талаарх тодорхой мэдээллийг авах боломжтой. Иймд олон нийт олон улсын байгууллагуудын хийдэг эдийн засгийн хэтийн төлөвийн талаарх судалгааны мэдээллийг шийдвэр гаргалтдаа ихэнх тохиолдолд хэрэглэдэг. Хүснэгт 28-д ДБ, ОУВС, АХБ-ны хийсэн 2023, 2024 оны эдийн засгийн өсөлт, инфляцын түвшин, урсгал тэнцлийн алдагдал/илүүдлийн төсөөллийг харуулав. Эдгээр байгууллагын хийсэн төсөөллүүд зөрүүтэй байгаа нь богино, дунд, урт хугацааны эдийн засгийн хэтийн төлөвийг таамаглахад ашиглаж байгаа онолын болон эмпирик загварууд, эдгээр загварт ашигласан урьдач нөхцөлүүд ялгаатай байдагтай холбоотой.

Хүснэгт 28. Монгол Улсын эдийн засгийн хэтийн төлөв

Макро үзүүлэлт	2022				2023			2024		
	ДБ ¹		ОУВС ²	АХБ ³	ДБ	ОУВС	АХБ	ДБ	ОУВС	АХБ
ДНБ-ий өсөлт, %	4.7	5.0	5.0	5.2	5.5	5.7	6.3	4.5	5.9	
Инфляцын түвшин, %	-	13.2	15.2	-	11.7	10.5	-	12.8	8.6	
Урсгал тэнцэл*, %	-	-13.4	-	-	-10.9	-	-	-12.6	-	

Эх сурвалж:

- (1): Дэлхийн банкны “Дэлхийн эдийн засгийн хэтийн төлөв: 2023 оны 6-р сарын тайлан”
- (2): Олон улсын валютын сангийн “Дэлхийн эдийн засгийн хэтийн төлөв: 2023 оны 10-р сарын тайлан”
- (3): Азийн хөгжлийн банкны “Азийн хөгжлийн хэтийн төлөв: 2023 оны 9-р сарын тайлан”

Тэмдэглэгээ: * - Урсгал тэнцлийн алдагдал/илүүдэл ДНБ-д эзлэх хувиар тооцсон болно.

2023 оны ДНБ-ий өсөлтийн таамаглалыг ДБ, ОУВС, АХБ тун ойролцоо таамагласан байна. Харин 2024 оны хувьд хамгийн өөдрөг эдийн засгийн өсөлтийн таамаглал (6.3%)-ыг ДБ хийсэн бол ОУВС 4.5% гэж хамгийн бага төсөөллийг хийжээ. ОУВС, АХБ-ны хийсэн 2023 оны инфляцын түвшний таамаглал тун ойролцоо буюу харгалзан

11.7%, 10.5% байгаа бол 2024 оных нэлээд зөрүүтэй харагдаж байна. Манай улсын эдийн засгийн өсөлтийн гол хүчин зүйл болох уул уурхайн салбар, цаашилбал, түүхий эдийн экспортын орлого манай үрд хөрш Хятадын түүхий эдийн эрэлтээс хүчтэй хамааралтай тул бид Хятадын эдийн засгийн 2023, 2024 оны хэтийн төлөв, олон улсын байгууллагууд Хятад, бүс нутгийн эдийн засагт ямар эерэг, сөрөг шокууд тохиолдож болох талаар онцолж байгааг анхааралтай ажиглах нь зүйтэй. 2023, 2024 оны хувьд дотоод эдийн засаг дахь хамгийн том сорилт бол инфляцын түвшнийг хэрхэн тогтворжуулах, Монголбанк үүний эсрэг богино, дунд хугацаанд ямар бодлого баримтлах вэ чухал юм. Үүний зэрэгцээгээр 2024 онд УИХ-ын сонгууль болох тул улсын төсөв талаас инфляц дээр хэр хэмжээний дарамт ирэх вэ гэдэг нь улсын төсвийн зарлагын өсөлтөөс ихээхэн хамаарна. Сүүлийн жилүүдэд гадаад өрийн хэмжээ хурдацтай өсөж байгаа холбоотойгоор төсвийн бодлого талаас 2024 онд том дүнтэй гадаад өрийн эргэн төлөлтийг хэрхэн хийх вэ гэдэг нь манай эдийн засагт нэг том эрсдэлийг бий болгоно.

5.3. БАГАНА БА ИНДИКАТОРЫН ҮНЭЛГЭЭ

Аргазүй хэсэгт авч үзсэний дагуу макро орчин түвшний гурван багана болох өрсөлдөх, холбогдох, өөрчлөгдөх чадваруудын дундаж оноо, индикаторуудын нормчилсон оноог тус тус Хүснэгт 29-д харууллаа. Өрсөлдөх, холбогдох, өөрчлөгдөх чадваруудын нормчилсон дундаж оноо манай улсын хувьд харгалзан 39.2, 57.1, 77.4 гарчээ. Өрсөлдөх чадварын баганын дундаж оноо, 39.2 доогуур ангилалд үнэлэгдэж байгаа бөгөөд энэ багана долоон индикатораас бүрдэнэ. Логистик гүйцэтгэлийн индекс сул, онцгой тариф, ISO 9001 чанарын гэрчилгээ, ISO 14001 хүрээлэн буй орчны гэрчилгээ тус тус харьцуулах түвшнээс доогуур (26.5-аас 44.2-ын хооронд байх), үйлчилж буй тариф, засаглалын индекс тус тус дээгүүр (44.2-оос 70.7-ийн хооронд байх) гэж үнэлэгджээ. Өгөгдөл байхгүйн улмаас техникийн зохицуулалтын тоог тооцох боломжгүй байв. Өрсөлдөх чадварын баганын үнэлгээг хойш татаж байгаа хамгийн бага утгатай гурван индикатор бол логистик гүйцэтгэлийн индекс, ISO 9001 чанарын гэрчилгээ, ISO 14001 хүрээлэн буй орчны гэрчилгээ байна. Гэхдээ уг баганын хувьд хүчтэй үнэлэгдэх индикатор байхгүй байгааг бид анхаарах хэрэгтэй юм. Иймд бусад индикаторын хувьд ч мөн сайжруулах зайлшгүй шаардлагатай. Тухайлбал, Дэлхийн банкны жил бүр тооцдог макро түвшинд засаглалын чанарыг тодорхойлох засаглалын индексийн дуу хоолой ба хариуцлагатай байдал, улс төрийн тогтвортой байдал ба хүчирхийлэл, терроризмгүй байх, засгийн газрын үр ашигт байдал, зохицуулалтын чанар, хуулийн хэрэгжилт, авлигын хяналт гэсэн 6 талбарын ихэнх талбарт Монгол Улс муу үнэлгээтэй байгаа, мөн зарим талбарын индекс жил ирэх тусам муудаж байгааг манай улсын бодлогын шийдвэр гаргагчид анхааралдаа авах нь зүйтэй юм.

Хүснэгт 29. Макро орчин (Нормчилсон оноо)

Өрсөлдөх чадвар	39.2
Үйлчилж буй тариф	58.6*
Техникийн зохицуулалтын тоо	-
Онцгой тариф	42.6*
Логистик гүйцэтгэлийн индекс	25.0
ISO 9001 чанарын гэрчилгээ	33.2*
ISO 14001 хүрээлэн буй орчны гэрчилгээ	29.4*
Засаглалын индекс	46.6
Холбогдох чадвар	57.1
Өрхийн МХТ-ийг ашиглах боломж	35.2*
Телефон хэрэглэгчийн тоо	58.6*
Интернэт хэрэглэгчийн тоо	60.0*
Хүртээмжтэй интернэтийн индекс	68.9
Засгийн газрын онлайн үйлчилгээ	62.6
Өөрчлөгдөх чадвар	77.4
Хүүгийн түвшний зөрүү	76.8
Суралцсан жил	85.6
Патентын өргөдлийн тоо	60.9*
Барааны тэмдэгтийн бүртгэл	86.4*
Харьцуулах түвшин: 44.2	
Индикаторын сул түвшин: ≤26.5 оноо	Индикаторын хүчтэй түвшин: ≥70.7 оноо

Тэмдэглэгээ: * - Өгөгдлийн боломжгүй байдлаас шалтгаалж, 2019, 2021 онуудын дунджаар нормчилсон оноог тооцсон болно.

Тайлбар: Индикаторуудын өгөгдлийг олон эх сурвалжаас авч байгаа учраас тусад нь Хавсралт 2-т харуулав.

Холбогдох чадварын баганын дундаж оноо, 57.1 харьцуулах түвшнээс дээгүүр ангилалд үнэлэгдэж байна. Уг баганын таван индикатор тухайд өрхийн МХТ-ийг ашиглах боломж хамгийн бага оноотой буюу 35.2, энэ нь харьцуулах түвшнээс доогуур ангилалд орж байгаа бол телефон хэрэглэгчийн тоо, интернэт хэрэглэгчийн тоо, хүртээмжтэй интернэтийн индекс, засгийн газрын онлайн үйлчилгээ гэсэн бусад 4 индикатор тус тус харьцуулах түвшнээс дээгүүр ангилалд үнэлэгдэж байна. Энэ баганын хамгийн өндөр оноотой хоёр индикатор болох хүртээмжтэй интернэтийн индекс, засгийн газрын онлайн үйлчилгээ ОУХТ-ийн Жижиг, дунд үйлдвэрийн өрсөлдөх чадварын хэтийн төлөв тайлан 2021-д харгалзан 49.1, 35.1 гэсэн оноотой байжээ. Эндээс эдгээр индикатор харгалзан 19.8, 27.5 хувиар (пунктээр) тус тус өссөнийг нэлээд сайн үзүүлэлт гэж хэлж болно. Энэ баганын онооны үнэлгээний хувьд хүчтэй түвшинд ангилагдах индикатор байхгүй байгаа учраас цаашид жигд сайжруулах шаардлагатай, гэхдээ өрхийн МХТ-ийг ашиглах боломж индикатор доогуур түвшинд үнэлэгдэж байгаа тул цаашид нэлээд хүчин чармайлт гаргах хэрэгтэй байна.

Өөрчлөгдөх чадварын баганын дундаж оноо, 77.4 индикаторын хүчтэй түвшинд үнэлэгдэж байна. Тус баганыг бүрдүүлэх дөрвөн индикаторын хувьд суралцсан жил, барааны тэмдэгтийн бүртгэл индикаторын хүчтэй түвшинд үнэлэгдэж байгаа бол хүүгийн түвшний зөрүү, патентын өргөдлийн тоо харьцуулах түвшний дээгүүр ангилалд үнэлэгджээ. Санхүүгийн зах зээлийн зуучлалын үр ашгийг хэмжих хүүгийн түвшний зөрүү зээл ба хадгаламжийн хүүгийн ялгавраар тодорхойлогдоно. Уг зөрүү бага байх тусам хэлцлийн зардал бага байна, цаашилбал, хөрөнгө оруулалтын сангийн зардал бага байна гэсэн үг. Манай улсын энэ зөрүү Ковид-19 цар тахлаас өмнө буюу 2016-2020 оны хооронд дунджаар 6.3 байсан бол 2021 онд 9.4 болж, огцом өссөн нь хүүгийн түвшний зөрүү харьцангуй бага үнэлэгдэхэд нөлөөлсөн байна. Суралцсан жилийн хувьд бага ангийн боловсролоос дээд боловсрол хүртэл суралцсан жилээр хэмжигдэнэ. Манай улсын иргэдийн суралцсан жил индикаторын хүчтэй түвшинд үнэлэгдэж байгаа нь сайшаалтай боловч уг үзүүлэлт иргэдийн эзэмшсэн боловсролын чанарын талаар ямар нэгэн мэдээлэл өгөхгүй. Үүнээс гадна тус индикаторын хүчний түвшний үнэлгээг Нэгдсэн үндэстний байгууллагаас жил бүр гаргадаг Хүний хөгжлийн тайлан-гийн хүний хөгжлийн индексийн нэг бүрэлдэхүүн индекс болох боловсролын индексийн утга батлан харуулна.

6. ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН БАГАНЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ШИНЖИЛГЭЭ

Энэ хэсэгт өрсөлдөх чадварын багана бүрийн хувьд эдийн засгийн түвшний бүрэлдэхүүнийг (компанийн чадавх, бизнесийн экосистем, макро орчин) харьцуулж, тэдгээрийн уялдаа холбоог илрүүлэхийг зорино. Ингэснээр компанийн чадавх, бизнесийн экосистем, макро орчны үзүүлэлтүүдийн аль нь ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг/холбогдох чадварыг/өөрчлөгдөх чадварыг дэмжиж, аль нь хязгаарлаж байгааг тодорхойлох боломж бүрдэнэ.

6.1. ӨРСӨЛДӨХ ЧАДВАР

ЖДБ-ийн өрсөлдөх чадвар дундаж түвшинд үнэлэгдсэн ба сайжруулах шаардлагатай байна. ЖДБ-ийн өрсөлдөх чадварын гурван баганын хоёр нь болох компанийн чадавх, бизнесийн экосистемийн дундаж оноо харьцуулах түвшнээс дээгүүр хэдий ч хүчтэй түвшнээс нэлээд доогуур, гурав дахь багана болох макро орчны үнэлгээ харьцуулах түвшнээс доогуур үнэлэгдлээ. Тодруулбал, ЖДБ-ийн өрсөлдөх чадварын дундаж оноо компанийн түвшинд 52.4, бизнесийн экосистемийн хувьд 56.6, макро орчны баганын хувьд 39.2 оноогоор үнэлэгдсэн байна. (Хүснэгт 5) Компанийн түвшинд ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг бууруулж буй хүчин зүйл нь үйл ажиллагааны үр ашиг, зардлын үр ашиг, чанарын удирдлага байна. Бизнесийн экосистемийн хувьд өрсөлдөх чадварыг бууруулж буй гол хүчин зүйлс нь зам тээвэр, дэд бүтцийн хөгжил, эрчим хүчний найдвартай байдал, дотоодын болон олон улсын чанарын гэрчилгээжүүлэлтийн талаар мэдээлэл авах боломжийн оноонууд бага гарсан явдал юм. ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг бууруулж буй макро орчны хүчин зүйлс нь логистик гүйцэтгэлийн индекс, ISO 9001 чанарын гэрчилгээ болон ISO 14001 хүрээлэн буй орчны гэрчилгээ, онцгой тарифын үнэлэгдсэн утгууд харьцуулах түвшнээс доогуур үнэлэгдсэн явдал юм. (Хүснэгт 30)

Хүснэгт 30. Өрсөлдөх чадварын багана: Компани, бизнесийн экосистем, макро орчны уялдаа

Компанийн чадавх	Оноо	Бизнесийн экосистем	Оноо	Макро орчин	Оноо	
Үйлдвэрлэлийн үр ашиг	Үйл ажиллагааны үр ашиг	45.8	Эрчим хүчний найдвартай байдал	53.5	Үйлчилж буй тариф	58.6
	Зардлын үр ашиг	48.7	Зам тээвэр, дэд бүтцийн хөгжил	47.4	Техникийн зохицуулалтын тоо	-
	Цаг хугацааны үр ашиг	74.7	Хөдөлмөрийн зах зээлийн хөгжил	55.7	Онцгой тариф	42.6
Төрийн байгууллагын үйл ажиллагаа			57.8	Засаглалын индекс	46.6	
Албан хэлцлийн хэрэгжилт	61.7					

Нөөцийн менежмент	Орлого, зарлагын бүртгэл	76.6	Дотоодын тээврийн найдвартай байдал	68.7	Логистик гүйцэтгэлийн индекс	25.0
	Банканд данс эзэмших байдал	49.7	Гаалийн бүрдүүлэлтийн үр ашиг	68.7		
	Мөнгөн хөрөнгийн удирдлага	69.6				
Чанарын удирдлага	Чанарын хяналт, стандарт	27.5	Дотоодын тохирлын гэрчилгээний талаар мэдээлэл авах боломж	50.1	ISO 9001 чанарын гэрчилгээ	33.2
			Олон улсын гэрчилгээжүүлэлтийн талаар мэдээлэл авах боломж	41.7	ISO 14001 хүрээлэн буй орчны гэрчилгээ	29.4

Харьцуулах түвшин: 44.2

Сул түвшин: ≤26.5 оноо

Хүчтэй түвшин:
≥70.7 оноо

Бичил бизнесүүдийн өрсөлдөх чадвар хамгийн сул ба бизнесийн хэмжээ томорч, жижиг, дунд хэмжээтэй болохын хэрээр өрсөлдөх чадварын оноо ахиж байна.

Компанийн түвшинд өрсөлдөх чадварын үнэлэгдсэн утгыг бичил, жижиг, дунд хэмжээний ААН-ээр задлан харвал, бичил ААН-ийн хувьд хамгийн бага буюу 49.4, жижиг хэмжээний ААН-үүдийн хувьд 55.2, дунд хэмжээний ААН-үүдийн хувьд 58.4 оноогоор үнэлэгджээ. (Хүснэгт 5) Төрөөс хэрэгжүүлж буй татвар, тарифын бодлого, техникийн зохицуулалтуудыг ААН-үүдийн өрсөлдөх чадварын ялгаатай байдалд тулгуурлаж, бичил бизнесүүдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бизнесийн таатай орчныг бүрдүүлэх хэрэгтэй байна.

ЖДБ-үүд үйл ажиллагааны үр ашиг, зардлын үр ашгаа нэмэгдүүлж, бүтээгдэхүүний чанарын удирдлагын тогтолцоог өргөн хүрээнд нэвтрүүлж чадвал өрсөлдөх чадвар нь нэмэгдэх боломжтой байна. Үүний тулд ЖДБ-үүд

хөдөлмөрийн бүтээмжийг өсгөх шинэ технологи, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, үйлдвэрлэлийг бүрэн хүчин чадлаар нь ашиглах, компанийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх менежмент, зохион байгуулалт хийх, хөдөлмөрийн бүтээмжид тулгуурласан цалин, хөлсний системийг нэвтрүүлж, бараа, материалыг бөөний, хямд үнээр авах гэрээ, хэлцэл байгуулж, зах зээлд оролцогч талуудтай хамтран ажиллах замаар зардлын үр ашгийг бууруулах арга хэмжээ авч, хэрэгжүүлбэл өрсөлдөх чадвар нэмэгдэх магадлалтай байна. Түүнчлэн, ЖДБ-ийг дэмжих, бодлогын зохицуулалт хийж, хэрэгжүүлдэг төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагууд компанийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх бизнесийн экосистем, макро орчныг бүрдүүлэхэд анхаарах шаардлагатай байна. Тодруулбал, үр чадвартай ажиллах хүч бүхий хөдөлмөрийн зах зээлийг хөгжүүлэх, эрчим хүч, зам тээвэр, дэд бүтцийг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, дотоодын болон олон улсын бүтээгдэхүүний чанарын хяналтын тогтолцоо, гэрчилгээжүүлэлтийг хэрхэн авах, хэрэгжүүлэх талаар ЖДБ-үүдэд зориулсан мэдээ, мэдээллийг цацах, энэ талын сургалт, үйлчилгээ зохион байгуулах хэрэгтэй.

ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг дэмжих бизнесийн экосистемийн бүх индикатор харьцуулах түвшнээс дээгүүр үнэлэгдсэн боловч нэг нь ч хүчтэй түвшинд хүрээгүй.

Тиймээс ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг дэмжих экосистемийг бүхэлд нь сайжруулах, хөгжүүлэхийн төлөө төр, төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагууд анхаарч ажиллах шаардлагатай байна. Ялангуяа, Монголын худалдаа аж үйлдвэрийн танхим зэрэг бизнесүүдийн нэгдэл, холбоодын зүгээс бизнесийн экосистемийн оноог хамгийн ихээр доош татаж буй бүтээгдэхүүний олон улсын гэрчилгээжүүлэлтийн талаар мэдээ, мэдээлэл цацаж, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, хяналт, баталгаажуулалт, гэрчилгээжүүлэлт авахад ЖДБ-үүдийг дэмжих, хамтран ажиллах шаардлагатай байна. Мөн үйлдвэрлэлийн үр ашигт байдалд сөргөөр нөлөөлж буй экосистемийн бүрдэл болох зам тээвэр, дэд бүтцийн хөгжлийг хурдасгах, эрчим хүчний хүрэлцээ, найдвартай байдлыг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн хөгжүүлэхэд төрөөс анхаарах шаардлагатайгаас гадна ЖДБ рүү чиглэсэн төрийн байгууллагын үйл ажиллагааг илүү хялбар, хурдан, шуурхай, төвөг, чирэгдэлгүй болгоход анхаарах хэрэгтэй.

Өрсөлдөх чадварын макро орчны баганын хувьд логистик гүйцэтгэлийн индекс хамгийн муу үнэлгээг авсан байгаа нь дээр өгүүлсэн ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг зам тээвэр, дэд бүтцийн хөгжил хамгийн их хойш чангааж байгааг дахин баталж байна. Тиймээс МУ зам тээвэр, дэд бүтцийн хөгжилд онцгойлон анхаарч, даруй сайжруулах шаардлагатай байгааг дахин тэмдэглэе.

Макро орчны баганын индикаторууд дотор ISO 9001 чанарын гэрчилгээ, ISO 14001 хүрээлэн буй орчны гэрчилгээ гэсэн индикаторууд харьцуулах түвшнээс доогуур үнэлэгдсэн байгаа нь ЖДБ-үүд бүтээгдэхүүний чанарыг хянах, баталгаажуулах, гэрчилгээжүүлэх мисо болон макро орчин бүрдээгүй байгааг дахин нотолж байна. Иймд бүтээгдэхүүний чанар, стандартыг тогтоодог, мөрдүүлдэг, хянаж, гэрчилгээжүүлдэг байгууллагууд үйл ажиллагаагаа өргөжүүлж, сайжруулах шаардлагатай байна.

Тариф нь ЖДБ-ийн үйл ажиллагааг зохицуулдаг бодлогын нэг арга хэрэгслээс гадна бизнесийн байгууллагын зардал, үнэ, бараа, материалын сонголтод нөлөөлдөг чухал хүчин зүйлсийн нэг билээ. Макро орчны баганын индикаторууд дотроос онцгой тарифын индикатор харьцуулах түвшнээс доогуур, үйлчилж буй тариф харьцуулах түвшнээс дээгүүр хэдий ч хүчтэй түвшинд хүрээгүй үнэлэгдсэн байна. Тарифын зохицуулалтаар зарим үйлдвэрлэл, үйл ажиллагааг дэмжиж, заримыг нь хориглож, хязгаарлаж болно. Тиймээс ЖДБ-ийн шинж, байдлыг харгалзан тарифын ялгаатай бодлого явуулах замаар ЖДБ-үүдийн өрсөлдөх чадварыг дэмжих, урамшуулах шаардлагатай байна.

Засаглалын индекс 46.6 оноогоор үнэлэгдсэн нь харьцуулах түвшнээс үл ялиг өндөр хэдий ч хүчтэй түвшнээс хол зөрүүтэй байгаа нь ЖДБ-ийн макро орчин дахь засаглалыг сайжруулах, институтүүдийн үйл ажиллагааг уялдуулах, ЖДБ-д таатай хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байгааг илтгэнэ.

6.2. ХОЛБОГДОХ ЧАДВАР

ЖДБ-ийн хувьд борлуулалт, маркетингийн сувгуудад анхаарал хандуулж байгаа боловч, мэдээллийн сувгууд, хэрэглэгчийн мэдээлэл бүрдүүлэлтэд төдийлөн анхаарал хандуулахгүй байна. Өөрөөр хэлбэл хэрэглэгчтэйгээ холбогдох боломж өндөр байгаа боловч ЖДБ-үүд эдгээр шийдэл, боломжийг ашиглах байдал хангалтгүй байна. Холбогдох чадварын эхний үзүүлэлтээр тухайн компани худалдан авагч, хэрэглэгч талтайгаа хэрхэн харилцаж байгааг тодорхойлохыг зорьсон. Тухайлбал компанийн орчны хувьд 3 индикатораар хэмжсэн ба, мэдээллийн сувгууд, хэрэглэгчийн мэдээлэл бүрдүүлэлт гэсэн үзүүлэлтүүд харьцуулах түвшнээс доогуур үнэлэгдэж байгаа бол, борлуулалт, маркетингийн сувгууд нь харьцуулах түвшнээс дээгүүр үнэлэгдэж байна. Өөрөөр хэлбэл ЖДБ-үүд борлуулалт, маркетингийн үйл ажиллагаандаа анхаарч байгаа боловч, хэрэглэгчдээ төдийлөн анхаарал хандуулах, мэдээлэл хүргэхгүй байгааг илтгэж байна. Харин бизнесийн экосистемийн хувьд 2 индикатораар үнэлсэн ба худалдан авагчдын сонголт хийх боловсрол харьцуулах түвшнээс доогуур үнэлэгдсэн бол, хэрэглэгчтэйгээ холбогдох байдал харьцуулах түвшнээс дээгүүр үнэлэгдсэн болно. Өөрөөр хэлбэл технологийн дэвшил болон иргэдийн ухаалаг утас интернэтийн хэрэглээтэй холбоотойгоор хэрэглэгчтэйгээ холбогдох байдал өндөр үнэлэгдэж байна. Макро орчны хувьд 3 индикатораар үнэлсэн ба өрхийн МХТ-ийг боломж харьцуулах түвшнээс доогуур, телефон хэрэглэгчийн тоо, интернэт хэрэглэгчийн тоо зэрэг үзүүлэлтүүд харьцуулах түвшнээс дээгүүр үнэлэгдсэн.

ЖДБ-ийн хувьд ханган нийлүүлэлтийн сүлжээний суурь бүрдэж эхэлж байгаа хэдий ч, цаашид ханган нийлүүлэгчдийн мэдээлэл солилцох байдал, хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай. Холбогдох чадварын дараагийн үзүүлэлтээр тухайн компанийн орчны хувьд ханган нийлүүлэлтийн сүлжээ, тухайн ханган нийлүүлэлтийн сүлжээг үнэлдэг тогтолцоо бий эсэхийг үнэлэхэд харьцуулах түвшнээс дээгүүр бол, бизнесийн экосистемийн орчны хувьд ханган нийлүүлэгчдийн мэдээлэл солилцох байдал, ханган нийлүүлэгчдийн хамтын ажиллагааг хэмжсэн ба харьцуулах түвшнээс доогуур байна. Иймд ЖДБ-үүдэд ханган нийлүүлэлтийн сүлжээ, тогтолцоог улам сайн бүрдүүлэх, цаашид ханган нийлүүлэгч талуудын мэдээлэл солилцоо, хамтын ажиллагааг сайжруулах хэрэгцээ байна. Харин макро орчны хувьд хүртээмжтэй интернэтийн индекс хүчтэй түвшинтэй ойролцоо буюу 68.9% бөгөөд харьцуулах түвшнээс дээгүүр байна.

ЖДБ-ийн хувьд гишүүнчлэл бүхий салбарын холбоод, бусад худалдаа, хамтын ажиллагаа бүхий байгууллагуудын үйл ажиллагаа хангалтгүй, хамтын ажиллагаа дутмаг хэмээн үнэлж байна. Холбогдох чадварын сүүлчийн үзүүлэлтээр тухайн компани салбарын холбоод, бусад худалдаа, хамтын ажиллагаа бүхий байгууллагуудтай хамтын ажиллагааг бий болгоход ямар нэгэн хүчин чармайлт гаргадаг эсэхийг авч үзсэн ба компанийн түвшинд байгууллагуудын гишүүнчлэл, гишүүнчлэл бүхий байгууллагын үйл ажиллагаанаас хүртэх өгөөжийн үнэлгээ,

бизнесийн эко системийн хувьд салбарын холбоод, ХАҮТ, бусад худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих байгууллагуудын хамтын ажиллагааны орчин, харин макро орчны хувьд засгийн газрын онлайн үйлчилгээ хэр түвшинд байна вэ гэдэг асуудлыг авч үзлээ. Компанийн орчны хувьд институтүүдтэй холбогдох чадварын индикатор харьцуулах түвшнээс сул үнэлэгдсэн. Үүнээс үзвэл, ЖДБ-үүд гишүүнчлэл авч, хамтын ажиллагаа өргөжүүлэх сонирхол, хүчин чармайлт гаргаж байгаа ч гол үр дүн болох гишүүнчлэлийн үйл ажиллагаанаас бизнесийн хүртэх өгөөж, боломжууд харьцангуй бага байна. Иймд ЖДБ-үүд гишүүнчлэлтэй байгаа хэдий ч гишүүнчлэлээс хүртэх өгөөж, үр дүн нь тодорхойгүй, эсвэл гишүүнчлэлийн үйл ажиллагаандаа төдийлөн идэвхтэй оролцож манлайлал үзүүлэхгүй байна.

Үүнийг бизнесийн орчны зүгээс авч үзэхэд гишүүнчлэл олгож байгаа байгууллагуудын дотоод засаглал төлөвшөөгүй, үйл ажиллагаа нь бизнес эрхлэгчдийн хэрэгцээнд нийцсэн биш, оролцоог хангах байдал дутмаг зэрэг нь харьцуулах түвшнээс үл ялиг дээгүүр үнэлэгдэхэд нөлөөлж байна. Өөрөөр хэлбэл, энэ нь салбарын болон гишүүнчлэл олгож буй эдгээр байгууллагуудын хамтын ажиллагаа дутмаг байгааг илтгэж байна. Марко орчны хувьд засгийн газрын онлайн үйлчилгээний индикатор харьцуулах түвшнээс дээгүүр үнэлэгджээ. Үүнд сүүлийн жилүүдэд МУ-ын Засгийн газраас бизнес эрхлэгч нарт чиглэсэн болон бусад төрлийн үйлчилгээг онлайн хэлбэрт шилжүүлж байгаа нь нөлөөлсөн байж болно. Иймд гишүүнчлэл бүхий байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх, үйл ажиллагааг нь бизнес эрхлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх, бэхжүүлэх шаардлага байна.

Хүснэгт 31. Холбогдох чадварын багана: Компани, бизнесийн экосистем, макро орчны үялдаа

	Компанийн чадавх	Түвшин	Бизнесийн экосистем	Түвшин	Макро орчин	Түвшин
Хэрэглэгч	Мэдээллийн сувгууд	25.6	Худалдан авагчдын сонголт хийх боловсрол	20.3	Өрхийн МХТ-ийг ашиглах боломж	35.2
	Хэрэглэгчийн мэдээлэл бүрдүүлэлт	21.9	Хэрэглэгчтэйгээ холбогдох боломж	61.6	Телефон хэрэглэгчийн тоо	58.6
	Борлуулалт, маркетингийн сувгууд	54.1			Интернэт хэрэглэгчийн тоо	60
Нийлүүлэгч	Ханган нийлүүлэгчийн харилцаа	68	Ханган нийлүүлэгчид мэдээллээ солилцох байдал	38.2	Хүртээмжтэй интернэтийн индекс	68.9
	Ханган нийлүүлэгчийн гүйцэтгэлийн үнэлгээ	49.6	Ханган нийлүүлэгчдийн хамтын ажиллагаа	38.4		
			Ханган нийлүүлэгчийн үнэлгээний тогтолцоо	43.9		

Институт	Гишүүнчлэл	25.0	Салбарын байгууллагуудын хамтын ажиллагааны орчин	47.5	Засгийн газрын онлайн үйлчилгээ	62.6
	Гишүүнчлэлийн үнэлгээ	47.2				
	Харьцуулах түвшин: 44.2		Сул түвшин: ≤26.5 оноо		Хүчтэй түвшин: ≥70.7 оноо	

Тэмдэглэгээ: *-Харьцуулах түвшнээс

6.3. ӨӨРЧЛӨГДӨХ ЧАДВАР

ЖДБ-ийн санхүүжилтэд хүрэх боломжид ахиц гарчээ. Өөрчлөгдөх чадварын эхний үзүүлэлтээр тухайн компани санхүүгийн асуудлаа шийдэх чадвартай юу, бизнесийн орчинд нь санхүүжилтийн хүртээмж хэр байна вэ, тухайн улсад зээлийн хүүгийн түвшин хэр хэмжээнд байна вэ гэдгийг авч үзлээ. Санхүүжилтэд хүрэх боломж ба орчны хязгаарлагдмал байдал нь ЖДБ-ийн хөгжлийг сааруулдаг асуудлын нэг байсаар ирсэн бөгөөд энэ чиглэлээр ч сүүлийн жилүүдэд тодорхой ажлууд хийгдэж байна. Тухайлбал, ЖДҮ-ийг дэмжих үндэсний хөтөлбөр, Зээлийн батлан даалтын сан, ЖДҮ-ийг хөгжүүлэх сан, бусад төсөл хөтөлбөрүүдийг дурдаж болно. Тэгвэл энэ судалгаагаар олонх ЖДБ эрсдэл багатай эх үүсвэрээс санхүүгийн хэрэгцээгээ хангах чадвар нэмэгдсэн, бизнесийн орчинд санхүүгийн хүртээмж сайжирсан, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийн асуудал бизнес эрхлэхэд саад болох явдал багассан гэсэн үр дүнд хүрлээ. Түүнчлэн хүүгийн зөрүү буурч санхүүгийн зах зээлийн зуучлалын үр ашиг нэмэгдсэн байна (Хүснэгт 29). Энэхүү үр дүнд хүрсний гол шалтгаанууд нь дээрх төсөл, хөтөлбөрүүд үр дүнгээ өгөхөөс гадна бизнес эрхлэгчдийн зээлжих чадвар сайжирсан (барьцаа хөрөнгөтэй болсон, зээлийн түүхтэй болсон г.м.), банк, санхүүгийн байгууллагын зээлийн шаардлага зөөлөрсөн, хямд эх үүсвэр татан төвлөрүүлж байгаатай холбоотой хэмээн үзэж болох юм.

ЖДБ-ийн хувьд үр чадвартай хүний нөөцийн суурь бүрдсэн ч цаашид хүрэлцээг сайжруулах шаардлагатай. Өөрчлөгдөх чадварын дараагийн үзүүлэлтээр тухайн компанид үр чадвартай ажиллах хүч, чадварлаг менежер байгаа эсэх, тухайн салбар үр чадвартай, мэргэшсэн хүний нөөцөөр хангагдсан эсэх, тухайн улсад үр чадвартай мэргэжилтэн хэр хугацаанд суралцаж байна вэ гэдгийг тодорхойллоо. Үүнийг хэмжсэн индикаторууд компани ба бизнесийн экосистемийн түвшинд харьцуулах түвшнээс дээгүүр үнэлэгдсэн ч хүчтэй түвшний босго онооноос 10-17 оноогоор доогуур байна (Хүснэгт 32). Иймд ЖДБ-үүдэд үр чадвартай хүний нөөцийн суурь бүрдсэн ч цаашид үр чадвартай мэргэшсэн хүний нөөцийн хүрэлцээг тасралтгүй нэмэгдүүлэх шаардлага компани ба салбарын хувьд аль алинд нь байна. Харин МУ-ын тухайд үр чадвартай мэргэжилтний суралцсан дундаж жил хангалттай түвшинд байна.

ЖДБ-ийн хувьд үр чадвартай хүний нөөцийг бэхжүүлэх, тасралтгүй сургахад хүчин чармайлт гаргах шаардлагатай. Үр чадвартай хүний нөөцийг бүрдүүлэхээс гадна тэднийг цаашид хэрхэн хөгжүүлэх үү, хөгжүүлэх боломж ба орчин бүрдсэн үү гэдэг асуудал чухал юм. Энэ хүрээнд тухайн компани ажилчдаа чадавхжуулах

сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг эсэх, салбарын гол үр чадвар олгодог сургалтын байгууллагуудын хүрэлцээ, чанар ямар түвшинд байдгийг авч үзсэн. Ажилчдын сургалтын хөтөлбөр дэд индикатор харьцуулах түвшнээс дээгүүр, салбарын сургалтын байгууллагуудын хүртээмж, чанар харьцуулах түвшнээс үл ялиг дээгүүр үнэлэгдсэн байна (Хүснэгт 32). Хэдийгээр компанийн сургалтын хөтөлбөр харьцуулах түвшнээс дээгүүр үнэлэгдсэн ч судалгаанд хамрагдсан ЖДБ-ийн тавны нэг нь л бүх ажилчдаа хамруулсан сургалтын хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлдэг байна. Иймд ЖДБ-үүд ажилчдаа чадавхжуулахдаа “тогтмол бус”, “төлбөргүй”, “шаардлагатай ажилчнаа л сургадаг” загвараас тогтмол, бүх ажилчдаа сургадаг загвар руу шилжихэд анхаарах, харин салбарын сургалтын байгууллагууд хүрэлцээ, чанараа сайжруулах шаардлага байна.

ЖДБ-ийн хувьд инновац хөгжүүлэлтэд тодорхой хүчин чармайлт гаргаж байгаа ч бодит үр дүнд хүрэх шаардлага байна. Өөрчлөгдөх чадварын сүүлчийн үзүүлэлтээр тухайн компани шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхэд ямар нэгэн хүчин чармайлт гаргадаг эсэх, салбарын хувьд патент, лиценз, зөвшөөрөл авахад зардал, чирэгдэл хэр байдаг вэ, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжүүлэхэд их дээд сургууль, судалгаа шинжилгээний байгууллагууд, мэргэжлийн холбоотой хамтран ажилладаг эсэх, макро орчны хувьд тухайн улсад патент, барааны тэмдэгтийн бүртгэл хэр түвшинд байна вэ гэдэг асуудлыг авч үзлээ. Компанийн хувьд инновац хөгжүүлэлтийн индикатор харьцуулах түвшнээс доогуур үнэлэгджээ (Хүснэгт 32). Энэ нь ЖДБ-үүд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхэд тодорхой хүчин чармайлт гаргаж байгаа ч гол үр дүнд болох шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний патент, лицензийг эзэмших явдал харьцангуй бага байгаатай холбоотой юм. Иймд ЖДБ-үүд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжүүлэлтийн хувьд хүрсэн үр дүнд нь тодорхойгүй, эсвэл түүнийгээ албажуулах явдал нь хангалтгүй байна.

Үүнийг бизнесийн орчны зүгээс авч үзэхэд патент, лиценз, зөвшөөрөл авахад учирдаг зардал, чирэгдэл харьцуулах түвшнээс үл ялиг дээгүүр үнэлэгдсэн байна (Хүснэгт 32). Энэ нь шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг албажуулахад хүндрэлтэй байдаг гэсэн хандлага бизнес эрхлэгчдийн дунд нэлээдгүй байдгийг харуулж байна. Түүнчлэн инновац хөгжүүлэхэд мэргэжлийн байгууллагатай хамтран ажилладаг байдал харьцуулах түвшнээс доогуур үнэлэгджээ. Иймд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжүүлэхэд мэргэжлийн болон бизнесийн байгууллагуудын хоорондын шинжлэх ухаанч хамтын ажиллагааны суурийг тавих, үйл ажиллагааг бэхжүүлэх шаардлага байна.

Хүснэгт 32. Өөрчлөгдөх чадварын багана: Компани, бизнесийн экосистем, макро орчны уялдаа

	Компанийн чадавх	Оноо	Бизнесийн экосистем	Оноо	Макро орчин	Оноо
Санхүү	Санхүүгийн эх үүсвэр	80.0	Санхүүгийн хүртээмж	83.6	Хүүгийн түвшний зөрүү	76.8
			Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийн нөлөө	53.0		
Ур чадвар	Ур чадвартай хүний нөөц	61.1	Салбарын ур чадвартай ажиллах хүчний хүрэлцээ	54.2	Суралцсан жил	85.6
			Салбарын ур чадвартай ажиллах хүчний хүртээмжийн нөлөө	58.5		
	Ажилчдын сургалтын хөтөлбөр*	58.2	Салбарын сургалтын байгууллагын хүртээмж, чанар	46.9		
Инновац	Инновац хөгжүүлэлт	32.0	Патент, лиценз, зөвшөөрлийн зардал	48.8	Патентын өргөдлийн тоо	60.9
			Инновацын төлөөх мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагаа	43.5	Барааны тэмдэгтийн бүртгэл	86.4
Харьцуулах түвшин: 44.2			Сүл түвшин: ≤26.5 оноо		Хүчтэй түвшин: ≥70.7 оноо	

Тэмдэглэгээ: *-дэд индикаторыг авч үзэв.

7. БОДЛОГЫН ОНОВЧЛОЛЫН ШИНЖИЛГЭЭ

Энэ бүлэгт өмнөх бүлгүүдийн үр дүнг ашиглан бодлогын оновчлолын шинжилгээг хийнэ. Энэ хүрээнд ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг сайжруулах бодлого хэрэгжүүлбэл аль баганын, ямар үзүүлэлтүүдийг, хэдий хэмжээгээр өөрчлөх шаардлагатай талаар авч үзнэ. Энэхүү шинжилгээг хийхдээ пеналти ботэлник (penalty for bottleneck) аргыг ашигласан бөгөөд энэ нь хамгийн сул үзүүлэлтүүдийг сайжруулах замаар нийт үзүүлэлтүүдийг өсгөдөг. Түүнчлэн бүх тохируулсан үзүүлэлтүүдийн онооны дундаж тэнцүү байвал системийг оновчтой, харин зөрүү үүсвэл нөөц үр ашиггүй зарцуулагдсаныг илэрхийлнэ. Мөн ЖДБ-ийн өрсөлдөх чадварын үнэлгээнд авч үзсэн бүх үзүүлэлт нийт үнэлгээнд ижил хувь нэмэр үзүүлнэ гэж таамаглана. Энэхүү шинжилгээг компанийн чадавх, бизнесийн экосистемийн хувьд үндсэн үзүүлэлтийн түвшинд хийнэ.

Компанийн чадавх. Өмнөх үр дүнгээс үзэхэд холбогдох чадварын баганын хэрэглэгч, институт, өрсөлдөх чадварын баганын чанарын удирдлага гэсэн үндсэн үзүүлэлтүүдийг нэн тэргүүнд, өөрчлөгдөх чадвар баганын инновац гэсэн үзүүлэлтийг тодорхой хэмжээнд сайжруулах шаардлагатай байсан. Дараах хүснэгтэд компанийн чадавхын индексийг 10%, 15%, 20%-иар өсгөхөд хамгийн сул үндсэн үзүүлэлтүүдэд шаардагдах өөрчлөлтийг харууллаа. Компанийн чадавхын 10%-ийн өсөлт нь хамгийн их сайжруулах шаардлагатай 3 үзүүлэлтэд нөлөөлж, эдгээр үзүүлэлтийг 28 оноогоор нэмэгдүүлнэ. Энэхүү нэмэлт нөөцийн 50%-ийг чанарын удирдлага, 28.6%-ийг хэрэглэгч, 21.4%-ийг институтэд хуваарилах шаардлагатай. Үүний үр дүнд өрсөлдөх ба холбогдох чадварын багана мэдэгдэхүйцээр өснө.

Хүснэгт 33. Компанийн чадавхыг 10%, 15%, 20%-иар өсгөхөд шаардагдах нэмэлт нөөцийн хуваарилалт

Багана/Үндсэн үзүүлэлт	Анхны оноо	10%-ийн өсөлт			15%-ийн өсөлт			20%-ийн өсөлт		
		Шаардагдах оноо	Нийт хүчин чармайлтад эзлэх хувь	Өссөн оноо	Шаардагдах оноо	Нийт хүчин чармайлтад эзлэх хувь	Өссөн оноо	Шаардагдах оноо	Нийт хүчин чармайлтад эзлэх хувь	Өссөн оноо
Өрсөлдөх чадвар	49.7	6.8	50.0	56.5	9.0	42.2	58.7	11.02	36.9	60.8
Үйлдвэрлэлийн үр ашиг	56.4	0.0	0.0	56.4	0.0	0.0	56.4	0	0.0	56.4
Нөөцийн менежмент	65.3	0.0	0.0	65.3	0.0	0.0	65.3	0	0.0	65.3
Чанарын удирдлага	27.5	14.0	50.0	41.5	19.0	42.2	46.5	24	36.9	51.5


Холбогдох чадвар	42.9	5.5	50.0	48.4	9.4	53.3	52.3	12.90	52.3	55.8
Хэрэглэгч	33.9	8.0	28.6	41.9	13.0	28.9	46.9	18	27.7	51.9
Нийлүүлэгч	58.8	0.0	0.0	58.8	0.0	0.0	58.8	0	0.0	58.8
Институт	36.1	6.0	21.4	42.1	11.0	24.4	47.1	16	24.6	52.1
Өөрчлөгдөх чадвар	53.3	2.3	0.0	55.6	3.1	4.4	56.4	5.05	10.8	58.4
Бизнес төлөвлөлт ба санхүү	54.9	0.0	0.0	54.9	0.0	0.0	54.9	0	0.0	54.9
Ур чадвар	59.6	0.0	0.0	59.6	0.0	0.0	59.6	0	0.0	59.6
Инновац	45.3	0.0	0.0	45.3	2.0	4.4	47.3	7	10.8	52.3
Шаардагдах нэмэлт нөөц	-	28	100	-	45	100	-	65	100	-
Компанийн чадавхын индекс	48.7	4.9	-	53.5	7.2	-	55.8	9.7	-	58.3

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Тэмдэглэгээ: Өөрчлөгдсөн үзүүлэлтүүдийг өнгөөр тэмдэглэв. Бараан өнгөөр хүчтэй өөрчлөлтийг, цайвар өнгөөр сул өөрчлөлтийг үзүүлэв.

Түүнчлэн компанийн чадавхын 15% ба 20%-ийн өсөлт дээрх 3 үзүүлэлтээс гадна *инновацад* нөлөөлнө. 20%-ийн өсөлтийг хийхийн тулд 65 онооны нэмэлт нөөц шаардлагатай бөгөөд үүний 36.9%-ийг *чанарын удирдлага*, 27.7%-ийг *хэрэглэгч*, 24.6%-ийг *институт*, 10.8%-ийг *инновацад* хуваарилах шаардлагатай. Үүний үр дүнд холбогдох ба өөрчлөгдөх чадварын багана мэдэгдэхүйцээр өснө. Зураг 25-д хамгийн өндөр үнэлгээтэй үзүүлэлтээс (нөөцийн менежмент) үзүүлэлтүүдийн анхны оноо, 10%, 15%, 20%-ийн өсөлтийн дараах үзүүлэлтүүдийн оноог хассан зөрүүг үзүүлэв. Анхны онооны хувьд үзүүлэлтүүдийн хоорондох хэлбэлзэл өндөр байна. Хамгийн сул дөрвөн үзүүлэлт (чанарын удирдлага, хэрэглэгч, институт, инновац) хамгийн өндөр үзүүлэлтээс 20-38 оноогоор доогуур байгаа нь ЖДБ-ийн өрсөлдөх чадвар компанийн түвшинд үр ашиггүй байгааг харуулж байна. Нэг улс доторх аж ахуй эрхлэх онцлог шинж чанаруудын ялгаа их байх тусам бизнес эрхлэлтээс хүртэх ашиг тусыг ашиглахад хүндрэлтэй байдаг. 10%-ийн өсөлтийн дараа хамгийн их үзүүлэлт ба онооны зөрүү багассан ч үзүүлэлтүүдийн хооронд мэдэгдэхүйц хэлбэлзэл байсаар байгаа нь систем оновчтой бус хэвээр байгааг илтгэж байна. Харин 15% (эсвэл 20%) нэмэгдсэний дараа 4 (эсвэл 6) үзүүлэлт ойролцоо түвшинд хүрсэн тул систем харьцангуй оновчтой болсон байна. **Иймд ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг компанийн түвшинд нэмэгдүүлэхийн тулд хамгийн багадаа 15%-ийн өсөлт хийхийг зөвлөж байна.**

Зураг 25. Хамгийн өндөр үнэлгээтэй үзүүлэлт ба анхны оноо, 10%, 15%, 20%-ийн өсөлтийн дараах онооны зөрүү



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Өмнөх бүлгүүдэд бичил, жижиг бизнесүүдийн өрсөлдөх чадварыг сайжруулах шаардлагатай гэсэн үр дүн гарсан учраас бичил бизнесийн өрсөлдөх чадварыг 20%-иар, жижиг бизнесийг 15%-иар өсгөсөн үр дүнг доорх хүснэгтэд үзүүлэв. Бичил бизнесийн өрсөлдөх чадавхын 20%-ийн өсөлт нь 4 үзүүлэлтэд нөлөөлж, эдгээр үзүүлэлтийг 56 оноогоор нэмэгдүүлнэ. Энэхүү нэмэлт нөөцийн 41.1% нь чанарын удирдлага, 28.6% нь хэрэглэгч, 21.4% нь институт, 8.9% нь инновацад хуваарилагдана. Үүний үр дүнд өрсөлдөх чадвар 11 оноогоор, холбогдох чадварын багана 10.7 оноогоор, өөрчлөгдөх чадвар 4.7 оноогоор өснө. 20%-ийн өсөлтийн дараах бичил бизнесийн өрсөлдөх чадавхын үзүүлэлтүүд жижиг бизнесийн анхны оноотой ойролцоо түвшинд хүрэхийн зэрэгцээ бүх үзүүлэлт харьцуулах түвшнээс дээгүүр, хоорондоо ойролцоо түвшинд байгаа нь систем тогтворжсоныг харуулж байна (Зураг 25).

Хүснэгт 34. Бичил ба жижиг бизнесийн өрсөлдөх чадавхыг харгалзан 20% ба 15%-иар өсгөхөд шаардагдах нэмэлт нөөцийн хуваарилалт


Багана/Үндсэн үзүүлэлт	Бичил				Жижиг			
	Анхны оноо	20%-ийн өсөлт			Анхны оноо	15%-ийн өсөлт		
		Шаардагдах оноо	Нийт хүчин чармайлтад эзлэх хувь	Өссөн оноо		Шаардагдах оноо	Нийт хүчин чармайлтад эзлэх хувь	Өссөн оноо
Өрсөлдөх чадвар	46.3	11.0	41.1	57.3	52.6	8.9	37.7	61.6
Үйлдвэрлэлийн үр ашиг	54.9	0	0.0	54.9	57.7	0	0.0	57.7
Нөөцийн менежмент	62.3	0	0.0	62.3	67.0	0	0.0	67.0
Чанарын удирдлага	21.7	23	41.1	44.7	33.2	20	37.7	53.2

Холбогдох чадвар	38.4	10.7	50.0	49.04	47.0	10.6	54.7	57.6
Хэрэглэгч	28.2	16	28.6	44.2	37.9	15	28.3	52.9
Нийлүүлэгч	54.0	0	0.0	54.0	63.6	0	0.0	63.6
Институт	32.9	12	21.4	44.9	39.6	14	26.4	53.6
Өөрчлөгдөх чадвар	47.5	4.7	8.9	52.2	56.8	3.8	7.5	60.6
Бизнес төлөвлөлт ба санхүү	48.6	0	0.0	48.6	60.1	0	0.0	60.1
Ур чадвар	54.6	0	0.0	54.6	61.4	0	0.0	61.4
Инновац	39.4	5	8.9	44.4	49.0	4	7.5	53.0
Шаардагдах нэмэлт нөөц	-	56	100	-		53	100	-
Компанийн чадавхын индекс	44.1	8.8	-	52.8	53.0	7.8	-	59.9


Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Тэмдэглэгээ: Өөрчлөгдсөн үзүүлэлтүүдийг өнгөөр тэмдэглэв. Бараан өнгөөр хүчтэй өөрчлөлтийг, цайвар өнгөөр сул өөрчлөлтийг үзүүлэв.

Зураг 26. Бичил бизнесийн 20%-ийн өсөлт ба жижиг бизнесийн анхны онооны харьцуулалт



Зураг 27. Жижиг бизнесийн 15%-ийн өсөлт ба дунд бизнесийн анхны онооны харьцуулалт



Жижиг бизнесийн өрсөлдөх чадавхын 15%-ийн өсөлт нь мөн л 4 үзүүлэлтэд нөлөөлж, эдгээр үзүүлэлтийг 53 оноогоор нэмэгдүүлнэ. Энэхүү нэмэлт нөөцийн 28.3% нь хэрэглэгчид, 37.7% нь чанарын удирдлага, 26.4% нь институт, 7.5% нь инновацад хуваарилагдана. Үүний үр дүнд холбогдох чадварын багана 10.6 оноогоор, өрсөлдөх чадвар 8.9 оноогоор, өөрчлөгдөх чадвар 3.8 оноогоор өснө. 15%-ийн өсөлтийн дараах жижиг бизнесийн өрсөлдөх чадавхын үзүүлэлтүүд дунд бизнесийн анхны оноотой ойролцоо түвшинд хүрэхийн зэрэгцээ бүх үзүүлэлт харьцуулах түвшнээс дээгүүр, хоорондоо ойролцоо түвшинд байгаа нь систем тогтворжсоныг харуулж байна (Зураг 26).

Бизнесийн экосистем. Хүснэгт 35-д бизнесийн экосистемийн индексийг 10%, 15%, 20%-иар өсгөхөд хамгийн сул үндсэн үзүүлэлтүүдэд шаардагдах өөрчлөлтийг харууллаа. Бизнесийн экосистемийн 10%-ийн өсөлт нь хамгийн их сайжруулах шаардлагатай 5 үзүүлэлтэд нөлөөлж, эдгээр үзүүлэлтийг 40 оноогоор нэмэгдүүлнэ. Энэхүү нэмэлт нөөцийн 32.5%-ийг нийлүүлэгч, 30%-ийг хэрэглэгч, 17.5%-ийг чанарын удирдлага, 12.5%-ийг институт, 7.5%-ийг инновацад хуваарилах шаардлагатай. Үүний үр дүнд холбогдох чадварын багана мэдэгдэхүйцээр өснө. Харин 15% ба 20%-ийн өсөлт нийт 7 үзүүлэлтэд нөлөөлөх бөгөөд энэ нь бизнесийн экосистемийн хувьд ЖДБ-ийн өрсөлдөх чадварын ихэнх үзүүлэлтийг сайжруулах шаардлагатайг харуулж байна. 15% ба 20%-ийн өсөлт нь өмнөх 5 үзүүлэлтээс гадна үйлдвэрлэлийн үр ашиг, үр чадвар гэсэн хоёр үзүүлэлтэд нөлөөлнө. Үүний үр дүнд холбогдох ба өөрчлөгдөх чадварын багана мэдэгдэхүйцээр, өөрчлөгдөх чадвар тодорхой хэмжээгээр өсөхөөр байна.

Хүснэгт 35. Бизнесийн экосистемийг 10%, 15%, 20%-иар өсгөхөд шаардагдах нэмэлт нөөцийн хуваарилалт

Багана/Үндсэн үзүүлэлт	Анхны оноо	10%-ийн өсөлт			15%-ийн өсөлт			20%-ийн өсөлт		
		Шаардагдах оноо	Нийт хүчин чармайлтад эзлэх хувь	Өссөн оноо	Шаардагдах оноо	Нийт хүчин чармайлтад эзлэх хувь	Өссөн оноо	Шаардагдах оноо	Нийт хүчин чармайлтад эзлэх хувь	Өссөн оноо
Өрсөлдөх чадвар	56.6	3.5	17.5	60.1	5.0	19.4	61.6	7.5	22.4	69.1
Үйлдвэрлэлийн үр ашиг	55.2	0	0.0	55.2	1.0	1.6	56.2	5	5.9	61.2
Нөөцийн менежмент	68.7	0	0.0	68.7	0.0	0.0	68.7	0	0.0	68.7
Чанарын удирдлага	45.9	7	17.5	52.9	11.0	17.7	56.9	14	16.5	70.9
Холбогдох чадвар	42.9	9.8	75.0	52.7	13.4	64.5	56.3	16.8	58.8	73.1
Хэрэглэгч	41.0	12	30.0	53.0	15.0	24.2	56.0	19	22.4	75.0
Нийлүүлэгч	40.2	13	32.5	53.2	16.0	25.8	56.2	19	22.4	75.2
Институт	47.5	5	12.5	52.5	9.0	14.5	56.5	12	14.1	68.5


Өөрчлөгдөх чадвар	57.0	2.2	7.5	59.2	4.7	16.1	61.7	6.8	18.8	68.5
Бизнес төлөвлөлт ба санхүү	68.3	0	0.0	68.3	0.0	0.0	68.3	0	0.0	68.3
Ур чадвар	53.2	0	0.0	53.2	3.0	4.8	56.2	6	7.1	62.2
Инновац	49.5	3	7.5	52.5	7.0	11.3	56.5	10	11.8	66.5
Шаардагдах нэмэлт нөөц		40	100	-	62	100	-	85	100	-
Бизнесийн экосистемийн индекс	52.2	5.2	-	57.3	7.7	-	59.9	10.4	-	70.2

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Тэмдэглэгээ: Өөрчлөгдсөн үзүүлэлтүүдийг өнгөөр тэмдэглэв. Бараан өнгөөр хүчтэй өөрчлөлтийг, цайвар өнгөөр сул өөрчлөлтийг үзүүлэв.

Зураг 28-д хамгийн өндөр үнэлгээтэй үзүүлэлт ба анхны оноо, 10%, 15%, 20%-ийн өсөлтийн дараах үзүүлэлтүүдийн онооны зөрүүг үзүүлэв. Компанийн чадавхтай адил анхны онооны хувьд үзүүлэлтүүдийн хоорондох хэлбэлзэл өндөр байна. Хамгийн сул таван үзүүлэлт (нийлүүлэгч, хэрэглэгч, чанарын удирдлага, институт, инновац) хамгийн өндөр үзүүлэлтээс 19-28 оноогоор доогуур байгаа нь ЖДБ-ийн өрсөлдөх чадварын бизнесийн экосистем үр ашиггүй байгааг харуулж байна. 10%-ийн өсөлтийн дараа хамгийн их үзүүлэлт ба онооны зөрүү багасахын зэрэгцээ үзүүлэлтүүдийн хоорондын хэлбэлзэл бүүрч 9 үзүүлэлтээс 7 үзүүлэлт ойролцоо түвшинд хүрч, систем тогтворжиж байна. Энэ нь 15%-ийн өсөлтийн дараа ч өөрчлөлтгүй хэвээр байна. **Иймд ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг бизнесийн экосистемийн түвшинд нэмэгдүүлэхийн тулд багадаа 10%-ийн өсөлт хийхийг зөвлөж байна.**

Зураг 28. Хамгийн өндөр үнэлгээтэй үзүүлэлт ба анхны оноо, 10%, 15%, 20%-ийн өсөлтийн дараах онооны



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Зөвлөмж. Дараах хүснэгтэд компани болон бизнесийн экосистемийн хувьд сайжруулах шаардлагатай үндсэн үзүүлэлтүүд, мөн тэдгээрт харгалзах нэн тэргүүнд сайжруулах шаардлагатай индикаторуудыг нэгтгэн харууллаа. Иймд ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг сайжруулах бодлогын оновчлолыг хийхдээ дараах үндсэн

үзүүлэлтүүд, индикаторуудад нэн тэргүүнд авч үзэх шаардлагатай. Ингэхдээ компанийн чадавхыг 15%-иар, бизнесийн экосистемийг 10%-иас эхэлж өсгөх бодлого баримтлах нь зүйтэй юм. Үзүүлэлтүүдийн хэмжээг өсгөхдөө компанийн чадавхын хувьд Хүснэгт 33 (бизнесийн хэмжээгээр ангилах бол Хүснэгт 34), бизнесийн экосистемийн хувьд Хүснэгт 35-н тооцооллыг ашиглахыг зөвлөж байна.

Хүснэгт 36. Компани ба бизнесийн экосистемийн түвшинд сайжруулах шаардлагатай үндсэн үзүүлэлтүүд ба индикаторууд

Багана	Компанийн чадавх		Бизнесийн экосистем	
	Үндсэн үзүүлэлт	Индикатор	Үндсэн үзүүлэлт	Индикатор
Өрсөлдөх чадвар	Үйлдвэрлэлийн үр ашиг	Үйл ажиллагааны үр ашиг	Үйлдвэрлэлийн үр ашиг	Зам тээвэр, дэд бүтцийн хөгжил
		Зардлын үр ашиг		
	Нөөцийн менежмент		Нөөцийн менежмент	
	Чанарын удирдлага	Чанарын хяналт, стандарт	Чанарын удирдлага	Олон улсын гэрчилгээжүүлэлтийн талаар мэдээлэл авах боломж
Холбогдох чадвар	Хэрэглэгч	Мэдээллийн сувгууд	Хэрэглэгч	Хэрэглэгчдийн сонголт хийх боловсрол
		Хэрэглэгчийн мэдээллийн бүрдүүлэлт	Нийлүүлэгч	Ханган нийлүүлэгчид мэдээллээ солилцох байдал
	Нийлүүлэгч			Ханган нийлүүлэгчдийн хамтын ажиллагаа
	Институт	Гишүүнчлэл	Институт	Салбарын байгууллагуудын хамтын ажиллагааны орчин
Өөрчлөгдөх чадвар	Бизнес төлөвлөлт ба санхүү	Бизнес төлөвлөлт	Бизнес төлөвлөлт ба санхүү	
	Ур чадвар		Ур чадвар	Салбарын сургалтын байгууллагын хүртээмж, чанар
	Инновац	Инновац хөгжүүлэлт	Инновац	Мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах

Тэмдэглэгээ: Сайжруулах шаардлагагүй үндсэн үзүүлэлтүүдийг саарал өнгөөр тэмдэглэв.

8. ДҮГНЭЛТ

Энэ судалгаа нь МУ-ын ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг эдийн засгийн гурван түвшин болох микро (компанийн түвшин), мисо (бизнесийн экосистем), макро түвшинд тодорхойлоо. Тодруулбал, ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг үнэлээд зогсохгүй, ЖДБ үйл ажиллагаагаа тогтвортой явуулах, өрсөлдөх чадвараа бэхжүүлэхэд нь шаардагдах бизнесийн орчин болон зах зээлийн суурь нөхцөл хэр бүрдсэнийг тодорхойлж байгаагаараа онцлог юм. Өрсөлдөх чадварыг үнэлэхдээ ОУХТ-ийн ЖДБ-ийн өрсөлдөх чадварын матрицан аргачлалыг ашигласан бөгөөд өрсөлдөх чадвар, холбогдох чадвар, өөрчлөгдөх чадвар гэсэн гурван тулгуур хүчин зүйлээр тодорхойллоо. Судалгааны мэдээллийг анхдагч ба хоёрдогч эх үүсвэрээс цуглуулсан бөгөөд анхдагч мэдээллийг Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймагт үйл ажиллагаа явуулж буй 703 ЖДБ эрхлэгчдээс түүвэр судалгааны аргаар цуглууллаа. Судалгааны дүгнэлтийг ашиглаж буй аргатайгаа уялдуулан дараах хоёр түвшинд боловсруулав. Нэгдүгээрт, эдийн засгийн түвшин бүрээр өрсөлдөх чадавхын гурван баганын үр дүнг нэгтгэн дүгнэв. Хоёрдугаарт, өрсөлдөх чадварын багана бүрийн хувьд эдийн засгийн түвшнийг харьцуулж, үр дүнг нэгтгэн дүгнэв.

Эдийн засгийн түвшний тухайд

Компанийн чадавх. ЖДБ-ийн өрсөлдөх чадвар компанийн түвшинд өөрчлөгдөх чадварын оноо хамгийн өндөр буюу 53.3 оноо, өрсөлдөх чадварын оноо хоёр дахь өндөр буюу 49.7 оноо, холбогдох чадварын оноо хамгийн бага буюу 42.9 оноогоор үнэлэгдлээ. Өөрчлөгдөх болон өрсөлдөх чадварын оноо харьцуулах түвшин болох 44.2 онооноос өндөр гарсан ч хүчтэй түвшин болох 70.7 онооноос хол зөрүүтэй, доогуур байна. Харин холбогдох чадварын үнэлэгдсэн оноо харьцуулах түвшнээс ч бага гарчээ. Эндээс ЖДБ-ийн өрсөлдөх чадвар компанийн түвшинд дундаж хэмжээнд байгаа ба цаашид хүчтэй түвшинд хүргэхийн тулд нэлээд хүчин чармайлт гаргах шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрлээ.

Өрсөлдөх чадвар тухайд ЖДБ-үүдийн үйлдвэрлэлийн үр ашиг, нөөцийн менежментийн индикаторууд харьцуулах түвшнээс дээгүүр байгаа бол, чанарын удирдлагын индикатор харьцуулах түвшнээс сул түвшинд байна. Үйлдвэрлэлийн үр ашгийн индикаторыг үйл ажиллагааны, зардлын үр ашгийн индикатор харьцуулах түвшнээс дээгүүр бол, цаг хугацааны үр ашгийн индикатор харьцуулах түвшнээс хүчтэй түвшинд үнэлэгдсэн байна. ЖДБ-ийн үйл ажиллагааны үр ашигт байдалд хамгийн нөлөө үзүүлж хүчин зүйлс хөдөлмөрийн бүтээмжийн сул, ашигт ажиллагаа бага байдал нөлөө үзүүлж байна. Мөн ЖДБ-үүдэд зардлын үр ашиг төдийлөн хангалттай биш байна. ЖДБ-үүдийн олонх нь бараа, үйлчилгээгээ төлөвлөсөн цаг хугацаандаа үйлдвэрлэж, нийлүүлж байгаа боловч бичил бизнесийн гуравны нэг орчим нь хугацааны алдагдалтай ажиллаж байна. Харин нөөцийн менежментийн

түхайд гурван индикатор авч үзсэнээс банканд данс эзэмших байдал, мөнгөн хөрөнгийн удирдлага гэсэн хоёр индикатор харьцуулах түвшнээс дээгүүр, орлого, зарлагын бүртгэл хүчтэй түвшинд үнэлэгдсэн. ЖДБ-үүдийн олонх нь бизнесийн орлого, зарлагын бүртгэлээ байнга хийж байгаа боловч бичил бизнесийн орлого, зарлагын бүртгэлийг сайжруулах шаардлага байна. Мөн, чанарын удирдлагын өрсөлдөх чадварыг чанарын хяналт, стандарт гэсэн нэг индикатораар хэмжиж байгаа бөгөөд энэ нь харьцуулах түвшнээс үл ялиг дээгүүр үнэлэгдсэн. ЖДБ-ийн бараа, үйлчилгээний чанарын хяналт, баталгаажуулалтын стандарт хангалтгүй байна. Судалгаанд хамрагдсан ЖДБ-ийн 46.1% нь бараа, үйлчилгээнийхээ чанарт хяналт хийдэггүй байгаа нь чанар, стандартыг бууруулахад нөлөөлж байна. Өрсөлдөх чадварыг нийт долоон индикатораар хэмжсэн ба нэг индикатор харьцуулах түвшнээс сул, дөрвөн индикатор харьцуулах түвшнээс дээгүүр, хоёр индикатор харьцуулах түвшнээс хүчтэй түвшинд байна.

Холбогдох чадварын түхайд ЖДБ-үүдийн холбогдох чадвар хэр бэлэн байгааг хэрэглэгч, нийлүүлэгч, институт гэсэн 3 хүрээнд тодорхойлсон. Хэрэглэгчтэй холбогдох чадварыг гурван индикатораар авч үзсэнээс мэдээллийн сувгууд, хэрэглэгчийн мэдээлэл бүрдүүлэлт гэсэн индикаторууд харьцуулах түвшнээс сул түвшинд, борлуулалт, маркетингийн сувгийн индикатор харьцуулах түвшнээс дээгүүр үнэлэгдсэн. ЖДБ-ийн мэдээллийн гол суваг нь фэйсбүүк бөгөөд олонх нь нэг мэдээллийн сувгаар хэрэглэгчдэдээ мэдээллээ хүргэж байна. ЖДБ-ийн гуравны нэг гаруй (35.6%) нь хэрэглэгчээ татах, байнгын хэрэглэгчээ халамжлах, хэрэглэгчтэйгээ харилцах тогтолцоог бий болгоогүй байна. ЖДБ-ийн борлуулалт, маркетингаа голдуу сошиал хуудсаараа хийдэг бөгөөд талаас дээш хувь нь нэгээс дээш сувгаар борлуулалт, маркетингаа хийж байна. Ханган нийлүүлэгчтэй холбогдох чадвар нь хоёр индикатор авч үзсэнээс ханган нийлүүлэгчийн харилцаа индикатор харьцуулах түвшнээс дээгүүр түвшинд байгаа бол, ханган нийлүүлэгчийн гүйцэтгэлийн үнэлгээ индикатор доогуур түвшинд үнэлэгдсэн. ЖДБ-ийн ханган нийлүүлэгчтэй албан ёсны гэрээнд суурилсан найдвартай харилцаа үүсгэж байгаа байдал хангалтгүй байна. ЖДБ-ийн тогтмол нэг, эсвэл цөөн тооны ханган нийлүүлэгчтэй харилцах байдал хангалтгүй хэвээр буюу түхэйн нөхцөл байдлаас хамаарах, ханган нийлүүлэгчээ байнга солих, тогтмол ханган нийлүүлэгч байхгүй байх тохиолдол (46.3) байна. ЖДБ-ийн хувьд ханган нийлүүлэгчдээ улирал, хагас жил, жилийн эцэст үнэлдэг байдал сайн (67.5%) байна. Институтүүдтэй холбогдох чадварыг хоёр индикатор авч үзсэнээс гишүүнчлэлийн индикатор харьцуулах түвшнээс сул түвшинд үнэлэгдсэн бол, гишүүнчлэлийн үнэлгээ доогуур түвшинд үнэлэгдсэн. ЖДБ-үүд холбогдох байгууллагуудад гишүүнчлэлтэй байдал хангалтгүй байна. ЖДБ-үүд гишүүнчлэл бүхий байгууллагынхаа үйл ажиллагаанд сэтгэл ханамжгүй буюу гишүүнчлэлээс хүртэх өгөөжийг хангалтгүй хэмээн тодорхойлж байна. Холбогдох чадварыг нийт долоон индикатораар хэмжсэн ба гурван индикатор харьцуулах түвшнээс сул, дөрвөн индикатор нь харьцуулах түвшнээс дээгүүр түвшинд байна. Харин дунд хэмжээтэй бизнесүүд ихэнх индикаторын хувьд дээгүүр түвшинд үнэлэгджээ.

Өөрчлөгдөх чадварын тухайд ЖДБ-үүдийн өөрчлөлтийг даван туулах, дасан зохицох, шинэчлэл хийх суурь чадвар бүхэлдээ дундаж түвшинд байна. Гэсэн ч энэхүү чадварт тухайлсан индикатор, бизнесийн шинж байдлаас хамаарч мэдэгдэхүйц зөрүү ажиглагдаж байна. Бизнес төлөвлөгөө боловсруулах, инновац хөгжүүлэх гэсэн хоёр индикаторын хувьд бизнесийн шинж байдлаас үл хамааран бүхий л бизнес доогуур түвшинд үнэлэгджээ. Харин олонх ЖДБ-үүд эрсдэл багатай эх үүсвэрээс зайлшгүй шаардлагатай санхүүгийн хэрэгцээгээ хангах чадвар нэмэгдсэн нь харагдаж байна. Түүнчлэн ур чадвартай хүний нөөцөө бүрдүүлэх, инновац ашиглах чадвар нь харьцуулах түвшнээс дээгүүр байна. Бичил, худалдааны салбарын, орон нутгийн, эмэгтэй удирдлагатай бизнесүүд ихэнх индикаторын хувьд доогуур үнэлэгдэж байгаа нь тэдний хувьд аливаа өөрчлөлтийг даван туулах, өсөн дэвжихэд нь хүндрэл байгааг илтгэж байна. Харин дунд бизнес ихэнх индикаторын хувьд хүчтэй түвшинд үнэлэгджээ. Тодруулбал, тэд санхүүгээ хүртээмжтэйгээр зохицуулж, хүн капитал, инновацыг хөгжүүлэхэд хүчин чармайлт гаргаж, улмаар өөрчлөлтийг даван туулах, шинэчлэл хийх чадавх суусныг илтгэж байна.

Бизнесийн экосистем. ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг дэмжих бизнесийн экосистемийн хувьд өөрчлөгдөх чадварын оноо хамгийн өндөр буюу 57.0 оноо, өрсөлдөх чадварын оноо хоёр дахь өндөр буюу 56.6 оноо, холбогдох чадварын оноо хамгийн бага буюу 42.9 оноогоор үнэлэгдлээ. Өөрчлөгдөх болон өрсөлдөх чадварын экосистемийн оноо харьцуулах түвшин болох 44.2 онооноос өндөр гарсан хэдий ч хүчтэй түвшин болох 70.7 онооноос хол зөрүүтэй, доогуур байна. Харин холбогдох чадварын экосистемийн үнэлэгдсэн оноо харьцуулах түвшнээс ч бага гарчээ. Эндээс ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг дэмжих бизнесийн экосистем дундаж түвшинд бүрдсэн ба цаашид хүчтэй түвшинд хүргэхийн тулд их хүчин чармайлт гаргах шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрлээ.

ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг дэмжих экосистемийн хувьд нөөцийн менежмент, зохион байгуулалт хийх орчин харьцангуй сайн бүрдсэн бол үйлдвэрлэлийн үр ашгийг дэмжих, чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх экосистем сул хөгжжээ. Салбар дахь хувийн хэвшлийн байгууллагуудын албан хэлцлийн хэрэгжилт харьцангуй өндөр үнэлгээтэй байгаа нь ЖДБ-ийн үйлдвэрлэлийн үр ашгийн оноог дээш татсан бол зам тээвэр, дэд бүтцийн хөгжил муу, эрчим хүчний хүртээмж, найдвартай байдал тааруу, хөдөлмөрийн зах зээлийн хөгжил доогуур оноогоор үнэлэгдсэн нь бизнесийн байгууллагын үйлдвэрлэлийн үр ашгийг бууруулдаг, системийн хүчин зүйл болсон байна. Дотоодын болон олон улсын чанарын хяналт, баталгаажуулалтыг хэрхэн хийх, гэрчилгээжүүлэлтийг хэрхэн авах талаар мэдээлэл хомс байгаа нь ЖДБ-үүд бүтээгдэхүүний чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх боломжийг хязгаарлаж, өрсөлдөх чадварыг бууруулдаг мисо орчны хүчин зүйл болжээ.

ЖДБ худалдан авагч, ханган нийлүүлэгч, салбарын байгууллагууд, мэргэжлийн холбоодтой холбогдох чадварыг дэмжих экосистем хамгийн муу бүрдсэн байна. Ялангуяа, ЖДБ-үүд худалдан авагчтайгаа холбогдох системийн хөгжил тааруу байна.

Үүнд нөлөөлж буй гол хүчин зүйл нь худалдан авагчид бүтээгдэхүүнийг таних, сонголт хийх боловсрол тааруу явдал юм. Түүнчлэн, ханган нийлүүлэгчидтэйгээ мэдээлэл солилцох, хамтран ажиллах тогтолцооны хөгжил сул, мэргэжлийн холбоод, салбарын байгууллагууд хамтран ажиллах, үйл ажиллагаагаа үялдуулах орчин, нөхцөл муу хөгжсөн нь ЖДБ-ийн холбогдох чадварын хөгжилд сөргөөр нөлөөлж байна.

ЖДБ-ийн өөрчлөгдөх чадварыг дэмжих экосистемийн хувьд ААН-үүд санхүүжилт олох боломж, хүртээмжийн оноо хамгийн өндөр, хүчтэй түвшинд үнэлэгдсэн бол инновацын төлөөх мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагаа муу, патент, лиценз, зөвшөөрлийн зардал өндөр, үр чадвар сайтай ажиллах хүчийг сургах, бэлтгэх сургалтын байгууллагын хүртээмж, чанарын үзүүлэлтүүд харьцангуй бага оноотой үнэлэгджээ. Харин үр чадвар сайтай ажиллах хүчний хүрэлцээ, хүртээмж, бизнес эрхлэх лиценз, зөвшөөрлийн үзүүлэлтүүд дундаж түвшинд үнэлэгдсэн хэдий ч сайжруулах шаардлагатай. Өөрчлөгдөх чадварыг дэмжих өнөөгийн экосистемийг хөгжүүлэх нь ирээдүйд ЖДБ-үүдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх суурь хүчин зүйл болно. Тиймээс инновацын төлөөх мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулж, шинэ санаа, шинэ технологийг дэмжих, патент, лиценз, зөвшөөрлийн зардлыг бууруулах, сургалтын байгууллагуудын хүртээмж, чанарыг сайжруулах замаар ирээдүйд ЖДБ-үүд өрсөлдөх, холбогдох, өөрчлөгдөх чадвараа хөгжүүлэх суурь экосистемийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Макро орчин. Макро орчны гурван багана болох өрсөлдөх, холбогдох, өөрчлөгдөх чадварууд харгалзан 39.2, 57.1, 77.4 гэж үнэлэгдсэнээс харвал ЖДБ-үүдийн өрсөлдөх чадварыг өөрчлөгдөх чадвар хамгийн өндөр оноотойгоор хүчтэй түвшинд дэмжиж байна. Харин хамгийн бага оноотой өрсөлдөх чадварын хувьд уг баганын үнэлгээг хойш татаж байгаа хамгийн бага утгатай логистик гүйцэтгэлийн индекс, ISO 9001 чанарын гэрчилгээ, ISO 14001 хүрээлэн буй орчны гэрчилгээ гэсэн гурван индикаторын утгыг сайжруулахад илүү хүчин чармайлт гаргах шаардлагатай. Түүнчлэн, уг баганад хүчтэй үнэлэгдэх индикатор байхгүй байгаа учраас бусад индикаторын хувьд ч мөн сайжруулах хэрэгтэй. Харьцуулах түвшнээс дээгүүр үнэлэгдэж байгаа холбогдох чадвар баганын хамгийн бага оноотой өрхийн МХТ-ийг ашиглах боломжийг сайжруулах тал дээр бодлогын түвшинд нэлээд хүч хаях шаардлагатай нь харагдаж байна. Харьцуулах түвшнээс дээгүүр үнэлэгдэж байгаа бусад дөрвөн индикаторын хүртээмжтэй интернэтийн индекс, засгийн газрын онлайн үйлчилгээ гэсэн хоёр индикаторын тухайд манай улс сүүлийн хоёр жилд нэлээд ахиц дэвшил гарсан нь харьцуулалтаас харагдаж байна. Өөрчлөгдөх чадварын баганын хамгийн бага үнэлгээтэй индикатор болох патентын өргөдлийн тоо нь нэг талаас тухайн улсын шинэ санаа, санаачилга, цаашилбал, инновац хэр түвшинд явагдаж байгаа ерөнхий дүр зургийг харуулах тул уг индикаторын онооны өсөлт тухайн улсын бизнесийн салбарт хэр чухал вэ гэдэг нь ойлгомжтой.

Өрсөлдөх чадварын баганын тухайд

Өрсөлдөх чадвар. Үйлдвэрлэлийн үр ашиг, нөөцийн менежмент, чанарын удирдлага гэсэн гурван гол үзүүлэлт дээр төвлөрч, ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг компанийн түвшний болон бизнесийн экосистем, макро орчны индикаторуудтай харьцуулж, уялдаа холбоог үнэллээ. Компанийн болон бизнесийн экосистемийн хүрээнд ЖДБ-ийн өрсөлдөх чадвар дундаж түвшинд үнэлэгдсэн хэдий ч хүчтэй түвшинд хүрээгүй тул сайжруулах шаардлагатай. Харин макро орчны индикаторууд харьцуулах түвшнээс ч доогуур үнэлэгдсэн. Энэ нь ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг дэмжих мисо, макро орчин хангалттай бүрдээгүй болохыг нотолж байна.

ЖДБ-ийн өрсөлдөх чадварт эергээр нөлөөлсөн гол үзүүлэлтүүд нь цаг хугацааны үр ашиг, орлого, зардлын бүртгэл хөтлөлт, мөнгөн хөрөнгийн удирдлага байсан бол сөргөөр нөлөөлж буй гол хүчин зүйлс нь үйл ажиллагааны үр ашиг муу, зардлын үр ашиг бага, чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлээгүй явдал байв. ЖДБ эрхлэгчид үйлдвэрлэлд шинэ технологи, тоног төхөөрөмж нэвтрүүлэх, хөрөнгө санхүү зарцуулах, чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх, менежмент зохион байгуулалтаа сайжруулах замаар өрсөлдөх чадвараа өсгөх боломжтой. Харин ЖДБ-ийг дэмждэг, зохицуулдаг төрийн, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагууд ЖДБ-ийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх бизнесийн экосистем, макро орчныг бүрдүүлэх, хөгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, бүтээгдэхүүний чанарт дотоод, гадаадын стандарт тогтоох, мөрдүүлэх, хянах, тохирлын гэрчилгээ олгох, мэдээ, мэдээллээр хангах, тээвэр логистик, дэд бүтцийн хөгжлийг хурдасгах, эрчим хүчний хүртээмж, найдвартай байдлыг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн болон үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн зах зээлийг хөгжүүлэх хууль, эрх зүйн таатай нөхцөлийг бүрдүүлэх, татвар, тарифын оновчтой бодлого явуулж, бичил, жижиг бизнесийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Түүнчлэн, ЖДБ-үүд төрийн үйлчилгээг илүү хялбар, шуурхай, төвөг, чирэгдэлгүй авах боломжийг бүрдүүлэх, оролцогч талуудын үйл ажиллагааг уялдуулах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, засаглалын чанарыг нэмэгдүүлэх чухал байна.

Холбогдох чадвар. Хэрэглэгч, ханган нийлүүлэгч, институт гэсэн холбогдох чадварын гурван гол үзүүлэлт дээр төвлөрч, эдийн засгийн түвшний уялдаа холбоог авч үзлээ. ЖДБ-ийн хувьд борлуулалт, маркетингийн сувгуудад анхаарал хандуулж олон төрлийн сувгаар дамжуулан борлуулалт, маркетингаа явуулж байгаа боловч, хэрэглэгч тал руу чиглэсэн мэдээллийн урсгал хангалтгүй байна. Бизнесийн эко систем болон макро орчны хувьд хэрэглэгчтэйгээ холбогдох боломж өндөр байгаа боловч, компанийн хувьд хэрэглэгчдэд зориулсан мэдээлэлд анхаарал хандуулахгүй байна. ЖДБ-ийн хувьд ханган нийлүүлэлтийн сүлжээний суурь бүрдэж эхэлж байгаа хэдий ч, цаашид ханган нийлүүлэгчдийн мэдээлэл солилцох байдал, хамтын ажиллагааг сайжруулах хэрэгцээ байна. Харин салбарын хувьд ханган нийлүүлэгчдийн мэдээлэл, ханган нийлүүлэгчдээс санал боломжуудыг нэгтгэсэн платформыг ЖДБ-үүд санал болгох, идэвхжүүлэх хэрэгцээ байна. ЖДБ-ийн хувьд гишүүнчлэл бүхий салбарын

холбоод, бусад худалдаа, хамтын ажиллагаа бүхий байгууллагуудын үйл ажиллагааг хангалтгүй, хамтын ажиллагаа дутмаг хэмээн үнэлж байна. Компанийн түвшинд гишүүнчлэл, хамтын ажиллагаанд ач холбогдол өгч байгаа боловч, гишүүнчлэлээс өгөөж хүртэх байдал хангалтгүй байна.

Өөрчлөгдөх чадвар. Санхүү, ур чадвартай хүний нөөц, инновац хөгжүүлэлт гэсэн өөрчлөгдөх чадварын гурван гол үзүүлэлтэд төвлөрч, эдийн засгийн түвшний уялдаа холбоог авч үзлээ. ЖДБ-ийн санхүүжилтэд хүрэх боломж компани, бизнес ба макро орчны түвшинд мэдэгдэхүйц сайжирсан дүр зураг ажиглагдаж байна. Олонх ЖДБ эрсдэл багатай эх үүсвэрээс санхүүгийн хэрэгцээгээ хангах чадвартай болсон, бизнесийн орчинд санхүүгийн хүртээмж сайжирсан, хүүгийн зөрүү буурч санхүүгийн зах зээлийн зуучлалын үр ашиг нэмэгдсэн байна. Иймд санхүүжилтэд хүрэх боломжийн хувьд гаргасан амжилтыг цааш тогтвортой үргэлжлүүлэх нь чухал юм. Компанийн түвшинд ур чадвартай хүний нөөц тодорхой түвшинд бүрдсэн ч тэдгээрийг чадавхжуулах, тасралтгүй сургахад компанийн зүгээс хүчин чармайлт гаргах шаардлагатай байна. Харин салбарын хувьд ур чадвартай мэргэшсэн ажилчны хүрэлцээг нэмэгдүүлэх, гол сургалтын байгууллагуудын хүртээмж, чанарыг дээшлүүлэхэд анхаарах хэрэгтэй байна. Компанийн түвшинд инновац хөгжүүлэлтэд тодорхой хүчин чармайлт гаргаж байгаа ч бодит үр дүнд төдийлөн хүрээгүй, эсвэл үр дүнгээ албажуулах явдал хангалтгүй байна. Түүнчлэн бизнесийн орчны хувьд инновацыг хөгжүүлэхэд мэргэжлийн болон бизнесийн байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа төдийлөн бүрдээгүй байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Acs, Z. J., Rappai, G., & Szerb, L. (2011). Index-Building in a System of Interdependent Variables: The Penalty for Bottleneck. *GMU School of Public Policy Research Paper, No.2011-24*.

ADB, IRIM. (2021). *Улаанбаатар хотын гэр хорооллын бүсийн жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих нь” төслийн хэрэгцээ тодорхойлох судалгаа*. УБ.

ITC. (2015). *SME Competitiveness Outlook 2015: Compete, Connect and Change for Inclusive Growth*.

ITC. (2021a). *2021 SME Competitiveness Country Profiles: Technical Annexes*.

ITC. (2021b). *SME Competitiveness Outlook 2021: Empowering the Green Recovery*.

MEARC. (2021). *Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадварын судалгаа*. Улаанбаатар.

UNESCAP. (2009). *Policy guidebook for SME development in Asia and the Pacific*.

Байгаль орчин, хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэн. (2023). *Хөдөө аж ахуйн суурь судалгаа*.

Монгол банк. (2018). *Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал*. Улаанбаатар.

Монгол Улсын Засгийн Газар. (2021). *"Шинэ сэргэлтийн бодлого" үндэслэл, судалгаа*. Улаанбаатар.

ҮСХ. (2021). *Эдийн засгийн хөгжилд жижиг, дунд үйлдвэрлэлийн оруулж буй хувь нэмэр*. Улаанбаатар.

ҮСХ. (2023 оны 1-р улирал). *Бизнес регистрийн сан*.

ХАВСРАЛТУУД

Хавсралт 1 - ЖДБ-ийн өрсөлдөх чадварын матрицын индикаторууд

Багана	Үндсэн үзүүлэлт	Компанийн чадавх	Бизнесийн эко систем	Макро орчин
Өрсөлдөх чадварын багана	Үйлдвэрлэлийн үр ашиг <ul style="list-style-type: none"> Хүчин чадлын ашиглалт Ашигт ажиллагаа Хөдөлмөрийн бүтээмж (борлуулалтын орлого / ажилчдын тоо) Зардлын үр ашиг: <ul style="list-style-type: none"> Нэгж хөдөлмөрийн зардлын үр ашиг Бараа, материалын зардлын үр ашиг Цаг хугацааны үр ашиг: <ul style="list-style-type: none"> Үйлдвэрлэлийн төлөвлөгөөний цаг хугацаандаа биелсэн байдал Бүтээгдэхүүн, үйлчилгээг цаг хугацаандаа нийлүүлсэн байдал 	Үйл ажиллагааны үр ашиг: <ul style="list-style-type: none"> Хүчин чадлын ашиглалт Ашигт ажиллагаа Хөдөлмөрийн бүтээмж (борлуулалтын орлого / ажилчдын тоо) Зардлын үр ашиг: <ul style="list-style-type: none"> Нэгж хөдөлмөрийн зардлын үр ашиг Бараа, материалын зардлын үр ашиг Цаг хугацааны үр ашиг: <ul style="list-style-type: none"> Үйлдвэрлэлийн төлөвлөгөөний цаг хугацаандаа биелсэн байдал Бүтээгдэхүүн, үйлчилгээг цаг хугацаандаа нийлүүлсэн байдал 	<ul style="list-style-type: none"> Эрчим хүчний найдвартай байдал Зам тээвэр, дэд бүтцийн хөгжил Хөдөлмөрийн зах зээлийн хөгжил Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагууд, зохицуулалт хийдэг бусад байгууллага Зах зээлийн хөгжил, албан хэлцлийн хэрэгжилт 	<ul style="list-style-type: none"> Үйлчилж буй тариф Техникийн зохицуулалтын тоо Онцгой тариф Засаглалын индекс
	Нөөцийн менежмент <ul style="list-style-type: none"> Орлого, зарлагын бүртгэл Банканд данс эзэмших байдал Мөнгөн хөрөнгөний удирдлага 	<ul style="list-style-type: none"> Дотоодын тээврийн найдвартай байдал Гаалийн бүрдүүлэлтийн үр ашиг 	<ul style="list-style-type: none"> Дотоодын тохирлын гэрчилгээний талаар мэдээлэл авах боломж Олон улсын гэрчилгээжүүлэлтийн талаар дотоодоос мэдээлэл авах боломж 	<ul style="list-style-type: none"> Логистик гүйцэтгэлийн индекс ISO 9001 чанарын гэрчилгээ ISO 14001 хүрээлэн буй орчны гэрчилгээ
Чанарын удирдлага	Чанарын хяналт, стандарт: <ul style="list-style-type: none"> Байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарын хяналт (Үндэсний түвшний болон олон улсын түвшний чанарын гэрчилгээжүүлэлт) 			

Холбогдох чадварын багана	Хэрэглэгч	<p>Мэдээллийн сүвгүүд</p> <ul style="list-style-type: none"> • Байгууллагын ашиглаж байгаа харилцаа, мэдээллийн сүвгүүд <p>Хэрэглэгчийн мэдээлэл бүрдүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> • Хэрэглэгчийн мэдээллийг бүртгэх, хянах тогтолцоотой эсэх <p>Борлуулалт, маркетингийн сүвгүүд</p> <ul style="list-style-type: none"> • Борлуулалтын сүвгүүд • Маркетинг/Сурталчилгааны сүвгүүд 	<ul style="list-style-type: none"> • Хэрэглэгчдийн чухалчилдаг хүчин зүйлс • Хэрэглэгчтэйгээ холбоо тогтоох хүндрэлийн түвшин 	<ul style="list-style-type: none"> • Өрхийн МХТ-ийг ашиглах боломж • Телефон хэрэглэгчийн тоо • Интернет хэрэглэгчийн тоо
Холбогдох чадварын багана	Нийлүүлэгч	<p>Ханган нийлүүлэгчийн харилцаа</p> <ul style="list-style-type: none"> • Ханган нийлүүлэгчтэй гэрээтэй эсэх • Тогтмол эсвэл тогтмол бус ханган нийлүүлэгчтэй эсэх <p>Ханган нийлүүлэгчийн гүйцэтгэлийн үнэлгээ</p> <ul style="list-style-type: none"> • Ханган нийлүүлэгчийн гүйцэтгэлийг үнэлдэг эсэх 	<ul style="list-style-type: none"> • Ханган нийлүүлэгчийн нээлттэй мэдээлэл • Ханган нийлүүлэгчийн хамтын ажиллагааны үнэлгээ • Ханган нийлүүлэгчийн үнэлгээний тогтолцоо 	<ul style="list-style-type: none"> • Хүртээмжтэй интернетийн индекс
	Институт	<p>Гишүүнчлэл</p> <ul style="list-style-type: none"> • Гишүүнчлэлтэй эсэх <p>Гишүүнчлэлийн үнэлгээ</p> <ul style="list-style-type: none"> • Гишүүнчлэл бүхий байгууллагаас үр шим хүртэж буй байдлын үнэлгээ 	<ul style="list-style-type: none"> • Салбарын холбоод, ХАУТ, бусад худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих байгууллагуудын хамтын ажиллагааны орчин 	<ul style="list-style-type: none"> • Засгийн газрын онлайн үйлчилгээ

Өөрчлөгдөх чадварын батана			
Бизнес төлөвлөлт ба санхүү	Бизнесийн төлөвлөлт <ul style="list-style-type: none"> • Бизнес төлөвлөгөө боловсруулах түвшин Санхүүгийн эх үүсвэр <ul style="list-style-type: none"> • Санхүүгийн боломжит эх үүсвэр Санхүүгийн тайлагналт ба баталгаажуулалт <ul style="list-style-type: none"> • Санхүүгийн тайлагналт • Санхүүгийн тайлангийн баталгаажуулалт 	<ul style="list-style-type: none"> • Санхүүгийн хүртээмжтэй байдал • Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийн асуудал саад учруулж буй эсэх 	<ul style="list-style-type: none"> • Хүүгийн түвшний зөрүү
Ур чадвар	Ур чадвартай хүний нөөц <ul style="list-style-type: none"> • Ур чадвартай хүний нөөцтэй эсэх • Менежерийн туршлага Ур чадвартай хүний нөөцийг бүрдүүлэх <ul style="list-style-type: none"> • Ажилтны сонгон шалгаруулалт • Ажилчдын сургалтын хөтөлбөр 	<ul style="list-style-type: none"> • Салбар дахь ур чадвартай ажиллах хүчний хүрэлцээ • Салбар дахь ур чадвартай ажиллах хүчний хүртээмжийн асуудал саад учруулж буй эсэх • Салбарын гол ур чадвар олгодог сургалтын байгууллагын хүртээмж, чанар 	<ul style="list-style-type: none"> • Суралцсан жил
Инновац	Инновац ашиглалт <ul style="list-style-type: none"> • Лицензтэй программ хангамж, технологийн ашиглалт Инновац хөгжүүлэлт <ul style="list-style-type: none"> • Оюуны өмч, патенттай эсэх • Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээнд (инновац) гаргаж буй хүчин чармайлт 	<ul style="list-style-type: none"> • Бизнес эрхлэх лиценз, зөвшөөрөл • Патент, лиценз, зөвшөөрлийн зардал • Инновац хөгжүүлэлтэд мэргэжлийн байгууллагатай хамтран ажилладаг байдал 	<ul style="list-style-type: none"> • Патентын өргөдлийн тоо • Барааны тэмдэгтийн бүртгэл

Хавсралт 2- Макро орчин: Өгөгдлийн эх сурвалж

Өрсөлдөх чадвар	Өгөгдлийн эх сурвалж
Үйлчилж буй тариф	Calculations based on ITC Market Analysis Tools data, 2015-2021
Техникийн зохицуулалтын тоо	-
Онцгой тариф	Calculations based on ITC Market Analysis Tools data, 2020
Логистик гүйцэтгэлийн индекс	World Bank and Turku School of Economics, Logistics Performance Index, 20123
ISO 9001 чанарын гэрчилгээ	ISO Survey of Management System Standard Certifications, 2022
ISO 14001 хүрээлэн буй орчны гэрчилгээ	ISO Survey of Management System Standard Certifications, 2022
Засаглалын индекс	World Bank Worldwide Governance Indicators, 2022
Холбогдох чадвар	Өгөгдлийн эх сурвалж
Өрхийн МХТ-ийн хүртээмж	ITU World Telecommunication/ICT Indicators Database, 2017-2020
Телефон хэрэглэгчийн тоо	ITU World Telecommunication/ICT Indicators Database, 2016-2019
Интернэтийн хэрэглэгчийн тоо	ITU World Telecommunication/ICT Indicators Database, 2017-2019
Хүртээмжтэй интернэтийн индекс	EIU The Inclusive Internet Index and Facebook Value of the Internet Survey, 2022
Засгийн газрын онлайн үйлчилгээ	UNPAN e-Government Survey, 2022
Өөрчлөгдөх чадвар	Өгөгдлийн эх сурвалж
Хүүгийн түвшний зөрүү	World Bank, based on IMF data, international financial statistics and data files, 2022
Суралцсан жил	UNESCO Institute for Statistics, 2015–2020
Патентын өргөдлийн тоо	WIPO, 2015–2019
Барааны тэмдэгтийн бүртгэл	WIPO, 2015–2019

ISBN 991902241-1



9 789919 022419